

Өмнөх үг

Монгол Улсын нийгэм-эдийн засгийн шинэ нөхцөлд газрын харилцааны эрх зүйн орчны шинэтгэлийн хүрээнд гарсан Газрын тухай багц хуулиудаар газрын харилцааны зохицуулалт улам бүр боловсронгуй болж газрын үр өгөөжийг зөвхөн ашиглах бус, хамгаалах, нөхөн сэргээх, газрын харилцаанд оролцогчдод тэгш шударга байдлыг хангасан эрх, үүргийн харьцааг тэнцвэржүүлэх төрийн бодлогыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдсэн юм.

Газар нь байгаль, дэлхийн үүсэл хөгжлийн дүнд бий болсон сав шимийн ертөнц учраас түүний ашиглалтын цар хүрээ өөрийнх нь унаган чадавхиар тодорхойлогддог. Ийм практик Монгол Улсад нилээд шинэлэг асуудал боловч дэлхий нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн тогтвортой хөгжлийн үндэс болжээ. Үүний үзэл баримтлал нь газар болоод газраас үндэстэй байгалийн баялгийг зөв зохистой ашиглан нийгэм-эдийн засгаа хөгжүүлэх зарчимд тулгуурласан байдаг ба монгол оронд хэрэгжүүлэх үндсэн механизм нь улс, аймаг, нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тулгуурласан хөгжлийн бодлого юм.

Төв аймгийн хөгжлийн өнөөгийн ба хэтийн чиглэлийг улс, бүс нутаг, аймгийн эдийн засаг, нийгмийн хөгжлийн бодлоготой уялдуулан оновчтой тодорхойлж, түүнийг хэрэгжилтийг газар ашиглалтын зохистой бодлогоор дэмжин газрын харилцааны тогтвортой байдлыг хангах, газар зохион байгуулалтын цогц арга хэмжээг иж бүрнээр хэрэгжүүлэх, газрын сангийн удирдлагын тогтолцоог зөв бүрдүүлэх, газрыг экологийн сөрөг үр дагавруудаас урьдчилан хамгаалах, доройтсон газруудыг нөхөн сэргээх, газар нутгийг цаг хугацаа, орон зайн хувьд оновчтой төлөвлөхөд энэхүү ерөнхий төлөвлөгөөний зорилго оршиж байна.

Монгол Улсын Газрын Хуулийн хүрээнд газар зохион байгуулалтыг газрын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, газрын кадастр эрхлэх, газрыг үр ашигтай, зохистой ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх, газрын эдийн засгийн чадавхи, нөөцийг нэмэгдүүлэх, газарзүйн болон газрын харилцааны таатай орчин бүрдүүлэх зорилготой цогцолбор арга хэмжээ гэж тодорхойлсон бөгөөд хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Төв аймгийн Засаг Даргын захиалгаар аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг газрын судалгааны мэргэжлийн байгууллага “Газар сервис” ХХК 2005 онд хийж гүйцэтгэв. Газар зохион байгуулалтын судалга шинжилгээ боловсруулалтын ажлыг тус компаний зөвлөх мэргэжилтэн төслийн удирдагч Ц.Бадам, газар зохион байгуулагч инженер Д.Мөнхцэцэг, Л.Уранбилэг, У.Өнөржаргал, хөрс судлагч Б.Мөнхбат, бэлчээр судлаач П.Мягмарцэрэн, геоморфологич-хот суурингийн экологич доктор Ч.Батсайхан, цаг уурын инженер М.Баясгалан, туслах ажилтан Ш.Ариунаа, Лхагвасүрэн, С.Эрдэнэцогт нарын бүрэлдэхүүнтэйгээр хийж, төслийн зөвлөхөөр М. Мэндбилэг ажиллав. Мөн судалгаа боловсруулалтын ажилд Төв аймгийн газрын албаны удирдлага, мэргэжлийн хүмүүс идэвхи санаачлагатай оролцсноос яамдын бодлогыг тодорхойлон өгч үнэтэй мэдээллээр хангасан явдалд гүйцэтгэгчийн зүгээс гүн талархал илэрхийлье.

НЭГ. ЕРӨНХИЙ ХЭСЭГ

1.1. Онол - аргазүйн үндэслэл

Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө нь газарзүйн болон менежментийн шинжлэх ухааны онолын үндэслэл, нийгэм эдийн засгийн хөгжлийн дүн шинжилгээнд суурилагдсан бөгөөд Төв аймгийн байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцлийн ерөнхий үнэлгээг доорхи суурь судалгаан тулгуурлан хийлээ. Үүнд:

- Уур амьсгал
- Хөрсөн бүрхэвч
- Ургамлан нөмрөг
- Усзүй
- Орчны бохирдол
- Нийгэм-эдийн засгийн хүчин зүйлсийн судалгаа
- Газар ашиглалтын одоогийн байдлын судалгаа

Байгаль-нутаг дэвсгэрийн үнэлгээ болон газар зохион байгуулалтын төлөвлөлтөнд газарзүйн мэдээллийн системийн ArcGis, ArcView 3.2 , Arc INFO 3.5, имиж боловсруулалтын ERDAS 8.4 болон зураглалын AutoCadmap 2000 зэрэг орчин үеийн дэвшилтэт программуудыг ашиглаж орон зайн хувьд дэлхийн координатын нэгдсэн сүлжээнд байршуулан зурган мэдээллийг тоон хэлбэрт шилжүүлснээрээ онцлог бөгөөд энэ газрын харилцааны өнөөгийн шаардлагыг бүрэн хангаж байгаа болно.

Тус аймгийн суурь судалгаа болон төлөвлөлтийн судалгааг дунд масштабын буюу 1:100000 масштабын нарийвчлалаар хийж гүйцэтгэсэн бөгөөд хэвлэлтэнд тохиромжтой байх үүднээс төлөвлөлтийн эцсийн зургийг 1: 200 000 масштабаар хэвлэв.

Аймгийн нийгэм-эдийн засгийн нөхцлийн судалгаанд SWOT харьцуулалт-шинжилгээний аргыг ашиглан хөгжлийн давуутай болон сул тал, боломжийг гаргаж, эдийн засгийн хөгжлийн үзүүлэлтийг төлөвлөлтийн үе шатуудаар тодорхойллоо.

Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний төлөвлөлтийн зарчим нь байгаль нутаг дэвсгэрийн нөхцөл, нөөцөд тулгуурласан газрын менежментийн бодлогын бүсүүдийг тодорхойлж бүс тус бүрийн ашиглалтын горимыг илрүүлэх, газрын нэгдмэл сангийн шилжилт, үүнээс гарах экологи-эдийн засгийн үр ашгийг тооцоход чиглэгдсэн болно.

1.2. Хууль эрхзүйн үндэслэл

Монгол улсын газрын багц хууль, Хот байгуулалтын тухай хууль, аймгийн Засаг даргын мөрийн хөтөлбөр, Монгол Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, Бүсчилсэн хөгжлийн тухай хууль, бүс нутгийн хөгжлийн үзэл баримтлал, дунд хугацааны хөтөлбөр болон төлөвлөлтийн стандарт нормчлол зэрэг болно.

ХОЁР: АЙМГИЙН БАЙГАЛЬ-НУТАГ ДЭВСГЭРИЙН ЦОГЦОЛБОРЫН НӨХЦӨЛ , НӨӨЦИЙН ҮНЭЛГЭЭ

Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний төлөвлөлтийн үндэс нь тухайн газар нутгийн байгалийн нөхцөл, нөөцөд чадавхийн үнэлгээ өгч түүнд зохицсон экологийн хохиролгүй, эдийн засгийн хувьд ашигтай газар ашиглалтын хувилбарыг илрүүлэн төлөвлөх асуудал юм.

Төв аймаг нь 7404.2 мян.га нутагтай, нутгийн ихэнх хэсэг нь далайн түвшнээс дээш 1000-1300 метр, зүүн хойд хэсэг нь далайн түвшнээс дээш 1500-2500 метр өндөрт өргөгдсөн Тосон, Заамар, Зоргол хайрхан зэрэг уул нурууд Хэрлэн, Туул, Захар, Хүйн голын сав газараар тусгаарлагдсан бол нутгийн өмнөд хэсэгт цав толгодот өргөн хөндий үргэлжлэнэ. Нутаг дэвсгэрийн энэхүү ялгаа нь ландшафтын өвөрмөгц ялгарлыг бүрүллсэн байна.

2.1. Уур амьсгал

Төв аймгийн нутаг дэвсгэр уур амьсгалын хувьд **чийглэг хүйтэн, чийглэгдүү хүйтэвтэр, хуурайдуу хүйтэвтэр, хуурай дулаан** гэсэн 4 мужид хуваагдана. **Чийглэг хүйтэн муж нь** чийгийн хүрэлцээ ерөнхийдөө сайн боловч дулаан их дутагдалтай, эрт хүйтэрч, орой дулаардаг ба аймгийн зүүн хойт хэсэг хамрагдана. **Чийглэгдүү хүйтэвтэр мужид** Мөнгөнморьтын зүүн ба зүүн өмнөд хэсэг, Батсүмбэрийн зүүн ба зүүнхойд хэсэгтус тус багтана. **Хуурайдуу хүйтэвтэр мужид** чийгийн хэмжээ дунд зэрэг, дулааны хүрэлцээ сайн, түрүүчийн мужийн адил эрт хүйтэрч орой дулаарах ба чийгшлийн хувьд өмнөх мужуудаас арай илүү, 1200-1600 м өндөртэй бүх нутаг хамаарна. **Хуурай дулаавтар мужид** тус аймгийн Баянжаргалан, Баянцагаан, Баян-Өнжүүл, Бүрэн, Лүн, Өндөрширээт зэрэг сумууд хамрагдана. Энэ муж дулааны хангамжаар сайн боловч чийгээр дутмаг учир ургамлын баялагаар муу газар тариалан эрхлэх бололцоо багатай .




Газар зохион байгуулалтанд уур амьсгалын бүрдүүлэх хүчин зүйлсээс хамгийн чухал нөлөө бүхий зарим үзүүлэлтийг авч үзье.

2.1.1 Дулаан хүйтний горим

Тус аймгийн Туул, Хэрлэн голын сав дагуух буюу далайн түвшнээс дээш 1250 метрээс дээш өргөгдсөн нутгуудад хүйтний улирлын агаарын дундаж температур -20 градус байгаа нь бусад нутгаас арай илүү хүйтэн байна. Харин жилийн дундаж нь Заамар, Баянцогт, Баянхангай, Аргалант, Лүн, Архуст, Дэлгэрхаан, Баян-Өнжүүл, Цээл, Баянцагаан, Борнуур, Баянчандмань сумын нутагт 0.6-1.0 градус, бусад нутагт 0.1-...02 градус байна. Жилийн хүйтэн үе нь аль ч нутагтаа 1-р сар бөгөөд Лүн, Алтанбулаг, Эрдэнэ, Сэргэлэн, Зуунмод, Баяндэлгэр, Дэлгэрхаан, Бүрэн, Баян, Сүмбэр, Борнуур, Батсүмбэрт 40.1-49.7 градус хүрч хүйтэрэх нь олонтаа ажиглагддаг. Жилийн хамгийн дулаан үе нь нийт нутагт 7-р сар ба сарын агаарын дундаж температур далайн түвшнээс дээш 1000-

1250 метр өргөгдсөн нутагт 18.0-20.4 градус, 1270-1580 метрт өргөгдсөн өндөрлөг нутагт 15.7-18.9 градус дулаан байдаг байна.

Олон жилийн судалгаанаас үзэхэд дунджаар хөрсний температур 3-5 градусаас дээш дулаарах үе буюу ургамлын ургалтагд тохиромжтой үе нь 4-р сарын 26-аас 9-р сарын 29-ны хооронд 154 хоног үргэлжилнэ. Идэвхитэй дулааны нийлбэр нь далайн түвшнээс 1400 м-ээс дээш өргөгдсөн нутагт 1200-1500, 1000-1300 м-с дээш өндөрт орших хээрийн бүсэд 1500-1800 градус хүрдэг. Хоногийн дундаж агаарын температур 10 градусаас дээш байх хугацаа уулархаг нутагт 104-106, хээрийн бүсэнд 110-130 хоног байна.




2.1.2 Чийгшлийн горим

Төв аймгийн нутаг нь Хэнтийн нуруу ба түүний салбар уулс, говийн нутгийн залгаа оршдог тул чийгшлийн горимын хувьд эрс ялгаатай. Дулааны улиралд дундаж харьцангуй чийгшил уулархаг нутгаар 65-73%, хээрийн бүсэд 37-64% байна.

Хэнтийн нуруу түүний салбар уулст жилдээ 300мм-ээс их тунадас унадаг бол урагшлах тутам энэ үзүүлэлт багасч Баян, Зуунмод, Сэргэлэн, Баян-Өнжүүл зэрэг суманд 200-250 мм, харин баруун талдаа Хэнтий, Хангайн уулархаг орны нөлөөгөөр дээшилж, Угтаал, Заамар, Баянцогт, Жаргалант, Батсүмбэр зэрэг газар тариалангийн гол бүс нутагт 250-300 мм-т хүрнэ. Жилд унах тунадасны 81-93% нь дулааны улиралд, 7-19% нь хүйтний улиралд ордог. Хур тунадастай өдөр жилд

дунджаар 31-44 байдаг ч орон нутгийн онцлогоос шалтгаалж Угтаал, Зуунмод, Эрдэнэсант сумын нутагт 57-68 өдөр, уулархаг нутагтаа 150-218 хоног, Туул, Хэрлэн голын хөндийд 115-149 хоног, өмнө, зүүн өмнө зүгийн сумдад 119-154 хоног байна.



2.1.3 Салхины горим

Төв аймгийн салхины жилийн дундаж хурд уулархаг нутагт 2.1-3.5 м/сек, хээрийн бүсэд 3.9-4.8 м/сек хүрдэг бөгөөд хавар 3-р сарын 1-р 10 хоногоос 6-р сар гартал салхины хүч ихэсч цасан ба шороон шуурга ажиглагдана. Салхины хамгийн их хурд гол төлөв 3.4 сард 17-22 м/сек хүртэл ширүүсдэг. 10м/сек-ээс дээш салхитай өдрийн тоо ойт хээрийн бүсэнд 26-78 хээрийн бүсэд 88-217 байхад 15м м/сек-ээс хүчтэй салхитай өдрийн тоо нутгийн ойт хээрийн бүсэд 10-16 өдөрт хүрнэ. Олон жилийн судалгаанаас үзэхэд хаврын эхэн сараас зуны сар гартал салхи шуурга ихтэй байдаг нь газрын гадаргын хөрсний эвдрэл, чийгийн алдагдлыг ихэсгэдэгээс хур багатай жийн хавар ургамал оройтож цухуйх, хатах явдал ажиглагдана.

2.2 Ус зүй, усан хангамж

Гадаргын усны сүлжээ төв аймгийн хувьд төдийлөн сайн биш ба сүүлийн жилүүдийн уур амьсгалын өөрчлөлт, хүний зохисгүй үйл ажиллаганы улмаас нилээд хэсэг нь ширгэж байна.

Хүснэгт 1. Гадаргын усны тооллого

Аймгийн нэр	Гол горхи		Булаг шанд		Рашаан		Нуур, тойром	
	нийт	ширгэсэн	нийт	ширгэсэн	нийт	ширгэсэн	нийт	Ширгэсэн
Төв	537	94	413	103	17	1	235	72

Аймгийн гадаргын ус нь Хойт мөсөн далай, Номхон далай, Төв Азийн гадагш урсацгүй ай савд хамрагдана.

Нутаг дэвсгэрийн 60 орчим хувь нь **Хойд мөсөн далайн ай савд багтах** Туул болон түүний цутгал Тэрэлж, Заан, Улиастай, Сэлбэ, Баруун баян, Галттай, Хаг, Хөлийн гол, Харбух зэрэг голууд багтана.

Туул гол. Хан Хэнтэй нурууны салбар уулс болох далайн түвшнээс дээш 2000 метр өндөрт өргөгдсөн Чисаалайн сарьдаг, Шороотын давааны өврөөс гарах Намьяа, Нэргүй хэмээх 2 голын уулзвараас эх авна. Туул голын хөндий Улаанбаатар хотоос доош тавиурч урсацын алдагдал ихэснэ. Туул голын жилийн дундаж өнгөрөлт Улаанбаатар орчим 26.6, Сонгинод 25.8, Өндөрширээтэд 24.1 шоо м/с байгаа нь дээрх дүгнэлтийг баталж байна. Голын ус хурах талбай 49840 ам км, 704 км урт байна.

Нутаг дэвсгэрийн 10 гаруй хувь нь **Номхон далайн ай савд багтдаг**. Хэрлэн голоор тэжээгдэнэ. Хэрлэн гол нь Их Хэнтэйн нурууны өвөр хажуугаас эх авсан Богдын гол, Цагаан гол хоёрын уулзвараас эхлэх ба аймгийн зүүн захаар урсаж, улсын хил хүртэл 1090 км үргэлжлэнэ. Ус хураах сав талбай нь 116455 ам км.

Төв аймгийн нутаг дэвсгэрийн 30-аад хувь нь **Төв Азийн гадагш урсгалгүй ай савд хамрагдах ба** хур тунадас харьцангуй бага, ууршилт их учраас гол мөрний сүлжээ бага, томоохон гол мөрнүүд байхгүй ба жижиг булаг шанд, тойром бүрдүүдээс энэ мужийн гадаргын ус нь бүрэлддэг.

Судалгаанаас харвал тус аймаг нь 112.9 км квадрат нийлбэр талбайтай 209 нууртай ба энэ нь манай орны бүх нуурын 6.8 хувьтай тэнцэнэ. Нуурын 93.3% нь 1000-1500м, хоёр нуур 2000м ээс өндөрт байрладаг. Нийт нуурын 90.9% нь 0.9 км квадратаас бага, ганц нуур 5 км квадратаас илүү талбайтай болно. Гарлын хувьд тектоникийн, мөстөлийн, цэвдэгийн гаралтай нуур зонхилдог. Нуурууд нь эрдэс давс, ус намгийн амьтад, жигүүртэн шувуу, амралт, рашаан сувилал, аялал жуулчлалын асар их нөөц болдог. Аймгийн нуурын каталогт 914-961 дугаартай 70.2 км квадрат талбайтай 48 нуурыг орууллаа. /Хавсралт 1/

2.2.2 Усан хангамж

Төв аймаг нь ойт хээрийн ба хуурай хээрийн бүсийг дамнан байрласан тул нутаг дэвсгэрийн усан хангамж харилцан адилгүй, нутгийн хойт хэсэг нь гадаргын усан хангамжаар сайн байхад өмнөд хэсэг нь зөвхөн гүний усны эх үүсвэрээр хангагдаж байна.

Төв суурингийн усны хэрэглээг гол усны гидравлик холбоо бүхий газрын доорхи усаар хангадаг бөгөөд 2004 оны байдлаар аймгийн нийт ашигласан усны хэмжээ 39332,45 мян. шоо. метр байсны 5976,0 мян.шоо метр ахуйн хэрэгцээнд, 25680,0 мян.шоо.метр үйлдвэрлэлийн хэрэгцээнд тус тус ашиглагдсан байна. /Улсын тайлан 2004 Маягт БОХ-4/

Хүснэгт 2. Ус ашиглалтын байдал


Д/Д	Ус ашиглалтын төрөл	Хэмжих нэгж	Ус ашиглалтын хэмжээ
1	Нийт ус ашиглалт	Мян.шоо.м	39332,45
2	Эх үүсвэрээр		
	Гадаргын уснаас	Мян.шоо.м	36712,0
	Газрын доорхи уснаас	Мян.шоо.м	2620,45
3	Зориулалтаар:		
4	Ахуйн хэрэгцээний	Мян.шоо.м	5976,0
	Үйлдвэрийн зориулалтаар	Мян.шоо.м	25680,0
5	ХАА-н	Мян.шоо.м	7676,4

6	Нийт хаягдал ус	Мян.шоо.м	9124,3
7	Нийт цэвэрлэсэн бохир ус	Мян.шоо.м	811,0

Хүснэгтээс харахад ус ашиглалтын 93%-ийг газрын гадаргын усаар хангаж жилд 9124.3 мян. шоо метр ус хаяж үүний 10 хүрэхгүй хувийг цэвэршүүлж байгаа нь ус ашиглалтын түвшин төдийлөн сайн бишийг харуулж байна. Бохир ус нь гол юм уу хөрсөнд шингэж байгаа нь экологид сөргөөр нөлөөлдөг.

Хүснэгт 3. Бохир ус цэвэрлэх байгууламжуудын ашиглалтын байдал

Д/д	Сумын нэр	Ашиг лалтанд Орсон он	Цэвэрлэгээний төрөл	Цэвэрлэсэн усаа Хаядаг газар	Ажиллагаа хэвийн эсэх	Ажилгүй буюу Хэвийн бус байх Шалтгаан
1	Зуунмод	1995	Биологи	Хөрсөнд	Хэвийн	
2	Аргалант	1990	Механик	Хөрсөнд	Ажилгүй	Засвар хийх
3	Батсүмбэр	1993	Механик	Жаргалант	Хэвийн	
4	Баянбуурал	1993	Биологи	Хараа гол	Хэвийн	
5	Баянхангай	1989	Механик	Хөрсөнд	Ажилгүй	Эзэнгүй
6	Баянцогт	1973	Механик	Хөрсөнд	Хэвийн	
7	Баянчандмань	1974	Механик	Хөрсөнд	Хэвийн бус	Засвар хийх
8	Борнуур	1982	Механик	Бороо голд	Ажилгүй	Тоногдсон
9	Заамар	1968	Механик	Хөрсөнд	Хэвийн бус	Эзэнгүй
10	Сүмбэр	1983	Механик	Хөрсөнд	Ажилгүй	Засвар хийх
11	Угтаал	1983	Механик	Хөрсөнд	Ажилгүй	Эзэнгүй
12	Залуучууд	1978	Механик	Хөрсөнд	Хэвийн	Засвар хийх
13	Эрдэнэсант	1973	Механик	Хөрсөнд	Хэвийн	



Төв аймаг нь 2680 сая м³ нөөцтэйгээс 69,2 сая м³ ашиглаж байна. Нийт хэрэглээнд хүн амын хэрэглээний ус 22,9 сая м³, үйлдвэрт ашиглах ус 45,2 сая м³, бэлчээр усжуулалт 27,3 сая м³ байгаа ба цаашид ч энэ хэмжээ нэмэгдэнэ.

Мөн тус аймагт 1 шоо км усны нөөцтэй Зуун мод, Чулуут цагаан дэл Заан гол, Жаргалант, Тал булаг гэх зэрэг газрын доорх усны нөөц ордууд илүүлсэн байна. / Хүснэгт 5/

Хүснэгт 4 . Төв аймгийн усны нөөц, шоо км-ээр

Д/д	Аймгийн нэр	Гадаргын ус		Газрын доорхи ус	
		Нийт	Ашиглаж болох	Ул хөрсний	Ашиглах боломжит
1.	Төв	1.91	0.20	0.59	0.20

Бэлчээрийн усжуулалт: Гадаргын ба газрын доорхи усны нөөц тоо хэмжээ, орон зайн хувьд жигд бус тархсан, хүйтний улиралд ил задгай ус хөлддөг зэрэг шалтгаанаас мал сүрэг усаар гачигдах явдал түгээмэл үзэгддэг.

Хээрийн бүсэд орших Өндөрширээт, Эрдэнэсант, Дэлгэрхаан, Бүрэн, Баян-Өнжүүл, Баянцагаан, Баян, Баянжаргалан, Лүн зэрэг олон суманд ус дутагдалтай учир уст цэгийн тоог нэмэгдүүлэх шаардлага гарч ирж байна. Зохисгүй ашиглалт, оновчгүй зохион байгуулалтаас шалтгаалан уст цэгийн тоо буурсан нь бэлчээрийг цаг улирал, өвс ургамлын онцлогт зохицуулан ээлжлэн ашигладаг нүүдлийн уламжлал хумигдаж, цөөн тооны худаг ус, булаг шанд бараадан эргэлдсэнээр бэлчээр талхлагдах элбэгшиж байна.

Хүснэгт 5. Уст цэгийн тоо /2000 оны байдлаар/

Нийт худгийн тоо	үүнээс		Ашиглагддаггүй
	инженерийн	энгийн	
1569	495	1074	350

2.3 Хөрс хөрсөн бүрхэвч

Хөрс-газарзүйн тархалтаараа аймгийн хойт хэсэг нь Хэнтийн нурууны төв хэсгийн уулын тундрын болон уулын нугын хөрсний тойрогт, нутгийн дунд болон түүнээс хойш хэсэг нь Хэнтийн нурууны зүүн ба баруун хэсгийн салбар уулсын уулын хар хүрэн ба хээрийн хар хүрэн хөрсний тойрогт, өмнөд хэсэг нь хуурай хээрийн бүсийн ухаа гүвээр удам хөндийн хүрэн хөрсний тойрог тус тус хамрагдана.

Газар зохион байгуулалтын зорилгоор хийгдсэн хөрсөн бүрхэвчийн судалгааны дүнгээс үзвэл төв аймгийн хөрс нь делювийн дунд ба хөнгөн шавранцар, элюви-делювийн элсэнцэр, аллювийн дунд ба хүнд шаварлаг хурдас дээр тогтсон ба нутгийн уулархаг хэсгээр элюви ба элюви-делювийн хурдас, тэдгээрийн бэл хормойгоор, тал хөндийгөөр делюви, эоловийн, том жижиг голын сав хөндийгөөр аллювийн хурдсууд тус тус тархжээ.

Хөрсний хэвшинжийн хувьд өндөр уулын ба уулын тайгын хөрснөөс, дундаж ба нам уулсын хүрэн хөрс, тал хээрийн хүрэн ба хар хүрэн хөрс, нугын ба голын хөндийн хөрснүүд павамгайлан тархжээ. / Хүснэгт 8/

Хүснэгт 6.Төв аймгийн хөрсний нөөц, түүний ашиглалтын байдал

Д/д	хөрсний нэр	Талбай /га/	%	тариалан	хадлан	бэлчээр	ашиглалтгүй газар
5	Өндөр уулын, уулын тайгын хөрс	234372.4	3.69		2361	232011.4	


6	Уулын ойн хөрс	268166.1	4.23		9724	265282.1	120
12	Уулын хар хүрэн хөрс	740971.8	11.7		16736	724070.8	165
	Уулын хүрэн хөрс	1498402	23.59		23212	1475159	31
14	Нугын хүрэн хөрс	281491.7	4.43	39161	2251	240079.7	
16	Хар хүрэн хөрс	842350	13.3		861	841489	
15	Хүрэн хөрс	2109380	33.2	74051		2035318	11
17	Эоловын элс	14986	0.24			9161	5825
18	Нугын ердийн хөрс	258444.8	4.08	2995	4549	250900.8	
21	Аллювийн нугат намгийн хөрс	95141	1.5			95141	

Эдгээр хөрс нь ашиглалтын хувьд бэлчээрт зонхилох боловч нугын хүрэн ба тал хөднийн хүрэн хөрс нь тариалангийн гол нөөц болдог. Хадлангийн нөөц газрууд нь уулын тайгын болон уулын ойн хөрс, хар хүрэн ба нугын хүрэн хөрс дээр байрлана.

Хөрсний дийлэнхийг / 89.3%/ хэвийн хөрс эзлэх ба хужирлаг хөрс 4.14 хувь, мараалаг хөрс 1.41 хувь, карбонатлаг 2.1 хувь, сулавтар хөгжилтэй хөрс үлдсэн хувийг эзэлж байна.

Хөрсөн бүрхэвчийн 67%-ийг хөнгөн ба дунд шавранцар хөрс эзэлж байгаа нь ашиглалт даахдаа хаьтцангуй сайн болохыг илтгэнэ. Гэвч урд талын сумдаар элсэнцэр хөрс голлож, экологийн хувьд харьцангуй эмзэг байгааг бодолцон бэлчээрийн даацыг тохируулах шаардлагатай.

Диаграмм 1. Хөрсний механикийн бүрэлдэхүүн /га-гаар/



Хөрсний дэлгэрэнгүй жагсаалтыг хавсралтаар үзүүлэв.

2.4 Ургамал, ургамлан бүрхэвчийн онцлог.

Төв аймаг ургамалшил Хангайн бүс нутгийн Хэнтийн нурууны тайгын муж болон Орхон Сэлэнгийн савд нутгийн баруун хойт хэсгийн сумд, Хэнтийн зах хаяа уулсын тойрогт Баяндэлгэр, Эрдэнэ, Архуст сум бүхэлдээ багтана.

Хэнтийн нурууны чийглэг сэрүүн уур амьсгал, өндрийн бүс бүслүүр, говь, тал хээрийн бүсийн ялгаагаар ургамлан бүрхэвч өндөр уулнаас нам хотос хүртэл нилээд ялгавартайгаар бүрэлдсэн ба ургамлын бүтэц бүрэлдэхүүн хангайн бүсэд баялаг, тал хээрт ядмаг. Ойн санд шинэс голлох ба бэлчээрийн ургамалжилт нь уулын нугын ба нугархаг хээрт 13-15ц/га ургацтай, 700-800кг/га тэжээлийн нэгжтэй, зун намар үхэрт илүү тохиромжтой байхад алаг өвс-жижиг дэгнүүлт үетэн-ботуульт хазаар өвст-хялганат ба жижиг дэгнүүлт үетэн-хялганат хээрийн бэлчээр нь 9-11 ц/га тэжээлийн нөөцтэй, 650-700 кг/га тэжээлийн нэгжтэй бөгөөд зун намрын улиралд үхэр адуунд тохиромжтой, Туул голын татмын улалжит-хужирлаг нуга, татмын алаг өвс-улалжит нугын бэлчээр 26-29 ц/га тэжээлийн нөөцтэй, 1900-2100 кг/га тэжээлийн нэгжтэй, зун намрын улиралд үхэрт тохиромжтой, алаг өвс- жижиг дэгнүүлт, үетэн-ботуульт уулын хээр, хазаар өвс-хялганат ба жижиг дэгнүүлт-үетэн-хялганат хээрийн бэлчээр нь 8-10 ц/га тэжээлийн нөөцтэй, 400-500 кг/га тэжээлийн нэгжтэй бөгөөд зун намрын улиралд бүх төрлийн малд тохиромжтой ба өмнөд хэсгээр тархах цөлөрхөг хээрийн бэлчээрийн ургац 3-5 цн/га ургацтай бог болон адуу тэмээнд илүү тохиромжтой байна.

2.5 Ан амьтан.

Төв аймгийн зүүн хойд хэсгээр баавгай, хур, мануул, шилүүс нургийн сойр, хэрэм тарвага чандага зурам чоно үнэг хярс мөн түүнчлэн дархлагдсан амьтад болох хандгай, буга, хүдэр гэх мэт, нутгийн баруун хойд хэсэгт буга зэрлэг гахай хярс, нохой зээх, сойр элбэг байдаг.

Туул голын савын эхний гол горхи цэнгэг нуурт зүйл зүйлийн загас элбэгийн дотор тул *Hucho taimen*, зэвэг *Brachymystax Lenok*, шивэр хадран *Thymallus arcticus* зэрэг агнуурын (4) үнэт загаснууд бий.

Аймгийн нутагт суурин болон нүүдлийн олон зүйл жигүүртэн шувуу бий. Нүүдлийн шувуу ирсэн дулааны улиралд шувууны зүйлийн тоо, нөөц баялаг хэд дахин нэмэгддэг. Шувуудын дотор хурынхан *Tetraonidae*, тагтааныхны *Columbidae* агнуурын ач холбогдолтой зүйлүүд байна. Орхоны эхний Хангайн өндөр уулсаар цагаан ятуу *Lagopus Lagopus*, ойд нь хур *Lyrurus tetrix*, Говийн алтайн уулсаар хахилаг *Alectoris chukar*, хээр, хаяа нам уулсаар дагуур ятуу *Perdix daurica*, тоодог *Otis tarda*, Нууруудын хөндий, говиор ногтруу *Syrharpnes paradoxus*, бараг бүх уулсаар хадны тагтаа *Columba rupestris* зэрэг суурин цөөн зүйл байдаг. Нугасныхны *Anatidae* бор галуу *Anser anser*, бор нугас *Anas strepera* зэрэг нүүдлийн усны арав гаруй зүйл (8, 21) бий.

Агнуурын хөхтөн амьтны бүрэлдэхүүн, тархац нөөцийн тойм:

Аймгийн нутагт тархсан агнуурын 34 (46,5%) зүйл амьтдынгийн дотор 22 зүйл (64,7%) нь агнуурын “үндсэн” буюу одоо мөрдөж байгаа монгол улсын ан агнуурын хуулийн дагуу агнан ашиглаж болох ерийн ан болж байна.

Үнэт үндсэн чухал ан болох аргаль хонь, янгир ямаа, халиун буга, баданга хүдэр, хар сүүлтий, цагаан зээр, монгол тарвага, хулангийн тархац нутаг хомсдоноос гадна манай улсын нэгдэн орсон олон улсын конвенци, эрхзүйн бусад акт, баримтын дагуу агнуураас албан ёсоор чөлөөлөгджээ.

Харин урьд агнуурын ач холбогдол багатай, тохиолдлоор шахам агнадаг байсан нэг талаас агнуурын шууд ашиг өгөөж, зах зээлийн үнэ цэнэ бага, хүч хөдөлмөр илүү зарцуулдаг, нөгөө талаас байгалийн орчин зүйн(экологийн) тэнцвэрт байдал, хөгжилд чухал оролцоо холбогдолтой зурам, үенгийн хэд хэдэн зүйл, маануул мий,

халздай дорго зэрэг тус аймагт угаас бага тархацтай цөөн амьтад үндсэн ан болсон сонирхолтой тал ажиглагдаж байна. Амьтдын дотор монгол тарваганы нөөц эрс багасаж, эдийн засагт төдийгүй байгалийн орчин тогтолцооны тэнцвэрт сөргөөр нөлөөлөх хэмжээнд очсон байна.

2.6 Экологийн өнөөгийн байдал.

Тус аймагт орчны бохирдлыг бий болгох томоохон хүчин зүйлсийн тоонд хотжилт суурьшил, уурхай, үйлдвэр, гэр хороолол орох бөгөөд хөрс ус агаарын бохирдлын түвшин харьцангуй их, цаашид ч нэмэгдэх хандлагатай байна.

2.6.1. Газрын гадаргад учирсан хохирол

Бүс нутгийн төдийгүй, улсын хэмжээний нь хүн амын нутагшил суурьшлын таталцлын цөм болсон нийслэл Улаанбаатар хотыг тойрон оршдог Төв аймгийн нутаг дэвсгэрт газрын гадарга олон янзын шалтгаанаас болж доройтолд орж байна.

Эдгээрээс хамгийн эрчимтэй нь бэлчээрийн талхлагдал бөгөөд хүрээгээ улам бүр тэлсээр байна.

Судалгаанаас харвал нийт нутаг дэвсгэрийн 1,1% нь хүний үйл ажиллагааны болон байгалийн зүй тогтлын алдагдлаас болж доройтолд оржээ. /хүснэгт 11/

Хүснэгт 7. Газарт учирсан хохирлын төрөл, хэмжээ

Д/Д	Үзүүлэлт	Доройтолд орсон газрын хэмжээ /га/	Эзлэх хувь %
1	Газарт учруулсан хохирол	824467	100
2	Үүнээс: Тариалангийн газраас атаршуулж орхисон талбайн хэмжээ	131353	15.9
3	Бэлчээр, отор, хадлангийн газарт	274069	33.2
4	Хортон шавьжийн голомт, тархалтын нөлөөллөөс	378950	46.0
5	Хот тосгон бусад суурин газарт	227	0.0
6	Ойн сан бүхий газарт	36926	4.5
7	Усан сан бүхий газарт	120,1	
8	Уул уурхайн тогтоогдсон нөөц бүхий үйлдвэрлэлийн ашиглалт, малталт хийх явцад эвдэрсэн газрын хэмжээ Үүнээс: хөрс хуулалт хийсэн	2942 187	0.4

Хүснэгтээс харахад хохирлын дийлэнхи хувь нь бэлчээрт байгаа боловч эдийн засгийн ач холбогдол өндөртэй тариалангийн газар эргэлтээс хасагдсан нь бодит хохирлын гол үзүүлэлт болно. Үүнээс гадна 2004 онд 11152 мян га газар хортон шавьжид идэгдэж, 25749 мян га газар түймэрт өртөн сүйтгэгджээ.

2.6.2. Суурьшлын бүсийн экологийн өнөөгийн байдал.

Хязгаарлагдмал орон зайд, хүн ам, техникийн бөөгнөрөл ихтэй байдаг хот суурингийн газарт хөрс, ус, агаарын бохирдол давамгайлдаг.

Хөрсний бохирдлын томоохон эх үүсвэр нь хот суурин газрын ахуйн бохир ус бөгөөд тус аймагт инженерийн шийдэлтэйгээр баригдсан 13 цэвэрлэх байгууламжаас өнөөдрийн байдлаар Батсүмбэр, Зуун мод хот, Баянбуурал амралтын цэвэрлэх байгууламжууд ажиллаж бусад нь ажиллагаагүй болж хөрс болон голын усанд шингэж байна. Мөн нэгдсэн дэд бүтэцгүй гэр хороолол болон барилга байгууламжаас гарсан бохир хөрсөнд 100 хувь шингэдэг.

Гэвч бохирдлын хэмжээ нь хот суурингийн хэмжээ, төвлөрөл суурьшлаас ихээхэн шалтгаалдаг бөгөөд тус аймагт орчны бохирдол хот, тосгодоор ямар байгааг дор сийрүүлэн үзүүлэв.

Зуунмод хот

Төв аймгийн хувьд хамгийн их төвлөрөлтэй хотжсон газар нь Зуун мод хот юм. Богдхаан уулын өвөрт тачир сийрэг хээрийн ургамалжилт бүхий хайргархаг нам ба дундаж уулсаар хүрээлэгдсэн хагас битүү хотост суурьшсан бөгөөд хотын эргэн тойрон элсэнцэр хар хүрэн хөрст нам уулс, төв хэсэгт нь дунд зэргийн зузаан хөнгөн шавранцар хүрэн хөрс тус тус тархжээ.

Ландшафтын энэхүү тогтоц нь хотын экологийн байдалд нөлөөлж хөрс нь нэлэнхүйдээ халцрах, тодорхой орон зайн хүрээнд агаарын болон хөрсний бохирдлыг үүсгэх нөхцлийг бүрдүүлсэн байна. 2005 онд ГХГЗЗГ-аас явуулсан судалгаанаас харвал Зуун мод сумын багуудын газрын төлөв байдал, чанарын өөрчлөлт дараахи байдалтай. /хүснэгт 12/

Хүснэгт 8 . Зуунмод сумын газрын төлөв байдал, чанар

Д/Д	Багын нэр	Газрын бохирдлын байдал
1	Баруун Зуунмод баг	Тус багын нутаг дэвсгэр ерөнхийдөө газрын өнгөн хөрс халцарч физик элэгдэлд дунд зэрэг орсон, химийн бохирдолд ороогүй, ахуйн хог хаягдлаар бага зэрэг бохирдсон байна.
2	Номт баг	Тус багын нутаг дэвсгэрийн эзэмшигчдийн ашиглалтад байгаа газрын хөрс физик элэгдэлтэд хүчтэй орсон, биологийн бохирдолд дунд зэрэг орсон боловч химийн бохирдолд ороогүй байна.
3	Нацагдорж 1	Газрын хөрс физик элэгдэлд хүчтэй орсон, биологийн бохирдолд дунд зэрэг орсон боловч химийн бохирдолд ороогүй.
4	Нацагдорж 2	Газрын хөрс физик элэгдэлд хүчтэй орсон, биологийн бохирдолд дунд зэрэг орсон боловч химийн бохирдолд ороогүй.
5	Нацагдорж 3	Газрын хөрс физик элэгдэлд хүчтэй орсон, биологийн бохирдолд дунд зэрэг орсон боловч химийн бохирдолд ороогүй.
6	Нацагдорж 4	Газрын хөрс физик элэгдэлд хүчтэй орсон, биологийн бохирдолд дунд зэрэг орсон боловч химийн бохирдолд ороогүй.
7	Баянхошуу	Тус багын газрын өнгөн хэсэг халцарч физик элэгдэлд дунд зэрэг орсон, химийн бохирдолд ороогүй, ахуйн хог хаягдлаар баг зэрэг бохирдсон байна.
8	Ланс	Тус багын газрын өнгөн хэсэг халцарч физик элэгдэлд дунд зэрэг орсон, химийн бохирдолд ороогүй, ахуйн хог хаягдлаар баг зэрэг бохирдсон байна.
9	Зүүндэлгэр	Тус багын нутаг дэвсгэр ерөнхийдөө газрын өнгөн хөрс халцарч физик элэгдэлд дунд зэрэг орсон, химийн бохирдолд ороогүй, ахуйн хог хаягдлаар бага зэрэг бохирдсон байна

Зуун мод хотын барилгажсан төвийн хэсгээс гарах бохир ус цэвэрлэх байгууламжаар дамжин хөрсөнд шингэдэг бол түүний эргэн тойронд байх гэр

хорооллын хашаа бүрт бохир усны цооног болон жорлонгоос гарсан шингэн ямар нэгэн цэвэрлэгээгүй хөрсөнд шингэдэг.

Бусад тосгон суурин

Төв аймгийн 26 сумын, төмөр зам дагасан жижиг суурингуудад хүн амын төвлөрөл, дэд бүтцийн сул хөгжлөөс шалтгаалан хөрсний бүтэц алдагдан тоосжсон, ахуйн бохир хөрсөндөө шингэснээс хөрс бохирдсон, автозам замбараагүй салаалсан зэрэг нь экологийн доройтол үүсгэх шалтгаан болсон байна.

Газар нутгийн байгалийн унаган төрхөөс шалтгаалан экологийн доройтол тосгон суурингуудад харилцан адилгүй. Тухайлбал тал хээрийн бүсийн сумдад элсжилт илүү ажиглагдаж байхад Батсүмбэр, Борнуур, Мөнгөнморьт сумдад хөрсний гадаргын ба гүний чийгшлээс шалтгаалж газрын гадаргын овор товон нэмэгдэж хөрс тоосжсон байна. Харин экологийн хувьд харьцангуй тогтвортой нь Эрдэнэ, Баянчандмани, Баянхангай, Жаргалант, Сүмбэр, Аргалант, Баян-Өнжүүл сумд болно.

Хүснэгт 9. Сумын төвийн газрын төлөв байдал.

Д/Д	Сумын нэр	Газрын бохирдлын байдал
1	Алтанбулаг	Сумын төвийн дундуур усны шугман эвдрэлийн нөлөөгөөр гуу жалга үүссэн, хөрсний тоосжилт ихтэй, нийтийн эзэмшил газар элсжсэн.
2	Аргалант	Харьцангуй хэвийн
3	Архуст	Ургамлан бүрхэвч зулгарч элсжсэн боловч харьцангуй хэвийн
4	Батсүмбэр	Сумын төвийн суурьшлын бүсийн зарим хэсгийн хөрс усны шугман эвдрэлд орсон, гадаргын овор товон ихтэй. Төвийн хэсэгт хөрсний усны түвшин харьцангуй дээр тоосжилт ихтэй.
5	Баян	Ургамлан бүрхэвч зулгарч элсжсэн боловч харьцангуй хэвийн
6	Баяндэлгэр	Ургамлан бүрхэвч зулгарч элсжсэн боловч харьцангуй хэвийн
7	Баянжаргалан	Ургамлан бүрхэвч зулгарч элсжсэн боловч харьцангуй хэвийн
8	Баян-Өнжүүл	Хэвийн
9	Баянхангай	Ургамлан бүрхэвч зулгарч элсжсэн боловч харьцангуй хэвийн
10	Баянцагаан	Ургамлан бүрхэвч зулгарч элсжсэн боловч харьцангуй хэвийн
11	Баянцогт	Ургамлан бүрхэвч зулгарч элсжсэн боловч харьцангуй хэвийн
12	Баянчандмань	Харьцангуй хэвийн
13	Борнуур	Сумын төвийн суурьшлын бүсийн зарим хэсгийн хөрс усны шугман эвдрэлд орсон, гадаргын овор товон ихтэй. Төвийн хэсэгт хөрсний усны түвшин харьцангуй дээр тоосжилт ихтэй.

14	Бүрэн	Ургамлан бүрхэвч зулгарч элсжсэн боловч харьцангуй хэвийн
15	Дэлгэрхаан	Ургамлан бүрхэвч зулгарч элсжсэн боловч харьцангуй хэвийн
16	Жаргалант	Харьцангуй хэвийн
17	Заамар	Харьцангуй хэвийн
18	Лүн	Ургамлан бүрхэвч зулгарч элсжсэн боловч харьцангуй хэвийн
19	Мөнгөнморьт	Сумын төвийн суурьшлын бүсийн зарим хэсгийн хөрс усны шугман эвдрэлд орсон, гадаргын овон товон ихтэй.
20	Өндөрширээт	Ургамлан бүрхэвч зулгарч элсжсэн боловч харьцангуй хэвийн
21	Сэргэлэн	Ургамлан бүрхэвч зулгарч элсжсэн боловч харьцангуй хэвийн
22	Сүмбэр	Харьцангуй хэвийн
23	Угтаал	Ургамлан бүрхэвч зулгарч элсжсэн боловч харьцангуй хэвийн
24	Цээл	Элсэнд хамгийн их автсан
25	Эрдэнэ	Харьцангуй хэвийн
26	Эрдэнэсант	Ургамлан бүрхэвч зулгарч элсжсэн боловч харьцангуй хэвийн

2.6.3. Усны бохирдол

Нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад усны нөөцийг зүй зохистой ашиглах, бохирдлоос хамгаалах асуудал туйлын чухал. Сүүлийн жилүүдэд монгол оронд болсон уур амьсгалын хуурайшилт, хүний үйл ажиллагааны зохисгүй нөлөөгөөр голын усны горим, чанар өөрчлөгдөж байна. Бохирдлын эх үүсвэр бүхий уст цэгүүдийн жагсаалтыг хүснэгтээр харуулав. / хүснэгт 14./ Алтны орд ашиглалтаас бохирдсон усны тооллогын явцад Туул гол Төв аймгийн Заамар сум орчимд, Мөнгөнморьт сумын нутаг дахь Тэрэлж гол зэрэг нь ихээхэн бохирджээ Энэ хөрс бохирдох гол шалтгаан болж байна. Зарим голын сав дагуу байрласан суурингуудад хөрсний ус бохирдох боломжийг бүрдүүлнэ.

Хүснэгт 10 . Төв аймгийн нутаг дахь алтны орд ашиглалтын нөлөөллөөр бохирдсон голууд

Д/д	Аймгийн нэр	Сумын нэр	Голын нэр	Бохирдлын шалтгаан
1.	Төв аймаг	Заамар	Хайлаастайн булаг	Алт олборлолт
2.	Төв аймаг	Заамар	Туул, Баян гол	Алт олборлолт
3.	Төв аймаг	Батсүмбэр	Бургалтайн гол	Алт олборлолт
4.	Төв аймаг	Заамар	Урд дэнжийн булаг	Алт олборлолт
5.	Төв аймаг	Мөнгөнморьт	Хэрлэн гол	Алт олборлолт
6.	Төв аймаг	Мөнгөнморьт	Тэрэлж гол	Алт олборлолт
6	Төв аймаг	Алтанбулаг, Лүн	Туул гол	Хотжилт

Усны бохирдлын түвшин, хамрах хүрээгээр хамгийн их нь Туул гол юм. Монгол улсын хүн амын 1/4-өөс илүү нь суурьшсан Улаанбаатар хотын нөлөөллөөс болж бохирдсон ба 2002-2003 онд хийгдсэн шинжилгээний дүнгээр Туул голд цутгаж байгаа бохир усны 47 хувийг Улаанбаатар хотын үйлдвэрүүдийн хаягдал, 53 хувийг ахуйн болон орон сууцны хаягдал бохир ус эзэлж байна.

Голын усны бохирдол нийслэлийн нутгаас давж, тус аймгийн Өндөрширээт хүртэл үргэлжсэнийг мэргэжлийн байгууллагууд тогтоожээ. Туул гол 5 дугаар

зэргийн бохирдолттой бөгөөд энэ нь зөвшөөрөгдөх хэмжээнээс 10 дахин их гэсэн үг юм.

2.7 Төв аймгийн байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөлийн мужлал

Нутаг дэвсгэрийг геологийн бүтэц, уур амьсгал, хотгор гүдгэр, ус зүй, хөрс ба ургамшил, амьтны аймгийн хам бүрдлийн ялгаа, харилцан үйлчлэлийн ижил төстэй нөхцлүүдээр нь мужилж, ашиглалтын үндсэн чиглэлийг тодорхойлох нь газрыг шинжлэх ухааны үндэслэлтэй ашиглах нөхцлийг бүрдүүлдэг. Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хүрээнд монгол улсын нийт нутаг дэвсгэрийг 4 том мужийг хүрээнд 31 тойргоор хувааж нөхцөл нөөцийг үнэлсэн байна. /Д.Даш, Ц.Бадам-УГЗБЕТ-2002/

Энэхүү мужлалын зарчмыг баримтлаж Төв аймгийн нутаг дэвсгэрийг байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцлөөр нь ангилахад Хангайн мужийн 3 тойрог, тал хээрийн мужийн 1 тойрогт хамрагдаж байна. /Зураг 1/

Ер нь нутаг дэвсгэрийн ландшафт бүрэлдэхэд Хэнтийн нурууны уулт орон, Дундад халхын нам уулс, ухаа гүвээт тал хээр, цав толгодот хээрийн бүсийн гадаргын тогтоцууд чухал нөлөө үзүүлсэн бөгөөд Хангайн мужийн төлөөлөл болсон Хэнтийн нурууны уулт тогтолцоо нийт нутаг дэвсгэрийн 73.4 хувийг, тал хээрийн мужийн ухаа гүвээт тэгш өндөрлөг тал хөндий 26.3 хувийг эзэлжээ. /Хүснэгт 15/

Хүснэгт 11. Аймгийн нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцөлийн ялгаа

Д/д	Мужийн нэр	Тойргийн нэр	Талбай	
			га	Хувь
1	Хангайн муж	Орхон-Туулын савын бэсрэг уулс бүхий ойт хээрийн тойрог	2616.0	31.0
2		Орхон – Сэлэнгийн хөндийн хээр бүхий тойрог	1293.6	17.5
3		Хэнтийн төв хэсгийн тайгын тойрог	1863.8	25.2
4		Хэнтийн зах хаяа уулсын ойт хээрийн тойрог	945.1	12.8
5	Тал хээрийн муж	Дундад халхын тэгш өндөрлөгийн тойрог	824.8	11.1
6		Хэрлэн голын өмнөд Баруун уртын нам уулсын тойрог	179.5	2.4
Дүн			7404.2	100


Байгаль-нутаг дэвсгэрийн цогцолбор нөхцлийн тойрог нь ландшафтын хувьд ижил, хүн амын нутагшил суурьшил, амьдралын хэв маяг адил тул газар нутгийн эзэмшил ашиглалтын чиглэл ерөнхийдөө төстэй байна.

Муж, тойргийн хуваарилалт, түүнд хамрагдах нутаг дэвсгэрийн хэмжээг сум бүрээр тооцож хавсралтанд харуулж, Тойрог бүрийн тодорхойлолтыг дор үзүүлэв. /Хавсралт . . . /

Орхон-Туулын савын бэсрэг уулс бүхий ойт хээрийн тойрог (Х-6)-т Хан Жаргалант, Заамарын нуруу, түүнээс салбарласан дундаж ба нам уулс бүхий 15 сумын нийт 2270051.63 га нутаг дэвсгэр хамрагдана. Хотгор гүдгэрийн шинжид хавтгай орой бүхий эртний тэгширлийн гадарга бүхий 1400-1600 м-ийн үнэмлэхүй өндөртэй дундаж уулсаас гадна намхан уулын морфоструктуртэй, уул нурууд нь ихэвчлэн усны хагарлуудын чиглэл дагуу тогтсон бөгөөд үүнд Туул, Бороо, Хараа голын хөндий голлох үүрэг гүйцэтгэжээ.. Туулын их тохойн хуримтлалын тал нь Туул голын дагуу Баян Эрхэтийн нуруунаас Заамар хүртэлх газрыг хамарч Улаанбаатараас доош 185 км үргэлжлэнэ. Туул голын дагуух цав толгодын үнэмлэхүй өндөр 900 – 1200 метр, харьцангуй өндөр 200 - 400 метр байна. Эндэхийн гадарга түр зуурын урсацаар ихээхэн хэрчигдэж бартаатай болсон буюу их, бага гуу, сайр зэрэг элэгдлийн хэлбэртэй байна. Толгодын оройгоор үлдэц хад, цохио үргэлжлэн тохиолдохоос гадна толгодын хажуугаар ч суурь чулуулаг ил гарсан байна.

Орхон-Туулын савын бэсрэг уулс бүхий ойт хээрийн тойрогийн хойд хэсэг нь Монгол орны газар тариалангийн гол бүс нутаг юм. Энд 7 дугаар сарын дундаж агаарын температур нь 17-20°C, хоногийн дундаж агаарын температур 10°C-ийн заагийг хавар 5 дугаар сарын сүүлчээр, намар 9 дүгээр сарын дунд үеэр тус тус дайрч, энэ үеийн үргэлжлэх хугацаа нь 117-120 хоног, уулархаг хэсэгтээ 105-110 хоног байдаг. Энэ хугацаанд 1750-2250°C-ийн дулаан хуримтлагддаг. Хавар эцсийн цочир хүйтрэл олон жилийн дунджаар 5 дугаар сарын 25-наас 6 дугаар сарын эхээр шувтарч намар анхны цочир хүйтрэл 8 дугаар сарын сүүлч, 9 дүгээр сарын эхээр тохиолддог. Дулааны улиралд 250-300 мм хур тунадас ордог. Туулын хөндийгөөр өвөлдөө илүү хүйтэн, зундаа дулаан байдаг. Энэ мужид тарималын ургалтын эхний үед гангийн магадлал 50% байж 10 жилийн 2-5-д нь ган тохиолдох магадлалтай.

Тойргийн хойт уулархаг хэсгээр нунтаг карбонатлаг сайргархаг хар хүрэн хөрстэй алаг өвс-хялганат, зүр өвс-хялганат, алаг өвс-хиаг-хялганат, нугат-хээрийн бэлчээртэй. 9-11 ц/га тэжээлийн нөөцтэй, 650-700 кг/га тэжээлийн нэгжтэй. Зун-намарт үхэр, адуунд тохиромжтой, харин тойргийн зүүн, зүүн өмнөд хэсэг нунтаг карбонатлаг хайргархаг хүрэн хөрстэй чулуусаг алаг өвс-хялганат, хазаар өвс-хялганат, харгана-хялганат хээрийн бэлчээртэй, өвөл-хавар бог мал, адуунд тохиромжтой байна. Туул голын зарим хэсгээр тархсан марзлаг нугын хөрстэй улалжит, цахилдагт, зурман сүүлт нугын бэлчээр нь 18-20 ц/га тэжээлийн нөөцтэй, 850-900 кг/га тэжээлийн нэгжтэй. Зун-намар бог малд тохиромжтой.



Сэлэнгэ – Орхоны хөндийн хээрийн тойрог / X – 7/ нь Хангай ба Хэнтийн уулт мужийн завсарын бэсрэг болон нам уулс, цав толгод, ухаа гүвээт тал, уулс хоорондын хотгорыг хамрах ба тус аймгийн 12 сумын 1293702.08 га нутаг хамрагдана. Орхон-Сэлэнгийн элэгдлийн уулс нь нийтдээ баруунаас зүүн тийш 1000 орчим км, өргөн нь 300 – 350 км үргэлжилнэ. Эндэхийн уулс бөмбөгөр оройтой, налуу хажуутай, хад чулуу багатай байдаг. Энэ тойргийн үнэмлэхүй өндөр нь 1500 – 2000 орчим метр байх буюу хөндийнүүдийнх нь өргөн 800 – 1200 метр байна. Хотгор гүдгэрийн хувьд манай орны агро үйлдвэрлэлийн гол бүс болон хөгжиж ирснээс гадна инженер хайгуулын ажил, зам тавах, усжуулалт зэрэг ажилд байгалийн аятай нөхцөл бүхий нутаг болно.

Тойргийн төв хэсгийн тал хөндийгөөр нунтаг карбонатлаг сайргархаг хүрэн хөрстэй чулуусаг алаг өвс-хялганат, харгана-хялганат, хазаар өвс-хялганат хуурай хээрийн бэлчээртэй. 20-22 ц/га тэжээлийн нөөцтэй, 1400-1500 кг/га тэжээлийн нэгжтэй. Өвөл-хаварт бог мал, адуунд тохиромжтой.

Сэлэнгэ, Орхон бусад голын татмын нугын хөрстэй улиасан төгөл бүхий хөвөн оройт-улалжит нугын бэлчээртэй. 24-30 ц/га тэжээлийн нөөцтэй, 1700-1800 кг/га тэжээлийн нэгжтэй. Зун намар үхэр, адуунд тохиромжтой.

Ландшафтын онцлог. Эндхийн ландшафтад уулын тайгын ширэгт хөрстэй үетэн бүхий нарс-шинэс болон уулын тайгын цэвдэгт хөрстэй давжаа бутногоон хөвд бүхий шинэсэн ойгоос бүрдэх тайга, татмын нуга, ойт хээр, нугат хээр зонхилох рольтой. Эндхийн ойд хусан ой түрж ургах явдал хааяагүй тохиолдоно. Ялангуяа ойн түймрийн дараа шинэс, нарсан ойд хус ихээр түрж ургадаг байна. Иймд дурьдсан нутагт алаг өвс-улалжит шинэсэн ой, түүний оронд ургасан хусан ой нэлээд том талбай эзэлнэ.

Сэлэнгэ мөрний татам дагуу бургас, сөөг бүхий торлогт намгархаг нуга, үетэн-алаг өвст нуга ээлжлэн тархана. Эндхийн ихэнх цутгал уулын жижиг голуудын татам дагууд сөөгөн ширэнгэ бүхий намгархаг нуга давамгайлна.

Хэнтийн нурууны төв хэсгийн тайгын тойрог (X-8)-т 4 сумын нутаг дэвсгэр хамрагдана. Хотгор гүдгэрийн хувьд Хэнтийн хомбон цулдам дундаж уулын дүр төрхийг бүрэн илэрхийлнэ. Энд эртний мөсдлийн ул мөр бүхий дундаж уулын хэв шинжит хотгор гүдгэр зонхилно. Үнэмлэхүй өндөр 2500-2800 метр, харьцангуй өндөр нь 1000 – аас их байна. Хэнтийн уулт хөмбөний зөвхөн төв хэсгийг өндөр уулс эзлэх бөгөөд эртний тэгшрэлийн гадарга шинэхэн тектоник хөдөлгөөнд сэргэгджээ.

Хэнтийн уулсын гол гол сарьдгууд Асралт хайрхан / 2800 м /, түүний салбар Гэл уул / 2551 м /, арай зүүн тийш орших Халзан / 2498 м /, Алагбаавгайн сарьдаг / 2468 м /, Хийдийн сарьдаг / 2666 м /, Их Хэнтийн нуруу болон Хэнтийн хан ба Туул, Ерөө, Хараагийн эхийн завсар оршиж хойт мөсөн далай болоод номхон далайн ус хагалбар болдогоороо онцлог.

Өндөр уулын усны хагалбар их төлөв асга, хад ихтэй, хавтгай оройтой бага зэрэг налуугаас гадна гадаргын хэрчигдлийн гүн 1000 метрээс их, хэрчигдлийн шигүү 0,5 км – ээс бага, гадаргын налуу 20 градус орчим байна. Дээрхи нэр бүхий сарьдгууд Туул, Минж, Ерөө голуудын эхэнд орших бөгөөд Түүнчлэн ян сарьдгийн хяр нь орчин үеийн хүйтний өгөршлийн улмаас элэгдэн мөлийснөөс гадна тэнд тагийн дэнж үүсэх үйл явц эрчимтэй явагдаж байна. Энд уур амьсгал хатуу ширүүн бөгөөд олон жилийн ба улирлын цэвдэг чулуулаг өргөн тархжээ.

Хэнтийн зах хаяа уулсын ойт хээрийн тойрог / X – 9 /-т Хэнтийн уулт өндөрлөгийн зах хэсгийн уулс хоорондын ховдол хотгороор тусгаарлагдсан хавтгай оройтой ихээхэн хэрчигдсэн дундаж өндөр уулс түгээмэл тархана. Тухайлбал: Хэнтийн баруун хажууд Ногоон нуруу, Манхат, Угтаал, Хөшиг зэрэг уулс, мөн түүнчлэн өмнөд хажуугийн Яргуйт / 2069/, Эрдэнэ / 1830 м /, Дугуй / 1835 м / зэрэг хоорондоо ухаа гүвээгээр холбоотой буюу тусдаа орших уулсын орон хамрагдана.

Энэ тойргын уулзүйг гадаргын төрх байдлаар нь 3 хэсэгт хувааж үзэж болох юм. Үүнд:

1. Арцат халзангийн тарамцагт уулс. Энэ хэсэгт орох уулсын үнэмлэхүй өндөр нь 2000- 2500 метр бөгөөд Их, Бага Хэнтийн нурууны ар болоод баруун хойт хажууд байрлана. Энд уулсын оройгоор хүйтний өгөршил эрчимтэй явагдаж улмаар тагийн дэнж үүсэх явц үргэлжилж гадарга нь тэгшрэх байдалтай болсон байна.

2. Уулт хөмбөний захаар орших ихээхэн хэрчигдсэн бэсрэг уулс. Энэ ангилалд Хэнтийн уулсын баруун хэсэгт Хараа, Ерөө голын урсгалын дунд хэсгээр орших уулс орно. Үнэмлэхүй өндөр нь 2000 – 2400 метр, харьцангуй өндөр нь 800 – 1000 метр ихэвчлэн хувирмал чулуулаг, боржин, эртний тунамал хурдаснаас бүрэлдэх бөгөөд эртний тэгшрэлийн гадаргын үлдэц уулс болно. Горхийн уулс. Хэнтийн уулт хөмбөний өмнөт хажууд орших бөгөөд ихэвчлэн боржингоос тогтсон учир боржинт тарамцаг гэж нэрлэдэг ч тал бий. Боржингоос гадна тунамал бялхмал чулуулаг тархсан байна. Мөн уулзүйн гол гишүүдэд Халзан, Алтан - Өлгий, Булнай, Богд уул, Баянзүрх зэрэг уулс орох ба Налайхын хотгор гэх мэт буурц болон хөндийн маягийн хотгор нилээд түгээмэл байна.

3. Үлдэц уулс. Энд Хэнтийн уулт хөмбөний захаар байрласан уулс, тухайлбал Туул голын их тохойн дагуу орших Заамарын уулс багтана. Уулс ихэвчлэн эрт төрмөлийн эриний дээд галавын боржин, хувирмал чулуулгуудаас тогтсон ба уулсын хооронд цэрд, гуравдагч, дөрөвдөгчийн сэвсгэр хурдсаар дүүргэгдсэн эртний хотгорууд байрлана.


Дундад Халхын тэгш өндөрлөгийн тойрог / Т – 1 /-т 7 сумдын нутаг дэвсгэр бүхэлдээ буюу хэсэгчилсэн байдалтай хамрагдаж, 1350016.98 га нутгийг эзэлнэ. Хотгор гүдгэрийн хувьд зөөлөн элэгдсэн хэлбэртэй, өргөн ихэвчлөн өргөн уудам хуурай хөндий талуудтай, бөөрөнхийдүү оройтой толгод нь өргөрөгийн дагуу байрлалтай тогтжээ. Нам хотгоруудад зууван хэлбэрийн хужир, бүрд, давстай нуурууд элбэг бөгөөд ийм тогтоц Баянцагаан сум, Баян сумын өмнөд, баруун өмнөд захаар тархжээ.

Хэрлэн голын өмнөд хэсгийн тойрог /Т – 3/ нь тус тусдаа орших уул болон дэл далан хэлбэрийн өндөрлөгүүд нь цэлгэр уудам нам газруудтай ээлжлэн оршино. Тэгш талууд нь гадагшаа урсацгүй хотгорууд тогтжээ. Хотгор гүдгэрийн үндсэн чиглэл нь өргөрөгийн дагуу гэж үзэж болох боловч жижиг толгодын чиглэлийг тогтооход түвэгтэй юм.

ГУРАВ. АЙМГИЙН ГАЗАР АШИГЛАЛТЫН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ

3.1. Газрын нэгдмэл сан, түүний ашиглалт

Төв аймгийн газрын нэгдмэл сангийн 2004 оны тайлангаас үзэхэд аймгийн нийт нутаг дэвсгэрийн хэмжээ 7404,2 мян га бөгөөд үүнээс хөдөө аж ахуйн газар 5743,6 мян га буюу 77,5%-ийг, тусгай хэрэгцээний газар 1043,7 мян га буюу 14,0%-ийг, ойн сан бүхий газар 543,8 мян га 7,3%-ийг, усан сан бүхий газар 14,3 мян га буюу 0,19%, зам шугам сүлжээний газар 37,9 мян га 0,51%-ийг, хот тосгон бусад суурин газар 20,9 мян га 0,28% газрыг тус тус эзэлж байна.



Нийгмийн хэрэгцээ шаардлага, эдийн засгийн хөгжлийг даган газар ашиглалтын хэлбэр зориулалт тодорхой хэмжээнд өөрчлөгдөж байдаг бөгөөд үүнийг сүүлийн 3 жилийн байдлаар харуулав. /Хүснэгт12/

Хүснэгт 12. Төв аймгийн нэгдмэл сангийн өөрчлөлт /га/

Д/д	Он	2002	2003	2004	Зөрүү+.- 2002-2003 он	Зөрүү+.- 2003- 2004 он
1	Газрын ангилал					
1	ХАА-н газар бүгд	5853788	5744306	5743636.3	-109482	-669.7
1.1	Үүнээс: Бэлчээр	5546416	5422688	5149367.2	-123728	-33208
1.2	Хадлан	59694	59694	59694	-	-
1.3	Тариалан	154179	119262	116207.7	-34917	-3054.3
1.4	Атаржсан газар	91445	125799	131353.3	+34354	+5554.3
1.5	ХАА-н барилга	2054	16863.1	17014.1	166577	+151.1
1.6	ХАА-д тохиромжгүй	233205	14926.5	14926.5	-218278.5	-
2	Хот тосгон бусад суурин газар	19623	20616	20935.2	+993	+319.2
2.1	Үүнээс: Барилгажсан талбай	5484	4864.7	5149.97	-6193	+285.27
2.2	Гэр хороолол	1214	1850.7	1984.78	636.7	+138.08
2.3	Нийтийн эзэмшил	6 346	6712.6	6448.75	366.6	-263.85
2.4	Үйлдвэрийн зориулалттай	36	43	45	7	+2
2.5	Уурхайн зориулалттай нийт	6543	7145	7306.7	602	+161.7
3	Зам шугам сүлжээний газар	37485	37566	37916	81	+350
3.1	Үүнээс: Төмөр зам	1636	1636	1636		

3.2		Авто зам	31530	31550	31900	20	+350
3.3		Шугам сүлжээ	4319	4380	4380	+61	
4	Ойн сан бүхий газар		1243208	543796	543796	-699412	
4.1	Үүнээс:	Ой	1061018	492655.5	492594	-568362.5	-61.5
4.2		Огтлогдсон ой	5168	5746.5	5456.0	578.5	-290.5
4.3		Хамгаалалтын бүс	38	5039	5056	5001	+17
		Бусад	176984	40355	40690	-136629	+335
5	Усан сан бүхий газар		16928	14285	14285	2643	-
5.1	Үүнээс:	Гол булаг шанд	9570	7964	7964	1606	-
5.2		Нуур	7358	6321	6321	1037	-
6	Тусгай хэрэгцээний газар			1043688	1043668,5		+0.5
6.1	Үүнээс:	Тусгай хамгаалалтай		1002903	1002703		
6.2		Батлан хамгаалах		40763	40763		
6.3		Боловсрол, ШУ туршилт		2	2.5		+0.5

Сүүлийн жилүүдэд хотжилт болон дэд бүтцийн хөгжлийг даган тэдгээрийн газрын сангийн хэмжээ өсч ХАА-н газар өнгөрсөн оныхоос 669,7 га-аар хасагджээ.

Хадлангийн газрын хувьд өөрчлөлт ороогүй бөгөөд тариалангийн талбай эргэлтээс 2003 онд 34917 га буюу 22,6%, 2004 онд 3054 га буюу 2,6% талбай эргэлтээс хасагдаж, атаржсан газар тэр хэмжээгээр жил дараалан нэмэгдсэн байна. Нөхөн сэргээлт хийгдэж олон наст тариалсан талбай нийт атаржсан газрын 0,3 хувийг эзэлж байгаа нь сул үзүүлэлт юм.

Өвөлжөө хаваржааны газрыг эзэмшүүлэх болсонтой холбоотойгоор ХАА-н барилга байгууламж бүхий газар 166728.1 га-гаар, хот тосгоны тэг гортигийн өөрчлөлтөөс энэ сангийн газар 319,2 га-гаар, Лүн суманд 3,5 км хар зам ашиглалтад орсноор зам шугам сүлжээний газар 350 га-гаар тус тус нэмэгдсэн байна.

Усан сан бүхий газарт тайлант онд 14285 га газар бүртгэгдсэн нь урьд оныхоос 2643 га-аар багассан нь тодорхой хэмжээний нутаг дэвсгэр тусгай хэрэгцээний газарт шилжсэнтэй холбоотой юм.

Ойн сан бүхий газарт өөрчлөлт ороогүй боловч ангилал дотроо шилжилт хөдөлгөөн хийгдсэн байна.

3.2. Газрын харилцааны өнөөгийн байдал

Нийгмийн харилцааг даган газрын харилцаанд оролцогчдын эрх үүрэг улам бүр нарийсч, иргэн аж ахуйн байгууллага газрыг хууль эрхийн хэмжээнд баталгаатай эзэмшиж ашиглаж эхэлснээс хойш бараг 10 шахам жил боллоо.

Энэ хугацаанд тус аймгийн хэмжээнд нийт 18388 хуулийн этгээд 243519.56 га газрыг эзэмшиж, ашиглаж өмчилсэн байна.

Газрын нэгдмэл сангийн ангилал тус бүрээр нь авч үзвэл ХАА-н газраас 112147,52га эзэмшилд, хот тосгон бусад суурины газраас өмчлөлд 696,9га, эзэмшилд 12380,7га, ашиглалтад 10786га нийт 23863,7 га, зам шугам сүлжээний газраас эзэмшилд 1764,1 га, ойн сан бүхий газраас 30838,0 га, усан

сан бүхий газраас 83 га эзэмшилд, тусгай хэрэгцээний газраас эзэмшилд 74823,2 га газрыг тус тус шилжүүлсэн байна.

**Хүснэгт 13. Газрын нэгдмэл сангийн эрх зүйн байдал
/аймгийн хэмжээгээр 2004 он/**

Газрын нэгдмэл сан	Нийт газрын талбай /га/	Өмчлөлд орсон газар	Эзэмшилд орсон газар	Ашиглагдаж байгаа газар	Бусдын эзэмшлийн ашиглалт
	243519.56	696.97	232036.59	10786	
ХАА-н газар	112147.52	-	112147,52	-	-
Хот тосгон бусад суурины газар	23863.74	696,	12380,77	10786	-
Зам шугам, сүлжээний газар	1764.1	-	1764,1	-	-
Ойн сан бүхий газар	30838.0	-	30838,0	-	-
Усан сан бүхий газар	83.0	-	83	-	-
Тусгай хэрэгцээний газар	74823.2	-	74823,2	-	-

**Хүснэгт 14. Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчдын тоо
/аймгийн хэмжээгээр 2004 он/**

Газрын нэгдмэл сан	Нийт газар эзэмшигчдийн тоо	Газар өмчлөгч	Эзэмшигч	Ашиглагч	Бусдын эзэмшлийг ашиглагч /түрээслэгч/
	18388	1896	16395	7	-
ХАА-н газар	7639	-	7639	-	-
Хот тосгон бусад суурины газар	10699	1986	8706	7	-
Зам шугам, сүлжээний газар	38	-	38	-	-
Ойн сан бүхий газар	7	-	7	-	-
Усан сан бүхий газар	1	-	1	-	-
Тусгай хэрэгцээний газар	4	-	4	-	-

3.3. Газрын үнэлгээ, төлбөр.

1997 оны Засгийн газрын 152-р тогтоолоор газрын үнэлгээний 4 үндсэн тойргийг бий болгосон ба Төв аймгийн нутаг дэвсгэр нь дээрх үнэлгээний тойргийн Хангай хэнтийн уулархаг (ХУ) болон тал нутгийн (Т) тойрогт багтана.

2004 онд аймгийн хэмжээнд 203 сая 806,8 мянган төгрөгийн төлбөр ногдуулах төлөвлөгөөтэй байснаас тайлангийн хугацаанд төлсөн төлбөр нь 208 сая 614,7 мянган төгрөгийн газрын төлбөрийн орлогыг орон нутгийн төсөвт төвлөрүүлжээ. /Газрын тайлан 2004 ГТ-8/

Газрын төлбөрийн орлогын гүйцэтгэлийг урьд оныхтой харьцуулахад бүх сумдаар өссөн дүнтэй байна. /хүснэгт 15/

Хүснэгт 15. Төв аймгийн сумдын газрын төлбөрийн орлогын өөрчлөлт

Д/Д	Сумдын нэр	2003 оны гүйцэтгэл	2004 оны гүйцэтгэл	Зөрүү /-,+/-
1	Алтанбулаг	136,0	2413,8	+2277,8
2	Аргалант	813,1	4069,8	+3256,7
3	Архуст	53,6	1147,0	+1093,4
4	Батсүмбэр	668,1	5217,4	+4549,3
5	Баян	676,6	3751,2	+3074,6
6	Баяндэлгэр	777,6	1451,2	+673,6
7	Баянжаргалант	34,0	96,3	+62,3
8	Баян-Өнжүүл	11,9	229,4	+217,5
9	Баянхангай	210,4	874,7	+664,3
10	Баянцагаан	500,0	1780,0	+1280
11	Баянцогт	460,2	4028,0	+3567,8
12	Баянчандмань	805,1	5169,0	+4363,9
13	Борнуур	1417,0	4415,2	+2998,2
14	Бүрэн	149,0	625,2	+476,2
15	Дэлгэрхаан	162,6	301,4	+138,8
16	Жаргалант	4024,5	14107,9	+10083,4
17	Заамар	116,4	93139,2	+93022,8
18	Лүн	159,2	1285,7	+1126,5
19	Мөнгөнморьт	132,8	9233,1	+9100,3
20	Өндөрширээт	45,7	522,9	+477,2
21	Сэргэлэн	5276,0	28514,3	+23238,3
22	Сүмбэр	510,8	2347,1	+1836,3
23	Угтаал	485,7	3291,0	+2805,3
24	Цээл	1901,5	7097,6	+5196,1
25	Эрдэнэ	376,4	6961,6	+6585,2
26	Эрдэнэсант	64,5	1709,9	+1645,5
27	Зуунмод	1250,7	4834,8	+3584,3

Хүснэгт 16. Төв аймгийн газрын төлбөрийн бүтэц

Д/Д	Төлбөрийн ноогдолт	Хувь
1	ХАА-н газар	29
2	Хот тосгон бусад суурины газар	64
3	Тусгай хэрэгцээний газар	7

Дээрх хүснэгтээс үзэхэд газрын төлбөрийг бүрдүүлэгч үндсэн 3 том хүчин зүйл байгаа бөгөөд төлбөрийн дийлэнхи хувийг хот тосгон бусад суурин газраас оруулсан нь харагдаж байна.

3.4. Газар хамгаалах арга хэмжээ.


Байгалийн нөөц ашигласны төлбөрийн орлогоос байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээний гол зорилго нь зах зээлийн харилцааны өнөөгийн нөхцөлд төв, орон нутагт байгаль орчныг

хамгаалах, байгалийн нөөцийг нөхөн сэргээх хөрөнгийн эх үүсвэрийг жил бүрийн төсөвт тусгаж байхаар тогтоожээ.

Газар хамгаалах арга хэмжээний аймгийн тайланг нэгтгэж үзэхэд /газрын тайлан ГТ-7/ тариалангийн газрын 8170, бэлчээрийн газарт 154782га-д, хот тосгон бусад суурин газарт 180,2га-д, ойн сан бүхий газарт 4686 га-д, усан сан бүхий газарт 15,8 га-д, уурхайн эдэлбэр газарт 425,57га талбайд тус тус хамгаалалтын арга хэмжээ авчээ. /График 2/

Диagramм 2. Газар хамгаалах арга хэмжээ

Д/Д	Газрын ангилал	хамгаалах арга хэмжээ авсан талбай	%
1	Тариалан	8170	4.9
2	Бэлчээр	154782	92
3	Хот тосгон	180.2	0.1
4	Ой	4686	2.8
5	Ус	15.8	0
6	Уурхай	425.57	0.3



Нийт тариалангийн газрын 7 хувьд нь хамгаалалтын арга хэмжээ авснаас 413 га-д олон наст тариалж, 1607 га-г зурваслан тариалж, 50 га нь ойн зурвасаар хамгаалагдаж, 4269 га шим ба эрдэс бордоогоор бордогдож, 1831 га-д хортон шавьж мэрэгчдийг устгах арга хэмжээ авсан байна. Бэлчээрийн газрын 154782 га талбай хамгаалсан нь нийт хамгаалсан талбайн 92%-ийг эзэлж байна. Үүнээс хортон шавьж мэрэгчдийн хөнөөлтэй тэмцсэн нь 30031га, хог хаягдлаас цэвэрлэсэн нь 17 га, даацыг тохируулсан нь 92195га, ашиглалтаас чөлөөлсөн 1650га, сэлгэж ашигласан 30889 га талбай байна.

Хот тосгон бусад газрын хувьд нийт 180,2 га талбайд хамгаалах арга хэмжээ авснаас хөрсжүүлж, зүлэгжүүлсэн газар 18,6га, мод бут сөөг тарьсан 5,9 га, нүх гуу жалгыг тэгшилж янзалсан 124,5 га, ахуйн хог хаягдлаас цэвэрлэсэн 31,2 га талбай байна.

Ойн сан бүхий газарт нийт 4686 га газарт нөхөн сэргээлт хийснээс ойн цэвэрлэгээ хийсэн 2199га, хортон шавьжтай тэмцсэн 2390га, мод бут сөөг тарьсан 97 га талбай байна.

Усны сан бүхий газарт нийт 15,8 га талбайг хамгаалжээ. 3,4 га-д ус хамгаалах арга хэмжээ авч 11.4 га-д усны эх булаг, эрэг орчмын газрын хөрсийг цэвэрлэж, 1 га-д усны эвдрэлээс хамгаалах арга хэмжээг тус тус гүйцэтгэсэн байна.

Уурхайн ашиглалтын явцад ухагдаж эвдэрсэн газрыг нөхөн сэргээж нийт 425,57 га талбайнаас, ухаж эвдэрсэн газрыг эргүүлэн дарж хөрсжүүлсэн 372,57га, дарж булсан талбайг хөрсжүүлж ургамалжуулсан газар 53 га- г тус тус эзэлж байна.

ДӨРӨВ. ТӨВ АЙМГИЙН НИЙГЭМ-ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, ХЭТИЙН ТӨЛӨВ

Төв аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний төлөвлөлтийн үе шатуудад нийгэм-эдийн засгийн хөгжлийн хэтийн төлөвийг тодорхойлохдоо уг төлөвлөлтөнд шаардлагатай нийгэм-эдийн засгийн хүчин зүйлсийн одоогийн байдалд дүн шинжилгээ хийж, цаашдын хандлага, хэтийн төлөвийг тодорхойлов.

Монгол Улсын газрын хуулийн дагуу газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө нь 12-16 жилийн баримжаатай төлөвлөгддөг бөгөөд энэхүү төлөвлөгөө нь 2005-2020 оныг хамарч байна. Харин төлөвлөлт нь 2000-2004 оны дундаж үзүүлэлтэнд суурилагдсан болно.

4.1. Нутаг дэвсгэрийн зохион байгуулалтын төлөвлөгөөнд харгалзсан нийгэм эдийн засгийн нөхцлүүд

Төв аймаг нь Монгол улсын хөдөөгийн аймгуудаас хүн ам, газар нутаг, эдийн засгийн чадавхийн хувьд нилээд дээгүүр төвшинд ордог, дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн бүс нутаг юм. Газар зүйн байршлын хувьд улсын нийслэл Улаанбаатар хотыг тойрсон, хамгийн холын сум нь Улаанбаатар хотоос 250 км-т, хамгийн ойрын сум нь Улаанбаатар хотоос 40 гаруй км-т байдаг.

2004 оны эцсийн байдлаар Төв аймаг нь 7404237 га нутаг дэвсгэртэй, 88.6 мянган хүн амтай, 1551.4 мянган малтай, 27 сум, 104 багтай, эдийн засгийн гол салбар нь хөдөө аж ахуй, жилд 27.6 тэрбум төгрөгний дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэдэг бөгөөд нэг хүнд 7908 га газар, 296894 мянган төгрөгийн дотоодын нийт бүтээгдэхүүн ногдож байна.

4.2. Хүн ам, нийгмийн талаарх SWOT шинжилгээ

Давуу талууд:

1. Аймгийн хүн амын тоо 2004 оны эцсийн байдлаар суурин хүнээр тооцсоноор 88.6 мянган хүн болж, нийт хүний 49.88 хувь буюу 44.2 мянга нь эрэгтэйчүүд, 50.12 хувь буюу 44.4 мянга нь эмэгтэйчүүд байна.
2. Аймгийн хэмжээнд 22498 өрх байгаагийн 55.48 хувь буюу 12483 нь аймаг, сумын төвд, 44.52 хувь буюу 10015 нь хөдөөд бүртгэгдсэн байна.
3. Нийт хүн амын 57.05 хувь буюу 50.5 мянга нь аймаг, сумын төв, сууринд, 42.95 хувь буюу 38.1 мянга нь хөдөөд амьдардаг. 1 кв. км нутагт 12 хүн ногдож байгаа нь хүн ам харьцангуй сийрэг суурьшилтайг харуулж байна.
4. 2004 онд 736 эх төрж, 740 хүүхэд бүртгэгдэн, 464 хүн нас барж, хүн амын цэвэр өсөлт 276 болжээ.
5. Аймгийн хүн амын бүтцийг насны бүлгээр авч үзвэл 0-15 насныхан 31.7 хувь, хөдөлмөрийн насныхан 61.5 хувь, тэтгэвэрийн насныхан 6.8 хувийг эзэлж байна.
6. Хөдөлмөрийн насны 54552 хүний 74.7 хувь нь буюу 40762 хүн ажиллаж байна.
7. Аймгийн дүнгээр 41943 ажиллах хүчний 98.3 хувь нь буюу 41224 нь ажил эрхэлж байна.

8. Хөдөлмөрийн насны 1000 хүнд ногдох ажиллах хүч аймгийн дүнгээр 769 хүн, ажиллагчид 756, тэжээвэр хүн 625, үүнээс хүүхэд 515, өндөр настан 110, ажилгүйчүүд 13, ажил эрхлээгүй хүн 112, хөдөлмөрийн чадваргүй хүн 52 ногдож байна.

9. Хөдөлмөрийн насны 1000 хүнд ногдох ажиллах хүч, ажиллагсдын тоо өмнөх оноосоо 7- 5 хүнээр, тэжээвэр хүмүүсийн тоо дүнгээрээ 79, үүний дотор хүүхэд 72, өндөр настан 7-гоор, ажилгүйчүүд 3, ажил эрхлээгүй хүн 20-иор тус тус буурсан байна.

10. Төв аймагт 2 дээд сургуулийн салбар, 1 коллеж, 3 мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төв, 32 ерөнхий боловсролын сургууль, 37 цэцэрлэг ажилладаг.

11. Аймгийн хэмжээнд 667 ортой 35 эмнэлэг ажиллаж, 10000 хүнд 12.1 их эмч, 22.4 сувилагч ногдож байна.

12. Тус аймагт хүн амын дундаж наслалт 64.2-т хүрч байна.

Сул талууд:

1.Төрөх насны эмэгтэйчүүдийн болон 1000 хүн амд ногдох төрөлт аймгийн

дүнгээр өсөхгүй байна.

2.Нийт төрөлтөд 20-оос доош насны төрөлтийн эзлэх хувь 7.1 байна.

3.Эхийн эндэгдэл 100000 амьд төрөлт тутмаас 136 тохиолдол гарч байна.

4.Нялхсын эндэгдэл амьд төрсөн 1000 хүүхдэд 27 байна.

5.Улаанбаатар хот болон бусад суурин газарт шилжигчдийн тоо их байгаагаас аймгийн хүн ам жилээс жилд буурч байна.

6.Төв суурин газарт хүн амын нягтрал ихэсч, хөдөөд сийрэг болж байна.

7.Хөдөлмөрийн насны хүн амын тоо 2002 оноос буурч эхэлсэн.

8.Ажилгүйчүүд хөдөлмөр зохицуулалтын албанд бүртгүүлэн ажил идэвхтэй

хайх явдал хөдөөд хангалтгүй байгаа болон ажлын байр бий болгох ажил далайцтай биш байгаагаас хөдөлмөрийн насны хөдөлмөр эрхлээгүй хүмүүсийн тоо буурахгүй байна.

9.Сумдын ИТХ-ын гаргасан мэдээгээр 2004 оны жилийн эцсийн байдлаар нийт хүн амын 16.1 хувь нь буюу 2936 өрхийн 11744 хүн ядуу амьдарч байна.

10. Ажлын байрны хангалт аймагт, ялангуяа сумдад хангалтгүй, цалин хөлсний хэмжээ бага байгаагаас мэргэжил боловсролтой, ажлын туршлагатай хүмүүс Улаанбаатар, Дархан зэрэг төв газарт шилжин явдаг.

11.Тусгайлсан мэрэгжил эзэмшээгүй, ажлын дадлага, туршлагагүй анх удаа ажилд орох гэж ажил хайж байгаа ажилгүйчүүдийн тоо буурахгүй өсөх хандлагатай байна.

Боломж

1. Аймгийн төв Зуунмод хот нь Төвийн бүсийн төв болохоор улсын хэмжээнд шийдвэрлэгдсэн.

2. Мянганы замын хэвтээ тэнхлэгийн зам Зуунмод хотыг дайран өнгөрөх болсон.

3. Олон улсын нисэхийн нөөц буудал тус аймгийн Сэргэлэн сумын Хөшгийн хөндийд төвлөрөх болсон.

Өөрчлөлтийн чиг хандлага

1-р үе шат (2005-2008 он)

1. Аймгийн хүн ам жилд дунджаар 1.4 хувиар өснө.

2. Мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвийн сургалтын хамрах хүрээг өргөтгөхийн хамт аж ахуйн байгууллага дээр хүмүүст мэргэжил олгох ажлыг нэмэгдүүлнэ.

3. Шинээр гэр бүл болсон малчин өрхийг 100- аас доошгүй малтай болгох,

малчин бус өрхийг амьжиргааны эх үүсвэртэй болгох талаар аймгаас хэрэгжүүлж эхэлсэн хөнгөлөлттэй зээлийн бодлогыг үргэлжлүүлэн хамрах хүрээг нь өргөтгөн хэрэгжүүлнэ.

4. Болвсрол, эрүүл мэндийн байгууллагуудын тоо, үйлчилгээний хүрээг нэмэгдүүлэх, мэргэжлийн боловсон хүчний хангалт, материаллаг баазыг нь бэхжүүлэх арга хэмжээг дэс дараалалтайгаар хэрэгжүүлнэ.

5. Мал аж ахуйн түүхий эдийг авах, иргэдийг өргөн хэрэгцээний бараагаар

хангах иргэдийн хувь нийлүүлсэн хоршооны байгууллагыг сум бүрт байгуулан түүнд түшиглэн боловсруулах шатны жижиг үйлдвэрийг байгуулан ажиллах бодлогыг хэрэгжүүлнэ.

6. Зуунмод сумын төвд аж үйлдвэр, технологийн парк байгуулах ажил улсын төлөвлөгөөний дагуу хийгдэнэ.

7. Хүн амын бодит орлого болон амьжиргааны төвшинг байнга нэмэгдүүлэх

ажил улсын хэмжээнд явуулах бодлогын хүрээнд хэрэгжинэ.

8. Хөдөлмөр эрхлээгүй хүмүүсийн хөдөлмөрийн насны хүнд эзлэх хувийг 10.9-д хүргэнэ.

9. Аймгийн нийт иргэдэд ядуу иргэдийн эзлэх хувийг 8.6-д хүргэнэ.

2-р үе шат (2009-2012 он)

1. 1-р үе шатны (2005-2008 он) 1-7- рт хийгдэх ажлууд энэ шатанд улам төгөлдөржиж, чанар, далайцын хувьд ахицтай хийгднэ.

2. Хөдөлмөр эрхлээгүй хүмүүсийн хөдөлмөрийн насны хүнд эзлэх хувийг 9.3 хувь хүртэл бууруулна.

3. Аймгийн нийт иргэдэд ядуу иргэдийн эзлэх хувийг 2012 оны эцсийн дүнгээр 7.0 хувь хүртэл бууруулна.

3-р үе шат (2013-2016 он)

1. 1-р үе шатны (2005-2008 он) 1-7- рт хийгдэх ажлууд энэ шатанд 2-р үе шатанд хийгдсэн ажлын үр дүн, байдлаас харгалзан улам төгөлдөржиж, чанар, далайцын хувьд ахицтай хийгднэ.

2. Хөдөлмөр эрхлээгүй хүмүүсийн хөдөлмөрийн насны нийт хүнд эзлэх хувийг 7.7 хувь хүртэл бууруулна.

3. Аймгийн нийт иргэдэд ядуу иргэдийн эзлэх хувийг 2016 оны эцэст 5.4 хувь хүртэл бууруулна.

4-р үе шат (2017-2020 он)

1. 1-р үе шатны (2005-2008 он) 1-7- рт хийгдэх ажлууд энэ шатанд 2 ба 3-р үе шатанд хийгдсэн ажлын үр дүн, байдлаас харгалзан улам төгөлдөржиж, чанар, далайцын хувьд ахицтай хийгднэ.

2. Аймгийн нийт хөдөлмөрийн насны хүнд хөдөлмөр эрхлээгүй хүмүүсийн эзлэх хувийг 2020 оны эцэст 5.0 хувьд хүргэж бууруулна.

3. Аймгийн нийт хүн амд ядуу хүмүүсийн эзлэх хувийг 4.0 хувьд хүргэж

бууруулна.

4.3. Хот байгуулалтын талаарх SWOT шинжилгээ

Давуу талууд:

1. 27 сумын төв болох орон нутгийн 27 хот байгуулагдан оршиж байна. 104 багийн төв болох орон нутгийн жижиг суурингууд үүсэн хөгжиж байна.
2. Ар, Өвөр жанчивлан, Шижир алт, Шохой –Цагаан булаг, Хөгшчүүл, Цагаан дэл, Бор хужир, Дов зэрэг рашаан сувилал, уул уурхай, зам харгуй түшсэн суурин газрууд бий болон оршиж байна.
3. Орон нутгийн хотуудын цөөн хэсэг нь буюу дөрөвний нэг орчим нь дулааны төвлөрсөн шугам сүлжээтэй байна.
3. 27 сумын төвийн нэг нь хэтийн хөгжлийн төлөвлөгөөтэй байна.
4. Хот, тосгон бусад суурин газрын эдэлбэр газрын хэмжээ (уурхайн дэвсгэр газрыг оруулахгүйгээр) 13628.5 га байна.

Сул талууд:

I- Орон нутгийн 26 хот хэтийн хөгжлийн төлөвлөгөөгүй.

II- Орон нутгийн жижиг тосгон, суурингууд “ Хот, тосгоны тухай” Монгол улсын хуулийн дагуу зохион байгуулалтад ороогүй.

III- Орон нутгийн хотын 75 хувь нь дулаан, цэвэр, бохир усны төвлөрсөн шугам сүлжээтэй болоогүй.

IV- Хот, суурин газрын газар ашиглалт боловсронгуй биш, хэтийн бодлого төлөвлөгөөгүй.

Өөрчлөлт, хөгжлийн чиг хандлага:

1-р үе шат (2005-2008 он)

1. Энэ үе шатанд нэг багийн төв шинээр байгуулагдана. Энэнд 10 га газар хувиарлагдана.
2. Хот, суурин газрын эдэлбэр газрыг зохистой ашиглах, газар ашиглалтыг нягтруулах, тохижилтыг сайжруулах, хотын архитектор, үзэмж, аюулгүй байдлын талаар хэтийн төлөвлөгөө, бодлого гаран дэс дараалалтай хөгжинө.
3. Багийн төвүүдийн хөгжлийг Аймгийн “ баг” хөтөлбөрийн хүрээнд хөгжүүлнэ.
4. Хот, тосгон бусад суурин газрын эдэлбэр газрын хэмжээ (Багийн төв- 10 га, шинээр байгуулагдах үйлдвэрийн дэвсгэр газар-90 га, бүгд 100 га-гаар нэмэгдэж) 13728.5 га-д хүрнэ.

2-р үе шат (2009-2012 он)

- 1 Нэг дүгээр үе шатанд хот байгуулалтын талаар хийгдэх ажлуудыг улам эрчимжүүлэн чанар, агуулгын төвшинг дээшлүүлнэ.
2. 2008 оны эцэст хот, тосгон бусад суурин газрын эдэлбэр газрын хэмжээ 28.5 га-гаас хэтрэхгүй төлөвтэй байна.

3 ба 4-р үе шат (2013-2016, 2017-2020 он)

1. Эдгээр үе шатанд түрүүчийн үе шатанд хийгдсэн ажлын үр дүнд шинжилгээ хийн орчин үеийн хөдөөгийн хот, тосгоныг байгуулах ажлууд хийгдэнэ.

2. Хот, тосгон ба бусад суурингийн газрын хэмжээг 2020 онд 13728.5 га-гаас хэтрүүлэхгүй байна.

4.4. Дэд бүтцийн хөгжлийн талаарх SWOT шинжилгээ:

Давуу талууд

1. Орон нутгийн хот болох бүх сумын төвүүд цахилгаан эрчим хүчний төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон. Багийн төвүүд болох суурингуудын 20 хувь нь цахилгаан эрчим хүчний төвлөрсөн шугам сүлжээнд холбогдсон.
2. Бүх сумын төвүүд нь 100 хувь цахилгаан холбооны , 22.2 хувь нь хөдөлгөөнт холбооны сүлжээнд холбогдсон.
3. Бүх сумын төвүүдийн 14.8 хувийг олон улсын төмөр зам дайран өнгөрдөг, 22.2 хувийг мянганы замын босоо, хэвтээ тэнхлэгийн зам дайран өнгөрдөг, бүх сум, багийн төвүүд аймгийн төв болон улаанбаатар хот болон бусад хотуудтай автын цардмал болон сайжруулсан замаар холбогдсон байна. 4. Бүх сумын төвүүдэд болон багийн төвийн 50.0 хувьд нь үндэсний телевизийн нэвтрүүлэг үздэг болсон байна. Мөн малчин өрхийн 25.0 орчим хувь нь үндэсний телевизийн болон орбитийн нэвтрүүлэг үздэг байна.
5. Малчин өрхийн 30 орчим хувь нь хувьдаа автомашин, трактор, мотоциклийн аль нэгтэй, зарим нь автомашин трактор, суудлын болон ачааны машины хослолтой болсон байна.

Сул талууд:

1. Цахилгаан эрчим хүчний ашиглалтын үр дүн хангалтгүй байгаа.
2. Хувийн ачааны автомашины ашиглалт сул.
3. Автозамын арчлалт, засварлалт хангалтгүй байгаа.
4. Олон улсын, улсын чанартай замуудыг бүрэн цардмал болгож чадаагүйгээс олон салаа зам гарах, бэлчээр багасах хандлагатай.
5. Малчин өрхийг цахилгаанжуулах, хөдөлгөөнт холбоогоор холбоожуулах асуудал бүрэн хэмжээнд хийгдээгүй.
6. Малчин өрх 100 хувь телевизийн нэвтрүүлэг үзэх бололцоо одоогоор бүрдээгүй байна.

Өөрчлөлт, хөгжлийн чиг хандлага

1-р үе шат (2005-2008 он)

1. Мянганы хэвтээ тэнхлэгийн зам Зуунмод хотыг дайран өнгөрнө.
2. Сэргэлэн сумын Хөшгийн хөндийд Олон улсын онгоцны нөөц буудал байгуулах ажлын эхлэлийн ажлууд (зураг төсөл зохиох, буудлын газрыг аймгийн тусгай хэрэгцээнд авах, хөрөнгө оруулалтыг улсын төсөвт тусгуулах) хийгдэнэ.
3. 3000 мянгаас дээш хүн амтай ба олон улсын болон улсын чанартай зам дагуух 10-аад сум хөдөлгөөнт холбооны сүлжээнд холбогдоно.
4. Багийн төвүүдийг цахилгаан эрчим хүчний, цахилгаан ба хөдөлгөөнт холбооны сүлжээнд холбох ажлууд дэс дараалалтай хийгдэнэ.
5. Аймаг, сумын төрийн болон боловсрол, эрүүл мэндийн байгууллагууд электрон шуудантай болох ажлууд үргэлжлэн хийгдэж эхэлнэ.
6. Малчин өрхийг цахилгаанжуулах асуудлыг “ буман гэрэл” хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлнэ.
7. Орон нутгийн замыг тэмдэгжүүлэх, сайжруулах, засварлах, байгуулах ажил аймгийн замын мастер төлөвлөгөөний дагуу хийгдэнэ.

2-р үе шат (2009-2012 он)

1. Малчин өрхийг сэргээх эрчим хүчний хэрэгслээр хангах буюу цахилгаан эрчим хүчний төвлөрсөн шугам сүлжээнд холбох замаар цахилгаанжуулна.
2. Сэргэлэн сумын Хөшгийн хөндийд байгуулах олон улсын нисэх онгоцны буудал байгуулах ажил хийгдэж дуусна.
3. Сумын төвүүдийг хөдөлгөөнт холбоонд холбох ажил гүйцээн хийгдэнэ.
4. Багийн төвүүдийг холбоожуулах ажлыг гүйцээн дуусгана.
5. Малчин өрхийг хөдөлгөөнт холбоогоор хангах ажлууд хийгдэнэ.
6. Орон нутгийн замыг тэмдэгжүүлэх, арчлах, засварлах, байгуулах ажил аймгийн замын мастер төлөвлөгөөний дагуу хийгдэнэ.

3-р үе шат (2013-2016 он)

1. Орон нутгийн замыг аймгийн замын мастер төлөвлөгөөний дагуу сйажруулах ажлыг хийнэ.
2. Малчин өрхийг холбоожуулах асуудлыг гүйцээн шийдвэрлэнэ.
3. Өмнөх хоёр үе шатанд хийгдсэн ажлыг чанарын шинэ төвшинд гүйцээн шийдвэрлэнэ.

4-р үе шат (2017-2020 он)

1. Аймгийн дэд бүтцийн хөгжлийн асуудалд дүн шинжилгээ хийж улам сайжруулж төгөлдөржүүлэх ажил хийгдэнэ.

4.4.1. Аймгийн эдийн засгийг хөгжүүлэх талаарх SWOT шинжилгээ

2004 оны байдлаар Төв аймаг нь оны мөнгөний ханшаар 27551767.6 мянган төгрөгийн дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэсний 62.8 хувь нь буюу 17294334.7 мянган төгрөг нь анхдагч үйлдвэрлэлийн, 4.7 хувь нь буюу 1295743.9 мянган төгрөг нь хоёрдогч үйлдвэрлэлийн, 32.5 хувь нь буюу 8961689.0 мянган төгрөг нь гуравдагч үйлдвэрлэлийн бүтээгдэхүүн байна.

4.4.2. Анхдагч үйлдвэрлэлийг хөгжүүлэх талаар:

Анхдагч үйлдвэрлэлд эдийн засгийн шинжлэх ухаанд тогтсоны дагуу хөдөө аж ахуй, ан агнуур, ойн аж ахуй, уул, уурхай, олборлох аж үйлдвэр оруулан шинжилгээг хийв. Ан агнуур, ойн аж ахуйг байгалийн нөөц нь харьцангуй өсөлт багатай, байгаль орчныг хамгаалах бодлоготой уялдуулан хэтийн төлөвт энэ үйлдвэрлэлийн хэмжээг өсгөхгүйгээр 2004 оны үйлдвэрлэлийн хэмжээнд байлгах бодлого баримталсан байна.

A/ Мал аж ахуйн үйлдвэрлэл

Давуу талууд:

1. Төв аймаг 2004 оны эцсээр нийтдээ 1551.3 мянган, хонин толгойд шилжүүлсэн 2988.4 мянган, бодод шилжүүлсэн 541.6 мянган толгой малтай байна.
2. Нийт малын 44.6 хувь буюу 691.9 мянган хээлтэгч мал тоолуулсан байна.
3. 2004 оны эцсээр сүү, махны чиглэлийн үхэр, махны чиглэлийн хонь, ноолуурын чиглэлийн ямаа нийлсэн цэвэр үүлдрийн болон эрлийз 55127 толгой малтай байна.
4. Цэвэр үүлдрийн болон эрлийз мал өсгөн үржүүлэх, маллах туршлагатай малчид, мэрэгжилтэнтэй болсон байна.
5. Сүүний чиглэлийн эрчимжсэн мал аж ахуйн 50 гаруй фермийн аж ахуй үйл ажиллагаа явуулж байна.
6. Сүүний чиглэлийн үхрийн, ноолуурын чиглэлийн ямааны, махны чиглэлийн нутгийн шилмэл омгийн хонины үржлийн аж ахуй ажиллаж байна.

7. Малын тэжээл бэлтгэх тариалангийн талбай, тэжээл үйлдвэрлэх тэжээлийн үйлдвэр, цех ажиллуулах өргөн бололцоотой байна.
8. Бусад аймагтай харьцуулахад мал аж ахуйн бүтээгдэхүүнийг муутгалгүй түргэн борлуулах зах зээл ойрхон байна.
9. Мал аж ахуйн бүтээгдэхүүнийг орон нутагтаа үйлдвэрийн аргаар борлуулан зах зээлд гаргах боломж сайтай тал байна.
10. Төв аймаг нь Улаанбаатар хотыг тойрон оршдог учир мал аж ахуйн бүтээгдэхүүний эрэлт хэрэгцээ ямагт өндөр байна.

Сул талууд:

1. Цэвэр үүлдрийн болон эрлийз малын тоо цөөрсөн.
2. Сүүний чиглэлийн фермийн аж ахуй хөгжүүлэхэд материаллаг бааз сууриа бараг байхгүй болгосон учир хөрөнгө ихээхэн шаардлагатай болсон.
3. Малын тэжээл тариалан бэлтгэх, үйлдвэрлэх мэрэгшсэн аж ахуйн нэгж цөөхөнтэй болсон.
4. Гахай, шувууны аж ахуй хөгжил зогсонги байдолд орсон.

Өөрчлөлт, хөгжлийн чиг хандлага

1-р үе шат (2005-2008 он)

1. Сүү, махны чиглэлийн үхэр, махны чиглэлийн хонь, ноолуурын чиглэлийн ямааны үржлийн аж ахуйн тоо, төрлийг нэмэгдүүлэх арга хэмжээг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
2. Эрчимсэн мал аж ахуйн үйлдвэрлэл эрхэлдэг аж ахуйн нэгжийн тоог жил бүр нэмэгдүүлэх арга хэмжээг авна.
3. Мал аж ахуйн тэжээлийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх ажлыг бодлого, төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлнэ.
4. Цэвэр үүлдрийн болон эрлийз малын тоог 2008 оны эцэст 65980-д хүргэнэ.
5. Хээлтэгч малын тоог 695.1 мянган толгойд хүргэнэ.
6. Нийт малын тоог 1555.5 мянган толгойд, хонин толгойд шилжүүлснээр 3006.3 мянган толгойд хүргэнэ.

2-р үе шат (2009-2012)

1. 1-р үе шатанд хийгдэх 1-3-рт тусгагдсан ажлуудыг улам баяжуулан хэрэгжүүлнэ.
2. Цэвэр үүлдрийн болон эрлийз малын тоог 2012 онд 79255-д хүргэнэ.
3. Хээлтэгч малын тоог 2012 онд 701.8 мянган толгойд хүргэнэ.
4. Нийт малын тоог 2012 онд 1562.6 мянган толгойд, хонин толгойд шилжүүлснээр 3029.8 мянган толгойд хүргэнэ.

3, 4-р үе шат (2013-2016, 2017-2020 он)

1. 1-р үе шатны 1-3-рт тусгагдсан ажлуудыг өмнөх шатанд хийгдсэн ажлын үр дүнг улам бэхжүүлэн тоо, чанарын хувьд ахиулан үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.
2. Цэвэр үүлдрийн болон эрлийз малын тоог 2016 онд 95475 толгойд, 2020 онд 108610 толгойд хүргэнэ.
3. Хээлтэгч малын тоог 2016 онд 708.3 мянган толгойд, 2020 онд 715.0 мянган толгойд хүргэнэ.
4. Нийт малын тоог 2016 онд 1570.7 мянган толгойд, хонин толгойд шилжүүлснээр 3054.2 мянган толгойд, 2020 онд 1577.8 мянган толгойд, хонин толгойд шилжүүлснээр 3077.7 мянган толгойд хүргэнэ.

Б/ Газар тариалангийн үйлдвэрлэл

Давуу талууд:

1. Аймагт 2004 оны байдлаар нийтдээ газар тариалангийн үйлдвэрлэлд зориулагдсан 247561 га газар байна.
2. 2004 оны жилийн эцсийн байдлаар нийт тариалангийн талбайн 46.9 хувь нь буюу 116207.7 га нь бусдад гэрээгээр эзэмшигдсэн байна.

3. Нийт эзэмшигдсэн талбайн 25.1 хувь нь буюу 29141.2 га талбайд 2004 онд тариалалт явуулсан байна.
4. Төмс, хүнсний ногоо тарих талбайнуудыг бүрэн усалгаатай болгох бололцоотой байна.
5. Хураасан ургацаа(төмс, хүнсний ногоо, үр тариа) цэвэрлэх, ялгах, ангилах бололцоо, нөхцөл сайтай байна.
6. Газар тариалангийн бүтээгдэхүүнийг борлуулахад зах зээл ойрхон байдаг сайн талтай байна.
7. Газар тариаланг мал аж ахуйн үйлдвэрлэлтэй хослуулан хөгжүүлэх бололцоотой.

Сул талууд:

1. 2004 оны байдлаар тариаланд зориулагдсан нийт талбайн 53.1 хувь нь буюу 131353.3 га газар бусдад гэрээгээр эзэмшүүлэгдээгүй атаршсан байдалтай байна.
2. Эзэмшүүлсэн тариалангийн талбайн дөнгөж дөрөвний нэг орчимд нь тариалж байна.
3. Орон нутгийн бололцоог ашиглан төмс, хүнсний ногоо тариалсан талбайг бүрэн усалж чадахгүй байна.
4. Таримлын төрлийг олшруулахад сул анхаарч байна.
5. Тариалангийн бүсийн нутагт бэлчээрийн мал аж ахуй сүүлийн үед өргөн хэмжээгээр нутаглах болсон байна.

Өөрчлөлт, хөгжлийн чиг хандлага

1-р үе шат (2005-2008 он)

1. Эзэмшэгдээгүй байгаа тариалангийн талбайг эзэмшүүлэх ажлыг өргөн далайцтайгаар явуулна.
2. Эзэмшүүлсэн тариалангийн талбайн 50-иас доошгүй хувьд жил бүр тариалалт хийдэг болох ажлыг бодлоготойгоор хэрэгжүүлнэ.
3. Төмс, хүнсний ногоо тарьсан талбайг бүрэн усалгаатай болгох талаар бүх тусламж, дэмжлэгийг үзүүлж хэрэгжүүлнэ.
4. Үрийн аж ахуй, зоорийн аж ахуйг аймагт бодлого, төлөвлөгөөтэйгээр хэрэгжүүлнэ.
5. Эзэмшсэн талбайгаа бүрэн ашигласан, нэгж талбайгаас өндөр ургац авсан иргэд, аж ахуйн нэгжийг урамшуулах, алдаршуулах арга хэмжээг авч ажиллана.
6. 2008 онд нийт тариалангийн талбайн 60.2 хувийг буюу 149041 га талбайг бусдад гэрээгээр эзэмшүүлнэ.
7. Нийт эзэмшүүлсэн талбайн 35.4 хувьд буюу 52806.2 га талбайд тариалалт хийнэ.
8. 2008 он гэхэд хадлангийн 32172.4 га талбайг бусдад гэрээгээр эзэмшүүлэн өнгөц сайжруулалт хийлгэн хадлан бэлтгэдэг болно.
9. Атаршсан талбайг 2004 оныхоос 32833.3 га-гаар багасгана.

2,3,4-р үе шат (2009-2012, 2013-2016, 2017-2020 он)

1. 1-р үе шатны 1-5-рт тусгагдсан ажлуудыг 2,3,4-р үе шатанд хэмжээ, чанарыг нь улам ахиулан эрчимжүүлж ажиллана.
2. 2012 он гэхэд нийт тариалангийн талбайн 73.5 хувийг буюу 181881 га талбайг, 2016 он гэхэд нийт тариалангийн талбайн 86.7 хувийг буюу 214721 га талбайг, 2020 он гэхэд нийт тариалангийн талбайг 100 хувь буюу 247561 га талбайг бүрэн бусдад гэрээгээр эзэмшүүлсэн байна.
3. Нийт эзэмшүүлсэн талбайн 42.0 хувьд 2012 онд, 46.6 хувьд 2016 онд, 50.0 хувьд 2020 онд тариалалт явуулдаг болсон байна.

4. Тариалангийн атаршсан талбайг 2004 оныхоос 2012 он гэхэд 65673.3 га-гаар, 2016 он гэхэд 98513.3 га-гаар тус тус бууруулж, 2020 он гэхэд атаршсан тариалангийн талбайгүй болно.

5. Бусдад удаан хугацаагаар гэрээгээр эзэмшүүлж, хадлан бэлтгэдэг талбайг 2012 он гэхэд 41348.4 га, 2016 он гэхэд 50524.4 га, 2020 он гэхэд 59694.0 га-д тус тус хүргэнэ.

В/ Уул, уурхай, олборлох аж үйлдвэр

Давуу талууд:

1. Ашигт малтмалын хэрэг эрхлэх газрын гаргасан мэдээллээс үзэхэд Төв аймгийн нутаг дэвсгэр нь бүхэлдээ 1:200000 масштабын судалгаанд хамрагдсанаас гадна 1:50000 масштабын геологийн зураглал, эрлийн ажлууд 50-60 хувьд хийгдэж харьцангуй олон тооны орд, илрэлүүд тогтоогдож, олон тооны алтны ордууд ашиглагдаж байна.

2. Төв аймгийн нутаг дэвсгэрт 2002 оны байдлаар ашигт малтмалын 40 төрлийн 513 орд, илрэл тогтоогджээ.

3. Тус аймгийн нутаг нь алтны арвин их нөөцтэй. Судалгааны өнөөгийн төвшинд тогтоогдсон хойт Хэнтийн алтжилтийн бүсийн БУ, ЗУ, Өмнөд Хэнтийн бүсийн БУ, Баруун-Өмнөд Хэнтийн бүсийн ЗУ тал нь тус аймгийн нутагт багтдаг. Дээрх алтны хүдэржилтийн бүсүүдийн хүрээнд 70 гаруй орд, 90 гаруй илрэл тогтоогджээ. Үүнээс 60 гаруй орд нь ямар нэг хэмжээгээр олборлогдож байгаа бөгөөд ихэнх нь Заамар, Туулын тохойн хүдрийн дүүргүүдэд хамрагдаж байна. Энэ нь тухайн дүүргүүдэд алтны нөөц арвин, газар зүй, эдийн засаг, зам харилцаа, дэд бүтэц харьцангуй түлхүү хөгжсөн, цаашид алт олборлох хэмжээг нэмэгдүүлэх өргөн боломжтой.

4. Ховор металлын хувьд цагаан тугалганы 24 орд, 24 илрэл, гянтболдын 5 орд, 43 илрэл, молибдений 1 орд, 1 илрэл, бериллийн 5 илрэл, тантал-ниобиний 2 илрэл, мышьякийн 3 илрэл, ховор металлын 1 орд, 1 илрэл тогтоогджээ. Эдгээрээс цагаан тугалганы шороон ордууд болон гянтболдын орд, илрэл тус аймгийн нутагт нэлээд баялаг юм. Цагаан тугалга, гянтболдын ихэнх орд, илрэлүүд Цагаан даваа-Жанчивлан болон Их Хайрханы ховор металлын бүсэд байгаа юм.

5. Тус аймгийн нутагт чулуун ба хүрэн нүүрсний 9 орд, 2 илрэл, шатах занарын 2 орд, 2 илрэл, битумын 1 орд, торфын 1 илрэл, нефьтийн 1 илрэл тогтоогджээ.

6. Төв аймаг нь Улаанбаатар хотыг тойрон оршдог ба дэд бүтэц харьцангуй сайн хөгжсөн учир уул уурхайн үйлдвэрлэл эрхлэхэд өөрийн өртөг хямд учир хөрөнгө оруулагчид олноор олдох давуу талтай.

Сул талууд:

1. Ашигт малтмалын ордуудыг ашигладаг Төв аймгийн аж ахуйн нэгж байхгүй.

2. Ашигт малтмалын ордуудыг ашиглахдаа алдагдал, хаягдал ихтэйгээр ашиглаж байгаа. Энэ нь алтан дээр хууль бусаар, гар аргаар алт олборлож байгаа хүний тоо улам олширч байгаагаар тайлбарлагдана.

3. Уул уурхайн үйл ажиллагаанд хөндөгдсөн байгаль орчныг нөхөн сэргээх ажил хангалттай бишээс ихээхэн хэмжээний бэлчээр сүйтгэгдэж, тэр нь бэлчээрийн мал аж ахуйн үр ашиг, улмаар малчин иргэдийн амьжиргаанд сөргөөр нөлөөлөхөд хүрч байна.

4. Нутаг дэвсгэртээ уул уурхайн үйлдвэрлэл явуулсанаар гарч буй чирэгдэл, хохирол, хор уршигтай нь харьцуулахад орон нутгийн нийгэм, эдийн засагт төдийлөн эерэг үзүүлж чадахгүй байна.

Өөрчлөлт, хөгжлийн чиг хандлага

1-р үе шат (2005-2008 он)

1. Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэх , иргэдийг ажлын байраар ханган ажилгүйдлийг арилгах, ядуурлыг бууруулах зорилгоор ашигт малтмалын орд ашигладаг, уул уурхайн үйлдвэрлэл явуулдаг өөрийн аймгийн аж ахуйн нэгжтэй болох бодлого баримтлан ажиллана.
2. Ашигт малтмалын нөөцийг бүрэн ашиглуулах зорилгоор олборлолтын ажилд тавих орон нутгийн төрийн байгууллагын хяналтыг хуулийн хүрээнд чангатгана.
3. Нутгийн малчин иргэдийн амьжиргааны эх үүсвэр болсон бэлчээрийн мал аж ахуйн бэлчээрийн хангамжийг тооцон уул уурхайн үйлдвэрлэлд зориулан олгох газрын хэмжээг тухайн жилд нөхөн сэргээж бэлчээрт шилжүүлж буй талбайн хэмжээтэй уялдуулан зохицуулж 2004 оны үеийн төвшингөөс нэмэгдүүлэхгүй байх зарчмыг баримтлана.
4. 2008 онд уул уурхайн үйлдвэрлэлийн дэвсгэр газарт 7306.7 га-гаас илүүгүй газар олгоно..

2,3,4-р үе шат (2009-2012, 2013-2016, 2017-2020 он)

1. –р үе шатны 1-3-рт тусгагдсан ажлуудыг 2,3,4-р шат бүрт харгалзан ажиллаж, тухайн шат бүрт дүгнэлт хийн улам сайжруулах замаар ажиллана.
2. 2012 он гэхэд уул уурхайн үйлдвэрлэл явуулахад зориулж 5845.2 га, 2016 он гэхэд 4383.7 га, 2020 он гэхэд 2922.2 га-гаас илүүгүй газрыг олгох болно.

4.2.4.2. Үйлдвэржүүлэлтийн талаарх SWOT шинжилгээ:**Давуу талууд:**

1. Дэд бүтэц сайн хөгжсөн.
2. Үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнээ борлуулах гадаад, дотоод зах зээл ойрхон.
3. Мал аж ахуй, газар тариалангийн түүхий эд дээр түшиглэсэн хөнгөн хүнсний аж үйлдвэр хөгжүүлэх бололцоо сайтай.
4. Хүрэн нүүрсийг боловсруулан нийлэг эдлэл үйлдвэрлэх нөөц бололцоотой. Үүнд гадаадын хөрөнгө оруулалт авах бололцоо бүрдсэн. Энэ талаар ажиллах хүчнийг авах, сургах нөөц сайтай.
5. Аймагт аж үйлдвэрийг хөгжүүлэхэд аймгийн хөгжлийг толгойлон авч явах ажил хэрэгч хүмүүсийн туслалцаа, оролцоо авах сайн бололцоотой.

Сул талууд

1. Аймагт аж үйлдвэрийн хөгжлийг толгойлон авч явах өөрийн гэсэн аж ахуйн нэгж ховор байгаа.
2. Аймгийн хэмжээнд аж үйлдвэрийг хөгжүүлэх цэгцтэй, удаан хугацааны сайн төлөвлөгөө байхгүй байгаа.
3. Аж үйлдвэрийн мэрэгжсэн ажиллах хүчингүй байгаа.
4. Аймагт цахилгаан, дулааны эрчим хүчний үйлдвэрлэл, холбооны үйлчилгээний өөрийн өртөг Улаанбаатар хотынхтой харьцуулахад харьцангуй өндөр байгаа.
5. Аймгийн дотоодын нийт бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээнд хоёрдогч үйлдвэрлэл буюу боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүний хэмжээ 2004 оны эцсийн байдлаар дөнгөж 4.7 хувь буюу 1295743.9 мянган төгрөг байна.

Өөрчлөлт, хөгжлийн хандлага**1-р үе шат (2005-2008 он)**

1. Аймагт аж үйлдвэрийг хөгжүүлэх сайн боловсруулсан төлөвлөгөөтэй болно.
2. Баян, Баянжаргалан, Архуст сумын нутагт буй хүрэн нүүрсний ордыг түшиглэн хүрэн нүүрс боловсруулж нийлэг эд үйлдвэрлэх үйлдвэр байгуулах ажлын эхлэлийг тавина.

3. Сумын төв болгонд иргэдийн хувь нийлүүлсэн хоршоог байгуулан түүнийг түшиглэсэн мал аж ахуй, газар тариалангийн бүтээгдэхүүнийг боловсруулах аж үйлдвэрийн жижиг салбаруудыг байгуулах ажлыг эрчимжүүлэн үргэлжлүүлнэ.
4. Мэрэгжлийн сургалт үйлдвэрийн төвүүдийг аж үйлдвэрийн мэрэгшсэн ажилчин бэлтгэх чиглэлээр өөрчлөлт хийгдэнэ.
5. Аймгийн боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг 2008 оны эцэст 2295743.9 төгрөгт хүргэнэ.

2, 3, 4-р үе шат (2009-2012 , 2013-2016, 2017-2020 он)

1. Энэ үе шатуудад 1-р үе шатанд хийгдэх ажлыг улам эрчимжүүлэн төгөлдөржүүлж, аймгийн боловсруулах үйлдвэрийн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хэмжээг 2004 оны үнийн байдлаар 2012 оны эцэст 3295743.9, 2016 оны эцэст 4295743.9, 2020 оны эцэст 5295743.9 мянган төгрөгт хүргэнэ.
2. Дээрх хугацаанд жил бүр аж үйлдвэрийг хөгжүүлэх ажилд дүн шинжилгээ хийж, төлөвлөгөө бодлогодоо тодотгол хийнэ.

ТАВ. ГАЗРЫН МЕНЕЖМЕНТИЙН БОДЛОГЫН БҮСҮҮДИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Төв аймаг нь Монгол орны стратегийн болон геополитикийн хамгийн үр ашигтай байрлалтай, байгаль-цаг уурын харьцангуй тааламжтай нөхцөлтэй, монгол улсын нутагшил суурьшлын таталцлын цөм, зах зээлийн багтаамж болон дэд бүтцийн хөгжил сайтай, төрөл бүрийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх арвин их нөөц бүхий өргөн уудам нутаг дэвсгэртэй, улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалын дагуу бүсийн тулгуур төв байхаар тогтсон зэрэг хөгжлийн олон хүчин зүйлийн эерэг нөлөөлөлд багтсан. Мөн аймгийн эдийн засаг нийгмийн салбар нь сүүлийн жилүүдэд тогтвортой хөгжиж иржээ.

Иймээс тус аймгийн газар нутгийн ашиглалтыг аль болох эрчимтэй хэлбэрээр байгаа нөөц боломжид нь түшиглэн экологийн хувьд хямралгүй, эдийн засгийн үр ашигтай ашиглах асуудал ойрын 20 жилийн газар ашиглалтын бодлогыг ерөнхийд нь тодорхойлж байна.

1990 оноос өмнө монгол оронд хэрэгжиж байсан газар төлөвлөлтийн зарчим нь газрыг нийгэмд аль болох өгөөжтэй ашиглах асуудал байсан бол өнөө үед нийгмийн аливаа үйл ажиллагааг байгалийн нөөцийн даац чадавхид тохируулах, газрын доройтол болох цөлжилт, ой, ургамал, хөрс, усны нөөцийн хомсдлоос урьдчилан сэргийлэхэд чиглэгдэж байна.

Энэхүү зарчмыг баримтлан Төв аймгийн өнөөгийн болон хэтийн хөгжлийг газар ашиглалтын бодлогоор дэмжих, түүнийг эдийн засгийн хувьд ашигтай, экологийн сөрөг нөлөөлөлгүй байлгахад газрын менежментийн бодлогыг чиглүүлэхэд энэхүү ерөнхий төлөвлөгөөний зорилго оршино.

Газрын талаар төрөөс баримталж буй бодлогын хүрээнд тус аймгийн нутаг дэвсгэрийн ашиглалтыг газрын менежментийн дараахи бүсүүдээр төлөвлөв.

Үүнд:

- 1 Хөдөө аж ахуйн газрын менежментийн бүс
- 2 Хотын болон суурьшсан газрын менежментийн бүс
- 3 Зам шугам сүлжээний газрын менежментийн бүс
- 4 Ойн сангийн газрын менежментийн бүс
- 5 Усан сангийн газрын менежментийн бүс
- 6 Тусгай хэрэгцээ газар, газрыг хамгаалах, нөхөн сэргээлтийн

менежмент гэх мэт.

5.1. Хөдөө аж ахуйн газрын менежментийн бүсүүд

Монгол улсын бусад аймгийг бодвол Төв аймгийн хөдөө аж ахуйн газрын ашиглалтанд мал аж ахуйн болон газар тариалангийн үйлдвэрлэл бараг тэнцүү хөгжиж ирсэн уламжлалттай бөгөөд газар тариалангийн үйлдвэрлэлийн үндсэн хөрөнгө болсон үржил шимт хөрсний нөөцөөр улсад тэргүүлэх бүс нутаг юм.

Хөдөө аж ахуйн газрын менежментийн бүсүүд **бэлчээрийн, хадлангийн, тариалангийн** гэсэн ангиллын дагуу төлөвлөгдсөн бөгөөд хөдөө аж ахуйн барилга байгууламжийн /хашаа саравч, үтрэм зэрэг/ газры тухайн бүсийн дотор байршихаар тооцов. Эдгээр бүсээс тухайн жилд эзэмшил ашиглалтанд олгогдох газрын эрэлт хэрэгцээг сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөөгөөр зохицуулагдана. /Зураг 2/

5.1.1 Бэлчээрийн газрын менежмент

Аймгийн эдийн засгийн томоохон салбарын нэг нь бэлчээрийн мал аж ахуй бөгөөд цаашид ч зонхилох суурийг эзлэх ба уламжлалт мал аж ахуйн үйлдвэрлэл нь бэлчээрийг улирлын сэлгээт ашиглалтын хэлбэрээр ашиглаж байна.

Сүүлийн үед хот суурин, зах зээлээ бараадан малчид улирлаар нүүдэллэх нь багасаж хагас суурьшмал байдал үүссэн, мөн Улаанбаатар хот чиглэсэн их нүүдлийн гол цэг, нутаг дэвсгэрийн нилээд хэсэг нь газар тариалан болон тэжээл үйлдвэрлэлийн зориулалтаар хагалагдсан, ашигт малтмал, эрдэс баялгийн ашиглалт нэмэгдэж байгаа, аялал жуулчлалыг хөгжүүлэх түүхэн дурсгалт болон байгалийн үзэсгэлэнт газар ихтэй, Улаанбаатар хотын хүнсний хэрэглээ жилээс жилд ихсэж байгаа зэрэг нь бэлчээр ашиглалтын уламжлалт аргыг боловсронгуй болгох, суурин ба хагас суурин маллагааны аргыг уламжлалт аргатай хослон хэрэглэх шаардлага гарч байна.

Иймд улс болон бүс нутгийн хөгжил, хүн амын нутагшил суурьшлын таталцаа, бүлэг суурингийн тогтолцоог харгалзан мал аж ахуйн үйлдвэрлэлийг үе шаттайгаар эрчимжүүлэх, үүгээр дамжуулан газар ашиглалтын үр ашгийг нэмэгдүүлэх, байгалийн нөхцөл, зах зээлийн эрэлт хэрэгцээнээсээ шалтгаалан нутаг дэвсгэрийн зарим хэсэгт бэлчээрийн мал аж ахуйг дагнан хөгжүүлэхээр төлөвлөв. Гэхдээ энэ бүсэд ч бэлчээр ашиглалтыг зохих хэмжээнд горимлон хагас суурин маллагаанд шилжих боломжтой юм.

Дээрхи үндсэн шалтгаанаас хамаарч уламжлалт мал аж ахуйд түшиглэсэн бэлчээр ашиглалтын одоогийн аргын зэрэгцээ эзэмшилт ашиглалтын нарийн хувиарлалт бүхий суурьшмал болон хагас суурьшмал ашиглалтын зарим хэлбэрийг оруулж төлөвлөв.

Судалгаанаас үзвэл тус аймгийн баруун ба баруун хойт талын сумдад эрчимжсэн аж ахуйг бүсийн хэмжээнд хөгжүүлэх боломж байна. Гэхдээ хээрийн сумдад хүн амын суурьшил, зах зээлийн эрэлт хэрэгцээг харгалзан боломжийг газарт суурьшмал ба хагас суурьшмал аж ахуйнууд хөгжих боловч бэлчээр ашиглалтын голлох хэлбэр нь уламжлалт аргаар зохион байгуулагдахаар байна.

5.1.1.1. Хуваарьт эдлэн эзэмшилтэй нарийн төрөлжсөн суурьшмал аж ахуйн бүс

Сүүлийн жилүүдэд Улаанбаатар хотын эрэлт хэрэгцээнд зохицуулан Төв аймгийн төдийгүй, Улаанбаатар хотын зарим иргэд аж ахуйн нэгж байгууллага фермерийн аж ахуйг хөгжүүлэх асуудал нилээд эрчимтэй өрнөж байна. Эдгээр нь голдуу хуучин сангийн аж ахуй байсан Баянчандмань, Борнуур, Батсүмбэр, Сүмбэр, Алтанбулаг зэрэг сумдад түлхүү хөгжжээ. Эдгээрийн дийлэнхи нь сүүний чиглэлийг баримталж байгаа боловч махны чиглэлийн эрчимжсэн аж ахуйнууд ч хөгжиж байна.

Энэхүү бүсийн газар зохион байгуулалтын онцлог нь юуны өмнө олгогдох газрын хэмжээ нь урьдчилан нормчлогдож, нарийн төрөлжүүлэн хуваарилах ба эрчимжсэн мал аж ахуй эрхлэх фермерүүд, аж ахуйн нэгжид уг газрыг гэрээний үндсэн дээр эзэмшинэ.

Зураг №3



Эрчимжсэн мал аж ахуйд үр ашигт зах зээл болон төв замаас хэр алслагдсан байдал зэрэг нь онцгой ач холбогдолтой бөгөөд стандартаар 100 хүртэл км алслагдсан бол тохиромжтой байдлын хувьд I, 100-200 хүртэл км алслагдсан бол II, 200-300 км алслагдсан бол III, 300-аас дээш км алслагдсан бол тохиромжгүй гэж үздэг. Энэхүү газар зохион байгуулалтаар төлөвлөгдсөн эрчимжсэн мал аж ахуйн бүс нь сум тус бүрд өөрийн зах зээл болон төв замаас хамгийн холдоо 50 км орчим байгаа нь алслагдсан байдлын хувьд тохиромжтой буюу 1 гэсэн үнэлгээний бүсэд байна.

Хүснэгт 17 . Төв аймгийн эрчимжсэн аж ахуйн хөгжлийн тойм

№	Сумын нэр	Тоо	Байгуулагдсан он	Чиглэл	Үхрийн тоо	Жилд нэг үнээнээс саасан сүү /л/
1	Алтанбулаг	3	2001-2003	Сүү	45	3200
2	Аргалант	1	2001	Сүү	21	1200
3	Батсүмбэр	31	1992-2004	Сүү	1122	63130
4	Борнуур	7	1975-2003	ГХТ	322	9222
5	Баянчандмань	16	2003	Сүү	377	3080
6	Жаргалант	1	2004	Сүү	70	
7	Аргалант	2	2003-2004	Сүү	36	
7	Зуунмод	1	2001	Сүү	25	960
9	Сүмбэр	5	2003	Сүү	80	10860

Цаашид эдгээр төвүүдэд тулгуурлан байгалийн нөхцөл, хүн амын тоо, суурьшил, зах зээлийн байрлал, авто болон төмөр замын ойролцоо орших сумдад **хуваарьт эдлэн эзэмшилтэй нарийн төрөлжсөн суурьшмал аж ахуйн бүс** буюу **эрчимжсэн мал аж ахуйн бүсийг** дараахи байдлаар төлөвлөв. /Хүснэгт 18/

Хүснэгт 18. Эрчимжсэн мал аж ахуй эрхлэх боломжтой нутгийн бэлчээрийн даацын одоогийн үнэлгээ

Д/д	Хуваарьт эдлэн эзэмшилтэй нарийн төрөлжсөн суурьшмал аж ахуйн бүсийн нэр	Талбай /га/	Ургац /цн/га/	Тэжээлийн нөөц /тн/	Даац /үхэр/
1	Баянчандмань-Батсүмбэрийн нарийн төрөлжсөн суурьшмал аж ахуйн бүс	327535.4	4.2	137564.8	8453
2	Цээл-Заамарын нарийн төрөлжсөн суурьшмал аж ахуйн бүс	108657.8	3.5	38030.2	494
3	Архуст-Мөнгөнморьтын нарийн төрөлжсөн суурьшмал аж ахуйн бүс	209196.1	4.2	87862.4	2024
4	Зуунмод-Баян-Баянжаргалангийн нарийн төрөлжсөн суурьшмал аж ахуйн бүс	174997.6	2.5	43749.4	1008

5	Алтанбулаг орчмын нарийн төрөлжсөн суурьшмал аж ахуйн бүс	7931.7	3.0	2379.5	548
6	Эрдэнэсантын нарийн төрөлжсөн суурьшмал аж ахуйн бүс	113425.0	3.2	36296.0	836
Бүгд		941743.6			13363

Байгалийн бэлчээрийн даацыг тооцохдоо саалийн үнээг зуны саруудад бэлчээрээр бусад саруудад байгалийн тэжээлээр хангана гэж үзсэн учир бөгөөд дулааны улирлын 5 сард байгалийн тэжээлээр, үлдсэн сард тариалсан тэжээлээр тэжээх нөхцөлд малын тоог нэмэгдүүлэх боломжтой. Иймд одоогоор энэ бусад байгаа атаржсан болон хуучин тариаланд ашиглаж байгаад бэлчээрт шилжсэн газруудыг эргүүлэн тэжээл тариалахад хөрсний нөхцөлөөрөө тохиромжтой болно.

Харин Цээл-Заамарын болон Баян-Баянжаргалангийн нарийн төрөлжсөн суурьшмал аж ахуйн бүсэд бэлчээрийн даацыг байгалийн бэлчээрийн ургацаар тооцсон учир тэжээлийг гаднаас худалдан авах юм уу тариалангийн талбай бүхий газрыг эзэмших боломжтой.

Эрдэнэсант болон Цээл-Заамарын нарийн төрөлжсөн суурьшмал аж ахуйн бүс нь дан махны чиглэлээр хөгжих бөгөөд бусад бүсүүд нь сүүний чиглэлээр хөгжих боломжтой юм.

Хүснэгт 19. Эрчимжсэн мал аж ахуйн тоо

Д/д	Бүсийн нэр	Даац /үхэр/	1 аж ахуйд байх үхрийн тоо	Аж ахуйн тоо
1	Баянчандмань-Батсүмбэрийн нарийн төрөлжсөн суурьшмал аж ахуйн бүс	8453	50-100	85-170
2	Цээл-Заамарын нарийн төрөлжсөн суурьшмал аж ахуйн бүс	494	50-100	5-10
3	Архуст-Мөнгөнморьтын нарийн төрөлжсөн суурьшмал аж ахуйн бүс	2024	50-100	20-40
4	Зуунмод-Баян-Баянжаргалангийн нарийн төрөлжсөн суурьшмал аж ахуйн бүс	1008	50-100	10-20
5	Алтанбулаг орчмын нарийн төрөлжсөн суурьшмал аж ахуйн бүс	548	50-100	5-6
6	Эрдэнэсантын нарийн төрөлжсөн суурьшмал аж ахуйн бүс	836	50-100	10-20
Бүгд		13363		

Эзэмшил газрын байгалийн унаган төрхийг хадгалах, хамгаалах асуудлыг газар эзэмшигч бүрэн хариуцах ба үйлдвэрлэлийнхээ үр ашгийг дээшлүүлэх үүднээс экологид хоргүй нөхцлөөр газарт хөрөнгө оруулж, бэлчээр олгогдсон газраа хашиж хамгаалах, хөрсний үржил шимийг дээшлүүлэх, ургац нэмэгдүүлэх, үйл ажиллагаа явуулна. Эрүүл ахуйн нарийн чанд дэглэмд захирагдаж үйлдвэрлэл явуулах учир ашиг шимийн төрөлжилтийн бус мал, амьтантай холилдон нутаглах, бусдын мал дамжин өнгөрөхийг тусгай эрхзүйн актын дагуу хориглох арга хэмжээ авах шаардлагатай.

Мөн аж ахуйнууд нь өөрийн хэрэгцээт тэжээлийг тариалах чиглэлээр газар тариалан эрхлэхийг хөгжүүлж болно.

Эрчимжсэн аж ахуйн хүчин чадал нь тэжээлийн нөөцөөс шууд хамаарах ба үйлдвэрлэлийн үр ашгийг нэмэгдүүлэх үүднээс байгалийн бэлчээрийг түлхүү ашиглахаар тооцож, хүйтний улиралд малыг үр тариа, тэжээлийн манжин, сүрэл, дарш, давс хужиараар байнгын байранд тэжээнэ гэж үзээд нийтдээ 941843.6 га бэлчээр, 47976.1 га тэжээлийн талбайг ашиглахаар төлөвлөсөн болно.

Хүнсний хэрэглээ ихтэй Цээл-Заамар болон Баян-Баянжаргалангийн бүсэд тариалангийн талбай байхгүйн улмаас дан ганц бэлчээрийн даацыг тооцсон бөгөөд эрчимжсэн аж ахуй эрхлэгчид нь тэжээлээ гаднаас худалдан авах байдлаар аж ахуйн тоог эрс нэмэгдүүлэх боломжтой.

Эрчимжсэн аж ахуйн зориулалтаар төлөвлөгдсөн бүс нутагт голын хөндий, уулсын ар хөндий, хоолой дагасан хар хүрэн, хүрэн хөрстэй, ургамалшилтын хувьд баялаг, ургац сайтай, цаашид сайруулахад бэрхшээл багатай, экологийн даац сайтай газруудыг хамруулсан ба өнөөгийн байдлаар ямар нэг зохицуулалтгүй ашигласнаас бэлчээр талхлагджээ. Иймээс төлөвлөгдсөн бүсийн байгаль орчны тэнцвэрийг хадгалах, нэгэнт доройтолд орсон газрыг нөхөн сэргээх, усны эх булгийг хамгаалах арга хэмжээг авах нь чухал байна.

5.1.1.2. Хуваарьт эдлэн болон нийтийн ашиглалтын газартай хосолмол аж ахуйн суурьшлын бүс

Зах зээлийн багтаамжаар төдийлөн сайнгүй, зөвхөн дотоодын хэрэгцээг хангах үйлдвэрлэл үйлчилгээг өрхийн аж ахуйн болон хоршооны хэмжээнд эрхэлж сүү ба махны чиглэлийн үхэр, хонь, адууны эрчимжсэн аж ахуйг уламжлалт болон хагас суурин маллагааны аргаар хөгжүүлэх бүс нутгийг энэ ангилалд хамруулав.

Энэ нь одоогийн хагас суурин маллагааны аргатай ижил боловч газар зохион байгуулалтын хувьд нийтийн ашиглалтын бэлчээрээс илүү оновчтой арга хэмжээг шаардана.

Газар зохион байгуулалтын онцлог нь олгогдох газрын хэмжээг нарийн нормчилж, төрөлжүүлэхгүй боловч аж ахуй эрхлэгчдийн хүсэлтээр газрыг сонгон гэрээний үндсэн дээр малчдад болон малчдын хамтлагуудад эзэмшүүлнэ.

Газар ашиглалтыг сайжруулах, үр шимийг нэмэгдүүлэхийн тулд аж ахуй болон малчдын хамтлаг дундын хоршилтыг дэмжиж, газрын байгалийн унаган төрхийг хадгалах, хамгаалах асуудлыг малчид ба хамтлагууд бүрэн хариуцаж бэлчээр зохион байгуулалтыг нарийвчлан төлөвлөх шаардлагатай. Үйлдвэрлэлийнхээ үр ашгийг дээшлүүлэх үүднээс экологид хоргүй нөхцлөөр газарт хөрөнгө оруулж, эдлэн газраа хашиж хамгаалах, хөрсний үржил шимийг дээшлүүлэх, ургац нэмэгдүүлэх, үйл ажиллагаа явуулахыг зөвшөөрнө.

Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд энэ бүс нутгийг гол төлөв аялал жуулчлал харьцангуй хөгжсөн ба төв зам дагуу байрладаг боловч байнгын зах зээлээс алслагдсан, бүтээгдэхүүн борлуулах хугацаа нь хязгаарлагдмал бүсүүдэд төлөвлөв. Энд нийт 464532.8 га буюу нийт нутаг дэвсгэрийн 6.2 хувийг хамарсан. /Хүснэгт 20/

Хүснэгт 20. Бүс нутаг дахь бэлчээрийн даац

Д/д	Байршил	Талбай /га/	Ургац /цн/га/	Тэжээлийн нөөц /тн/	Бэлчээрийн даац /үхэр/	Бэлчээрийн даац /хонь/
1	Баянчандмань-Батсүмбэрийн нарийн төрөлжсөн суурьшмал аж ахуйн бүсийн баруун хэсэг	117319.4	4.2	49274.14	1325	79474
2	Баянчандмань-Батсүмбэрийн нарийн төрөлжсөн суурьшмал аж ахуйн бүсийн зүүн хэсэг	163468.2	4.2	68656.64	1582	110737
3	Баянчандмань-Батсүмбэрийн нарийн төрөлжсөн суурьшмал аж ахуйн бүсийн төв хэсэг	55662.12	4.2	23378.09	539	37707
4	Баянчандмань-Батсүмбэрийн нарийн төрөлжсөн суурьшмал аж ахуйн бүсийн баруун урд хэсэг	22874.72	4.2	9607.38	221	15496
5	Цээл-Заамарын нарийн төрөлжсөн суурьшмал аж ахуйн бүс	46110.0	3.5	16138.51	434	26030
Бүгд		405434.4				

Хүснэгтэд тус бүс газруудын бэлчээрийн даацыг тооцсон бөгөөд аж ахуй эрхлэгчид аж ахуйн малыг дан бэлчээрээр тэжээлгүй байгалийн тэжээл болон таримал тэжээлээр хангана гэж үзвэл нэмэгдүүлэх боломжтой юм. Хуваарьт эдлэн болон нийтийн ашиглалтын газартай хосолмол аж ахуйн суурьшлын бүсэд дан ганц үхрийн аж ахуй биш ямарч төрлийн малтай байхыг зөвшөөрөх ба гагцхүү тухайн аж ахуй нь тодорхой хугацааны туршид боломжит үед ашиг олж байх нь чухал юм. Тус бүсийн онцлог нь хуваарьт эдлэн эзэмшилтэй аж ахуйг бодвол нийтийн ашиглалтын газрыг ашигладаг тул хүн малын нягтрал ихтэй хэсэгт бага зэрэг талхлагдсан бөгөөд цаашид газрын ачааллыг хэтрүүлэхгүй зөв зохицуулах шаардлагатай.

5.1.1.3 Өрхийн мал аж ахуйн суурьшлын бүс

Төв аймгийн хувьд өрхийн мал аж ахуйн бүс нь газар тариалангийн төрөлжсөн үйлдвэрлэл эрхлэх бүсийн орчимд төлөвлөгдөж байгаа бөгөөд өөрийн хэрэгцээг хангах цөөн тооны мал бүхий газар тариалан эрхлэгчдэд зориулан төлөвлөсөн болно.

Энд Цээл-Заамарын ихэнх хэсэг, Баянчандмань-Батсүмбэрийн бүсийн урд хэсэг нийт 680050.3 га газрыг төлөвлөсөн. Дээрх газруудад иргэд газар тариаланг төрөлжүүлэн эрхэлж, мал аж ахуйг өрхийн хэрэгцээнд зориулан эрхэлнэ. Газрын төлөв байдал, чанарын асуудлыг өрхүүд хариуцна. Бүс дэхь малын тоог түрээсийн төлбөрөөр зохицуулж, хариуцлага хүлээлгэх байдлаар газрыг хамгаалах арга хэмжээ авахыг зөвшөөрнө.

5.1.1.4. Чөлөөт ашиглалтын бүс

Хөдөө аж ахуй түүний дотор мал аж ахуйн үйлдвэрлэл зонхилсон. Төв аймгийн хувьд чөлөөт ашиглалтын бүсийн бэлчээр давамгайлна. Энэ бүсэд уламжлалт мал аж ахуйг хөгжүүлэхээр төлөвлөсөн бөгөөд улирлын бэлчээрийн хил заагийг ялгаж гаргалаа.

Газар зохион байгуулалт нь бэлчээр ашиглалтын уламжлалт аргад үндэслэгдэнэ. Үүнд улирлын сэлгээтэйгээр бэлчээрийг нийт дундаа ашиглуулах асуудлыг орон нутгийн төр захиргааны шийдвэрээр зохицуулах ба бэлчээр эзэмшүүлэхийг хориглоно. Малчид газрыг зөв зохистой ашиглах хамгаалах үүрэгтэй бөгөөд нутаг бэлчээрийг улирлын сэлгээ болон отор сонгох замаар ашиглана.

Чөлөөт ашиглалтын бэлчээрийг усжуулах асуудлыг төрөөс шийдэх боловч өөрсдийн хөрөнгөөр худаг гаргасан тохиолдолд зохих урамшуулал хөнгөлөлтийг хуулийн хүрээнд хэрэгжүүлнэ. Тус аймгийн хэмжээнд нийт 3751812.7 га газрыг чөлөөт ашиглалтын бүсийн бэлчээрт төлөвлөсөн бөгөөд энэ нь нийт нутаг дэвсгэрийн 50.6 гаруй хувь нь энэ бүсэд хамрагдаж байна. /Хүснэгт 21/

Хүснэгт 21. Зун-намрын улирлын бэлчээрийн даац

Д/д	Байршил	Бэлчээр			Бэлчээрийн даац /хонь/
		Талбай /га/	Малд идэгдэх ургац /цн/га/	Тэжээлийн нөөц /тн/	
1	Алтанбулаг	87878.42	2.5	21969.60	35435
2	Архуст	11483.75	4.2	4823.17	7779
3	Баян	37115.77	1.7	6309.68	10177
4	Баяндэлгэр	36988.46	4	14795.38	23864
5	Баянжаргалан	112203.55	1.7	19074.60	30765
6	Баян-Өнжүүл	169628.54	2	33925.71	54719
7	Баянхангай	13693.34	3.5	4792.67	7730
8	Баянцагаан	186460.36	1.7	31698.26	51126
9	Бүрэн	151129.74	2	30225.95	48752
10	Дэлгэрхаан	55280.67	2.1	11608.94	18724
11	Заамар	3718.78	3.5	1301.57	2099
12	Лүн	52669.91	3.4	17907.77	28883
13	Мөнгөнморьт	96057.98	4.2	40344.35	65072
14	Өндөрширээт	57912.86	2.5	14478.21	23352
15	Сэргэлэн	196700.4	2.7	53109.1	85660
16	Угтаал	395.33	3.5	138.37	223
17	Эрдэнэ	29757.16	4.2	12498.01	20158
18	Эрдэнэсант	98219.25	3.4	33394.55	53862

Зун-намрын бэлчээр нь голдуу томоохон голууд болон худаг ус ойролцоо байдаг нь бэлчээрийг талхлагдалд оруулахад хүргэдэг бөгөөд судалгаанаас харахад зун-намрын улирлын бэлчээр талхлагдалд их өртсөн байна.

Хүснэгт 22. Өвөл-хаврын улирлын бэлчээрийн даац

Д/д	Байршил	Бэлчээр			Бэлчээрийн даац /хонь/
		Талбай /га/	Малд идэгдэх ургац /цн/га/	Тэжээлийн нөөц /тн/	
1	Алтанбулаг	394686.24	2.5	98671.56	159148
2	Аргалант	20780.19	4.2	8727.6781	14077
3	Архуст	29989.15	4.2	12595.441	20315
4	Баян	181554.95	1.7	30864.342	49781
5	Баяндэлгэр	89671.708	4	35868.683	57853
6	Баянжаргалан	132832.58	1.7	22581.539	36422
7	Баян-Өнжүүл	243475.45	2	48695.09	78540
8	Баянхангай	20140.866	3.5	7049.3031	11370
9	Баянцагаан	307274.87	1.7	52236.727	84253
10	Бүрэн	192643.99	2	38528.798	62143
11	Дэлгэрхаан	160089.22	2.1	33618.736	54224
12	Заамар	27858.026	3.5	9750.3091	15726
13	Лүн	147389.25	3.4	50112.346	80826
14	Өндөрширээт	130201.63	2.5	32550.407	52501
15	Сэргэлэн	84300.1	2.7	22761.0	36711
16	Угтаал	7158.65	3.5	2505.5275	4041
17	Эрдэнэ	122523.57	4.2	51459.901	83000
18	Эрдэнэсант	141383.35	3.4	48070.34	77533

Энэ бүсэд голдуу тал хээрийн болон цөлөрхөг хээрийн өргөн уудам нутаг дэвсгэртэй сумдууд хамрагдах ба ургамлан нөмрөг нь сийрэг тачир, ургац багатай, хөнгөн хөрстэй, уур амьсгалын хувьд хуурайдуу байдгаас нь газрын нөхөн сэргээх чадвар маш сул байдаг онцлогтой.

5.1.1.5. Бэлчээрийн газрыг нөхөн сэргээх

Тус аймгийн хувьд газар нутгийн ихэнх хувийг ХАА-н газар тэр тусмаа бэлчээр эзэлдэг бөгөөд нийт нутгийн багахан хувь нь хад асга, элсний нүүлттэй зэрэг шалтгаанаар ашиглагдахгүй байна. /Хүснэгт 23/

Хүснэгт 23. Ашиглалт багатай бэлчээрийн байдал

Д/д	Нөлөөллийн ангилал	Талбай		Ашиглалтад тохиромжтой байдал
		га	хувь	
1	Хад асга чулуутай	3764,96	0.05	Ашиглалтанд тохиромжгүй
2	Элсний нүүлттэй	21896.62	0.29	Нөхөн сэргээлт хийх
	Дүн	25661.58	0.34	

2000-2004 онд хийгдсэн бэлчээрийн төлөв байдал чанарын хянан баталгааны судалгааны дүнгээс үзвэл нийт нутаг дэвсгэрийн 68.9 хувь нь хэвийн 31.1 хувь нь хүний үйл ажиллааны улмаас төлөв байдал, чанарын өөрчлөлттэй болжээ. /Хүснэгт 24/

Хүснэгт 24. Бэлчээрийн нөлөөлөлд өртсөн байдал

Д/д	Нөлөөллийн ангилал	Талбай		Нөхөн сэргээх газрын хэмжээ			Нөхөн сэргээх арга	Хөрөнгийн эх үүсвэр
		га	хувь	I	II	III		
1	Техногений нөлөөлөлтэй	2942.0	0.03	980.1	980.1	981.8	Хөрөнгө оруулалт	Улс, орон нутгийн болон эзэмшигч, ашиглагчийн хөрөнгөөр
2	Элсний нүүлттэй	21896.62	0.29	7298.7	7298.7	7299.22	Хөрөнгө оруулалт	Улс, орон нутгийн төсвөөр
3	Дунд зэрэг талхлагдсан	1865867.7	25.2	621955.9	621955.9	621955.9	Ашиглалтаас чөлөөлөх	Байгалийн аясаар нөхөн сэргээх
4	Их талхлагдсан	410935.2	5.55	136978.4	136978.4	136978.4	Хөрөнгө оруулалт	Улс, орон нутгийн төсвөөр

Эдгээр өөрчлөлтийн дийлэнхийг нь бэлчээрийн талхлагдал, болон техногенийн өөрчлөлт эзэлнэ. Техногений нөлөөлөл орсон газарт автозамын болон уурхайн үйл ажиллагааны улмаас эвдэрсэн газрыг хамрууллаа.

Бэлчээрийн төрх байдал, чанарын өөрчлөлтөнд орсон газрыг нөхөн сэргээх янз бүрийн арга байдаг бөгөөд эдгээрээс хөрөнгө хүч бага зарцуулах аргыг сонгох

нь зүйтэйгээс гадна уг газар хэний эзэмшилд байгаагаас шалтгаалан хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдвэрлэх нь зүйтэй:

Бэлчээрийг хамгаалах, зөв зохистой ашиглах, дунд зэрэг талхлагдалд орсон газруудыг байгалийн аясаар нь нөхөн сэргээхэд 3 сэлгээт ашиглалтын бүдүүвч ихээхэн ач холбогдолтой юм. /Хүснэгт 25/

Хүснэгт 25. Бэлчээрийг дулааны улиралд ашиглах гурван сэлгээт бүдүүвч

Ашиглах жилүүд	Бэлчээрийн хэсэг, түүнийг ашиглах дараалал		
	I хэсэг	II хэсэг	III хэсэг
Эхний жил	Зун /Ү-ҮIII сард 3 ээлжээр/	Зун намар /IX-X сард нэг ээлжээр/	Намар /X-XI сард нэг ээлжээр/
Хоёр дахь жил	Зун намар /IX-X сард нэг ээлжээр/	/X-XI сард нэг ээлжээр/	Зун /Ү-ҮIII сард 3 ээлжээр/
Гурав дахь жил	X-XI сард нэг ээлжээр	Зун /Ү-ҮIII сард 3 ээлжээр/	Зун намар /IX-X сард нэг ээлжээр/

Харин их талхлагдсан бэлчээрийг байгалийн аясаар нөхөн сэргээхэд доорхи сэлгээг хэрэглэнэ.

Хүснэгт 26. Талхлагдсан бэлчээрийг сэргээх сайжруулах сэлгээний бүдүүвч

Ашиглах дараалал /жилээр/	Бэлчээрийн хэсэг, түүний улирлаар ашиглах дараалал				
	I хэсэг	II хэсэг	III хэсэг	IV хэсэг	V хэсэг
Эхний жил	Ү-ҮIII сард 2 ээлжээр	өнжөөнө	ҮIII-IX сард 1 ээлжээр	IX-X сард 1 ээлжээр	X-XI сард 1 ээлжээр
Хоёр дахь жил	өнжөөнө	ҮIII-IX сард 1 ээлжээр	IX-X сард 1 ээлжээр	X-XI сард 1 ээлжээр	Ү-ҮIII сард 2 ээлжээр
Гурав дахь жил	ҮIII-X сард 1 ээлжээр	IX-X сард 1 ээлжээр	X-XI сард 1 ээлжээр	Ү-ҮIII сард 2 ээлжээр	өнжөөнө
Дөрөв дэхь жил	IX-X сард 1 ээлжээр	X-XI сард 1 ээлжээр	Ү-ҮIII сард 2 ээлжээр	өнжөөнө	ҮIII-IX сард 1 ээлжээр
Тав дахь жил	X-XI сард 1 ээлжээр	Ү-ҮIII сард 2 ээлжээр	өнжөөнө	ҮIII-IX сард 1 ээлжээр	IX-X сард 1 ээлжээр

Дээрхи 2 бүдүүвчийг газрын доройтлын хэмжээнд тохируулан хэрэглэхдээ бэлчээр ашиглалтын байдлыг харгалзах нь зүйтэй. Хэрэв бэлчээрийг өрхийн хэмжээнд ашигладаг бол өрхүүдэд, малчдын хамтлаг, бүлгүүд ашигладаг бол тэдгээрт хариуцуулан биелэлтийг хянах нь зүйтэй юм.

5.1.2. Хадлангийн газрын менежмент

Төв аймаг нь 59694.0 га хадлангийн газартай бөгөөд цаашид нэмж хадланд шилжүүлэх газрын нөөц хомс байна.

Хүснэгт 27. Хадлангийн газрын хэмжээ ба ашиглалтын байдал.

Д/д	Сумын нэр	Талбай		Ашиглалтын байдал
		га	хувь	
1	Алтанбулаг	2950.00	4.94	Хадлан хаддаг
2	Архуст	1730.00	2.90	Хадлан хаддаг
3	Батсүмбэр	5276.00	8.84	Хадлан хаддаг
4	Баяндэлгэр	571.00	0.96	Хадлан хаддаг
5	Баянжаргалан	717.00	1.20	Хадлан хаддаг
6	Баянхангай	2450.00	4.10	Хадлан хаддаг
7	Баянцогт	719.00	1.20	Хадлан хаддаг
8	Борнуур	3964.00	6.64	Хадлан хаддаг
9	Жаргалант	4650.00	7.79	Хадлан хаддаг
10	Заамар	4489.00	7.52	Хадлан хаддаг
11	Лүн	4200.00	7.04	Хадлан хаддаг
12	Мөнгөнморьт	8875.00	14.87	Хадлан хаддаг
13	Өндөрширээт	1370.00	2.30	Хадлан хаддаг
14	Сэргэлэн	2742.00	4.59	Хадлан хаддаг
15	Угтаалцайдам	1250.00	2.09	Хадлан хаддаг
16	Цээл	11716.00	19.63	Хадлан хаддаг
17	Эрдэнэ	2025.00	3.39	Хадлан хаддаг
	Нийт	59694.00	100.00	

Цаашид тэжээлийн нөөцийг нэмэгдүүлэх 31745.92 га бэлчээрийг хэсэгчлэн хадаж ба үүнээс жилд дунджаар 46.03 мян. тонн өвс бэлтгэх боломжтой юм.

Хүснэгт 28. Хадаж болох бэлчээрийн судалгаа

Д/д	Сумын нэр	Талбай		Ашиглалтын байдал
		га	хувь	
1	Баянчандмань	834.31	2.63	Хадаж болох бэлчээр
2	Архуст	268.60	0.85	Хадаж болох бэлчээр

3	Батсүмбэр	4292.57	13.52	Хадаж болох бэлчээр
4	Баян	5644.16	17.78	Хадаж болох бэлчээр
5	Баянжаргалан	5327.70	16.78	Хадаж болох бэлчээр
6	Баянцогт	335.07	1.06	Хадаж болох бэлчээр
7	Баянчандмань	365.44	1.15	Хадаж болох бэлчээр
8	Борнуур	2458.32	7.74	Хадаж болох бэлчээр
9	Бүрэн	83.89	0.26	Хадаж болох бэлчээр
10	Лүн	7708.11	24.28	Хадаж болох бэлчээр
11	Өндөрширээт	1935.14	6.10	Хадаж болох бэлчээр
12	Сүмбэр	265.15	0.84	Хадаж болох бэлчээр
13	Угтаалцайдам	2227.46	7.02	Хадаж болох бэлчээр
	Дүн	31745.92	100.00	

Төв аймгийн хэмжээнд томоохон тариалангийн талбайнуудын ойролцоо болон эрчимжсэн аж ахуйн бүсэд таримал болон сайжруулсан хадланг төлөвлөж байгаа бөгөөд энэ хадлангийн талбайн нийт хэмжээ 19007.49 га. Эдгээр талбайгаас авсан тэжээлийг эрчимжсэн аж ахуйн хэрэгцээнд ашиглах нь зүйтэй юм.

Хүснэгт 29. Таримал болон сайжруулсан хадлангийн газрын хэмжээ

Д/д	Сумын нэр	Талбай		Ашиглалтын байдал
		га	хувь	
1	Батсүмбэр	3756.26	19.76	Таримал болон сайжруулсан хадлан
2	Баянхангай	1796.85	9.45	Таримал болон сайжруулсан хадлан
3	Баянцагаан	572.27	3.01	Таримал болон сайжруулсан хадлан
4	Баянчандмань	267.11	1.41	Таримал болон сайжруулсан хадлан
5	Борнуур	1018.5	5.36	Таримал болон сайжруулсан хадлан
6	Жаргалант	3382.55	17.80	Таримал болон сайжруулсан хадлан
7	Лүн	352.89	1.86	Таримал болон сайжруулсан хадлан
8	Өндөрширээт	814.54	4.29	Таримал болон сайжруулсан хадлан
9	Угтаалцайдам	7046.52	37.07	Таримал хадлан

Хадлангийн газрын менежментэд бэлчээрийн газрын төлөвлөлттэй холбоотой эрчимжсэн буюу нарийн төрөлжсөн аж ахуйн орчмын хадлангийн талбайнуудыг эрчимжсэн мал аж ахуй эрхлэгчдэд эзэмшүүлэх бодлого баримтлана.

5.1.3.Тариалангийн газрын менежмент

Монгол улсад 1954-1980-аад оны үед 2 удаагийн атар газар илрүүлэх судалгаа явуулсан бөгөөд үүний хүрээнд Төв аймаг нь хөрс-цаг уурын нөхцлөөр монгол орны газар тариалангийн үндсэн бүс нутаг болох нь тогтоогджээ. Гэвч сүүлийн жилүүдэд гарч байгаа уур амьсгалын өөрчлөлтөнд хамгийн их өртөж байгаа салбар нь газар тариалан бөгөөд түүний эрсдэлийг бодитой үнэлэх шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт нотолгоо алга байна. Иймээс юуны өмнө тариалангийн талбайн дэргэд цаг уурийн харуулж байгуулж хур тунадас дулааны хэмжээ, хувиарлалтанд мониторинг хийх шаардлагатай байна.

Хөрсний агроүлдвэрлэлийн групп тогтоох судалгаагаар илэрсэн тариалангийн газарт тохиромжтой хөрс 303980.0 га илэрсэн бөгөөд газар тариалангийн үйлдвэрлэлийн хөгжлийн оргил үе болох 1980-аад оны сүүлчээр нийт 298.5 мян.га эргэлтийн талбайтай байжээ.

Үүний 50985.0 га нь ашиглалтын улмаас үржил шимээ алдаж, хөрс элэгдэл эвдрэлд орсны улмаас 1999 онд Улсын газар зохион байгуулалтын албаны даргын тушаалаар мэргэжлийн байгууллагын судалгаанд үндэслэн эргэлтээс хасч бэлчээрт шилжүүлсэн байна.

1990 оноос хойш газар тариалангийн улсын үйлдвэрийн газрууд хувьчлагдсан ба шинээр бий болсон аж ахуйн нэгжүүд эдийн засгийн чадавхи сул, байгаль-уур амьсгалын өөрчлөлт, оновчгүй зохион байгуулалт зэргээс шалтгаалж үйлдвэрлэл нь эрс буурч, ашиглах боломжтой олон арван мянган га газар ашиглалтгүй орхигдсон юм.

Тус аймаг нь одоогийн байдлаар 116207.7 га газрыг газар тариалангийн үйлдвэрлэлд ашиглаж байгаагийн 34821.0 га буюу 29.9 хувьд үр тариа тариалж, 4249.2 га буюу 3.65 хувьд төмс, хүнсний ногоо, 3968.0 га буюу 3.41 хувьд тэжээлийн ургамал, 222.8 га буюу 0.2 хувьд таримал ургамал, жимс жимсгэнэ тариалж, үлдсэн 73169.5 га буюу 62.84 хувийг уриншилсан буюу өнжөөсөн байна.

Нийт 131353.3 га газар атаршсан нь хөрсний үржил шимийн хувьд эргүүлэн тариаланд ашиглах боломжтой газрууд болно.

Төв аймаг нь нийслэл Улаанбаатар хоттой хил залгаа оршдог монгол улсын хамгийн том зах зээлийг эзэлсэн, стратегийн болон геополитикийн үр ашигтай байрлал бүхий аймгийн хувьд нутаг дэвсгэрийн ашиглалт, түүний дотор хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн өгөөж ихтэй г тариалангийн газрыг бүрэн дүүрэн ашиглах шаардлагатай бөгөөд энэхүү зарчмыг баримтлан газар тариалангийн газрын менежментийг боловсруулав.

Төв аймгийн газар тариалангийн үйлдвэрлэлийн гол бүс нь Цээл, Угтаалцайдам, Жаргалант, Сүмбэр, Борнуур, Батсүмбэр, Баянчандмань, Баянцогт, Аргалант, Эрдэнэсант, Архуст зэрэг сумд юм.

Төлөвлөлтөөр тус аймгийн хувьд нэмж атар газар хагалахгүй, одоо байгаа атаршсан талбайнуудыг эргэлтэнд оруулах, мөн улсын хөрөнгө оруулалтаар нөхөн сэргээлт хийгдсэн зарим талбайнуудыг ашиглах бодлого баримталлаа.

Төв аймгийн хувьд төлөвлөлтийн эхний үе шатанд нийт 1200 га хүчтэй элэгдэл эвдрэлд орсон атаршсан тариалангийн талбайд улсын төсвөөр нөхөн сэргээлт хийхээр төлөвлөгдсөн.

5.1.3.1. Газар тариалангийн төрөлжсөн үйлдвэрлэл эрхлэх бүсийн менежмент

Газар тариалангийн төрөлжсөн үйлдвэрлэл эрхлэх бүсийг хуучин тариалалт хийж байсан бүх сумдад төлөвлөж байгаа бөгөөд дотроо тариалалтын төрлөөр ялгаатай юм. Төмс, үр тариа тариалах бүсийг Жаргалант, Өндөрширээт, Сүмбэр сумдын зарим талбайд, төмс, хүнсний ногоо тариалах бүсийг Аргалант, Батсүмбэр, Баянцогт, Баянчандмань, Борнуур, Сэргэлэн сумдын зарим талбайд, тэжээл тариалах бүсийг Алтанбулаг, Аргалант, Архуст, Батсүмбэр, Баяндэлгэр, Баянхангай, Баянцогт, Борнуур, Жаргалант, Лүн, Эрдэнэ зэрэг сумдын зарим талбайд тус тус төлөвлөв.

Хүснэгт 30. Тариалангийн газрын менежментийн бүсүүд

Д/д	Сумын нэр	Талбайн дугаар	Талбай /га/	Тайлбар
Төмс, үр тариа хослон тариалах бүс				
1	Жаргалант	041, 042, 057	306.70	Эхний ээлжинд эзэмшүүлэх
2	Өндөрширээт	025-035	2661.80	Эзэмшүүлэх
3	Сүмбэр	001-085	8630.04	Эхний ээлжинд эзэмшүүлэх
		Бүгд	11598.54	
Төмс, хүнсний ногоо тариалах бүс				
1	Аргалант	058-065	901.05	Эзэмшүүлэх
2	Батсүмбэр	001-021,026-036, 041-118, 124-139	3083.66	Эхний ээлжинд эзэмшүүлэх
3	Баянцогт	125-127, 131-149	3630.05	Эхний ээлжинд эзэмшүүлэх
4	Баянчандмань	001-022,025-030,032-053,056-066, 072-073	3170.53	Эхний ээлжинд эзэмшүүлэх
5	Борнуур	001-213, 261-266, 326, 336-429	3230.65	Эхний ээлжинд эзэмшүүлэх
6	Сэргэлэн	001-011,014-015,019-020,026, 031, 040	908.01	Эзэмшүүлэх
		Бүгд	14923.95	
Тэжээл тариалах бүс				
1	Алтанбулаг	001-005	1243.71	Эзэмшүүлэх
2	Аргалант	001-057,066-073	15031.75	Эзэмшүүлэх
3	Архуст	001-080	17639.96	Эзэмшүүлэх
4	Батсүмбэр	022-025, 037-040, 119-123	342.67	Эхний ээлжинд эзэмшүүлэх

5	Баяндэлгэр	001-006, 009-015, 023	2614.65	Эзэмшүүлэх
6	Баянхангай	001-002, 007-011, 013-022, 025-043, 047-052, 058-098, 100-104, 108-135	12315.81	Эхний ээлжинд эзэмшүүлэх
7	Баянцогт	001-124, 128-130, 150-162	20754.53	Эхний ээлжинд эзэмшүүлэх
8	Борнуур	214-260, 267-325, 327-329, 332-335	3710.47	Эхний ээлжинд эзэмшүүлэх
9	Жаргалант	089-090, 102, 121-154	4890.81	Эхний ээлжинд эзэмшүүлэх
10	Лүн	001-019, 021-037, 039-040	3518.91	Эхний ээлжинд эзэмшүүлэх
11	Эрдэнэ	001-019	329.57	Эзэмшүүлэх
		Бүгд	82392.84	
Үр тариа тариалах бүс				
1	Жаргалант	001-008, 010-012, 014, 016-040, 043, 045-056, 058-088, 091-120, 155-276	29218.74	Эхний ээлжинд эзэмшүүлэх
2	Заамар	001-080	16758.77	Эзэмшүүлэх
3	Лүн	041-047	873.05	Эхний ээлжинд эзэмшүүлэх
4	Өндөрширээт	001-024	2761.66	Эзэмшүүлэх
5	Сүмбэр	086-091	376.24	Эхний ээлжинд эзэмшүүлэх
6	Угтаал	001-030, 032-070, 072-085, 087, 089-095, 097-187, 199-204, 206	34644.18	Эхний ээлжинд эзэмшүүлэх
7	Цээл	001-237	33242.42	Эхний ээлжинд эзэмшүүлэх
8	Эрдэнэсант	002-025, 027-045, 047-063, 065-088, 090-127	20771.35	Эхний ээлжинд эзэмшүүлэх
		Бүгд	138646.41	

Газар тариаланг төрөлжүүлэн хөгжүүлэх бүс нь голдуу зузаан ба дунд зэргийн зузаан, дунд шавранцар, дунд бага зэрэг чулуурхаг, чулуутай хүрэн ба хар хүрэн хөрс, хүнд шавранцар нугын хар хүрэн хөрс, нугын карбонатлаг бага зэрэг чулуутай хар шороон хөрс, нугын хар шороон хөрс дунд зэргийн зузаан бага зэрэг чулуурхаг, хар хүрэн, дунд зэргийн зузаан бага зэрэг чулуурхаг хүрэн, нугын хүрэн хөрс, нимгэн хүрэн, зузаан цайвар бага зэрэг чулуутай хүрэн хөрстэй бөгөөд дийлэнхи нь агро үйлдвэрлэлийн I- II зэрэглэлийн ангид хамрагдана. Харин дунд зэргийн зузаан бага зэрэг чулуурхаг хүрэн, нугын хүрэн хөрс нимгэн хүрэн, зузаан цайвар бага зэрэг чулуутай хүрэн хөрс, мөн цөлөрхөг хээрийн мараалаг, нугархаг бор хөрс нь агроүйлдвэрлэлийн III ба IV группэд хамрагдах боловч ихээхэн алаг цоог байрласан тул үйлдвэрлэлийн үйл ажиллагаанд нөлөө үзүүлэх хүчин зүйлсийн тоонд орохгүй байна.

Уур амьсгалын эрсдэл ихсэж байгаатай холбогдуулан усалгаатай тариаланг хөгжүүлэх шаардлага гарч байна.

Шинжлэх ухааны байгууллага, эрдэмтэн судлаачдын бүтээлээс харвал тус аймгийн газар тариалангийн бүх талбайг усжуулах гүний усны нөөц байхгүй нь тогтоогджээ. Иймд гадаргын ус болон хур тунадасыг зохистой ашиглах талаар нэмэлт судалгаа явуулж услах боломжтой газрыг шинээр илрүүлэх, шинээр хөв тогтоож чийгийн хуримтлалыг нэмэгдүүлэх газрыг сонгон тэргүүн ээлжинд ашиглах арга хэмжээ авах нь зүйтэй юм.

Төв аймаг байгаа услалтын системийн үзүүлэлтүүдийг дараах хүснэгтээс харж болно.

Хүснэгт 31. Инженерийн хийцтэй услалтын систем, ашиглалтын байдал

№	Услалтын системийн нэр	Услалтын системийн байршил /Солбицол/	Ашиглалтанд орсон он	Төслийн анхны хүч чадал /га/	1990 оны эхэнд байсан хүч чадал /га/	2001 оны эхэнд байсан хүч чадал /га/
1	Жаргалант	105°52' 48°30'	1967	850	532	0
2	Борнуур	106°15' 48°30'	1965	966	900	80
3	Арангат	106°14' 48°33'	1982	280	200	0
4	Батсүмбэр	106°48' 48°22'	1971	802	430	50
5	Баянгол	106°50' 48°32'	1971	34		0
6	Баянтолгой	106°44' 48°24'	1979	250	250	0
7	Уубулан	107°33' 47°50'	1974	36	36	0
8	Тогосны хоолой	107°57' 47°30'	1975	72	72	0
9	Баянчандмань	106°09' 48°09'	1975	72		0
10	Ар урт	105°04' 48°38'	1976	125	125	0
11	Гуна	105°55' 47°53'	1983	70	70	0
12	Дунд урт	105°53'		57	57	20

	48°07'				
Дүн			3578	2672	200

Эндээс харахад услалтын системийн ашиглалт ихээхэн хангалтгүй байгаа бөгөөд 2001 оны байдлаар Арангат, Баянгол, Баянтолгой, Уубулан, Тогосны хоолой, Баянчандмань, Ар урт, Гуна, Дунд уртын услалтын систем нь огт ашиглалтгүй байгаа бол Жаргалант, Борнуур, Батсүмбэрийн услалтын системүүд хүчин чадлынхаа 10 хүрэхгүй хувийг ашиглаж байна. Цаашид орчин үеийн дэвшилтэт техник технологийг хэрэглэснээр услалтын системүүдийг сэргээж ашиглах нь газар тариалангийн үйлдвэрлэлийг нэмэгдүүлэхэд ихээхэн түлхэц болно.

Энэ бүсэд орших талбайнуудыг тухайн тариалалтын төрлөөр аж ахуй эрхлэх аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд эзэмшүүлэхээс гадна цөөн хэдэн талбайг малын тэжээл, төмс, хүнсний ногоо тариалахад зориулан өмчлүүлж, эзэмшүүлж, ашиглуулж болно.

Одоогийн байдлаар тариалангийн газрын эргэн тойрны бэлчээр их талхлагдсан учир нөхөн сэргээх зорилгоор тариалалтын явцад талбай хоорондын замыг цэгцлэх замаар орчны бэлчээрийг талхлахгүй байх, нөхөн сэргээх зэрэг зохицуулалтын арга хэмжээ авах шаардлагатай.

5.1.3.2. Газар тариаланг МАА-тай хослуулан эрхлэх бүс

Газар тариаланг мал аж ахуйтай хослуулан эрхлэх бүс нь эрчимжсэн мал аж ахуйг дэмжих зорилгоор түүний тэжээлийн баазыг нэмэгдүүлэх, газар тариалангийн төрөлжсөн үйлдвэрлэх бүсийг малын хөлөөс хамгаалах, орчны хадлан бэлчээрийг талхлагдлаас сэргийлэх зорилгоор төлөвлөв.

Энэхүү бүсэд эрчимжсэн мал аж ахуйн үйлдвэрлэлээс гадна газар тариалан эрхлэгчдийн өрхийн хэрэгцээг хангасан цөөн тооны малтай байхыг зөвшөөрөх ба ихэнхи тариалангийн талбайнуудыг мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдэд урт хугацаагаар эзэмшүүлэх буюу өмчлүүлэх хэлбэрээр ашиглуулж газрыг хамгаалах нөхөн сэргээх үүргийн газар эзэмшигчдэд хариуцуулна.

Энэ бүсэд Заамар сумын зүүн хэсэг, Цээл сумын ихэнх, Угтаал сумын бүхэлдээ, Жаргалант сумын хойд хэсэг, Сүмбэр сумын ихэнх нутаг, Эрдэнэсант сумын зүүн хойд хэсэг, Бүрэн, Баян-Өнжүүл, Өндөрширээт сумдын нутгийн зааг хэсэг, нийт нутгийн 10.6 хувь буюу 677354.3 га газар хамрагдаж байна.

5.2. Хотжсон болон суурьшсан газрын менежментийн бүсүүд

Төв аймаг нь Монгол Улсын төв цэгт нийслэл хоттой нэгэн нутаг дэвсгэрийн цогцолбор болон байршдагаараа ихээхэн онцлог бөгөөд нийслэлийн хөгжлийн таталцлын босоо ба хэвтээ тэнхлэг нутаг дэвсгэрийн зохион байгуулалт, хот тосгодын хөгжил суурьшилд тэргүүлэх ач холбогдол өгч байна.

Тус аймагт засаг захиргааны харъяалал бүхий аймгийн зэрэглэлтэй хот 1, сумын төв тосгод 26 байгаагийн зэрэгцээ засаг захиргааны харъяалалгүй боловч нутагшил суурьшлын таталцлын гол хүч болох Улаанбаатар хотын нөлөө ихээхэн үүрэгтэй. Түүний хөгжлийн явц бий болсон нийгмийн болон инженерийн дэд бүтэц дагасан хэт төвлөрөл, ачааллыг бий болгож, энэхүү таталцлыг Улаанбаатарын

төвөөс гадагшлах зайгаар нь авч үзвэл Улаанбаатар хотын эдэлбэр газар-50км, хот орчмын бүс-100км, хотоос алслагдсан бүс-150км хүртэл үргэлжилж байгаа нь Төв аймгийн нутаг дэвсгэрийн бүхэлдээ Улаанбаатар хотын таталцлын бүсэд орж байна.

Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал болон 2002 онд Засгийн Газраар батлагдсан “Нийслэл Улаанбаатар хотын дэд бүсийн хөгжлийн үзэл баримтлал”, 2003 онд батлагдсан “Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө”-ний хүрээнд тус аймгийн нутагшил суурьшлын тогтолцоог үндсэн 7 бүлэг суурингаар тодорхойлжээ.

- Заамарын тулгуур төв
- Эрдэнэсантын тулгуур төв
- Баян-өнжүүлийн
- Баянцогтын тулгуур төв
- Баянчандманийн тулгуур
- Багахангайн тулгуур төв
- Багануурын тулгуур төв
- Нийслэл хотын бичил бүсийн таталцалд Алтан булаг , Батсүмбэр , Сэргэлэн сумд багтдаг.

Цахилгааны цаашдын хэрэглээ, хүчин чадлын өсөлтийн гол үзүүлэлт нь хөнгөн ба хүнсний үйлдвэр, уул уурхай, ашигт малтмалын үйлдвэр, амралт, аялал жуулчлалын салбарын хөгжил боловч одоогоор хүчин чадал ихтэй тодорхой төлөвлөсөн хөтөлбөр төсөл үгүй тул шинээр шугам сүлжээ төлөвлөөгүй, дэд станцын трансформаторын хүчин чадлын өргөтгөл хийгдэхээр байна. Хөгжлийн энэ төлөв нь аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хүрээнд нэмэлт газар шаардахааргүй байна.


Тус аймгийн хот суурингууд нь орон зайн хүрээнд цэгчилсэн байрлалтай, ерөнхийдөө хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний зарчим алдагдан барилгажсан байна.

Өнөөгийн засаг захиргааны харъяалал бүхий хот тосгодоос инженерийн нэгдсэн шугам сүлжээтэй нь Зуунмод хот бөгөөд энэ хэсэгт газар эзэмшүүлж, ашиглуулах асуудлыг аймгийн Засаг дарга шийдвэрлэх юм. Бусад хэсэгт сумын засаг дарга шийднэ. Зуунмод хотын барилгын давхаржилтын тоо 5-аас үл хэтэрнэ. Гэр хороолол болон амины орон сууц нь нам даралтын болон ердийн галлагаатай зуух хэрэглэнэ.

Зуун мод хотоос бусад сумын төвийн барилга байшин болон гэр хорооллууд нь нам даралтын болон ердийн зуухаар халдаг, 1-2 давхар барилгатай . Бохир цэвэр усны нэгдсэн системгүй байна.

Ихэнх төв суурингуудад 1980-1990 оны үед хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөө хийгдсэн боовч энэ төлөвлөгөө гүйцэд хэрэгжээгүйгээс хотын дотоод бүсчлэлийн ялгаа алдагдсан байна. Мөн орон сууц хувьчлалыг оновчгүй зохион байгуулснаар нэгдсэн дэд бүтэц бүхий сумын төвүүдийн шугам сүлжээ ажиллагаагүй болжээ.

Зураг №4



5.2.1. Хотын газар нутгийн үүргийн бүсүүд

Төв суурин газруудын хот байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжилт хангалтгүй, хотын доторхи бүсчлэл сумдад төдийгүй томоохон хотуудад ч алдагдсан нь ажиглагдлаа. Харин Зуунмод хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг 2005 онд “Кондизайн групп” компани боловсруулсан нь хараахан батлагдаагүй байна.

Хот суурингийн газрын менежментийн бүс нь тухайн ландшафтын онцлог нөхцлийг харгалзан газрыг зөв зохистой ашиглан хамгаалах, хүний ая тухтай амьдрах орчлыг бүрдүүлэх зарчмын үүднээс тогтоогдсон ба хот байгуулалт, газар зохион байгуулалтыг төлөвлөлт-ашиглалтын орон зайн шийдлээр хангаж, газрын экологийн чадавхид тохируулан нормчлохдоо газарзүйн мэдээллийн системийг ашигласнаараа онцлог боллоо. Хот суурин газрын хот байгуулалтын үнэлгээг хавсралтаар харуулав.

Харин төлөвлөлтөөр тогтоогдсон газрын менежментийн бүсийн хүрээнд барилгажуулах асуудлыг хотын хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөгөөр шийдэж, жил бүрийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусган эзэмшүүлэх, ашиглуулах, өмчлүүлэх асуудлыг шат дараатайгаар хэрэгжүүлбэл зохино.

Хот төлөвлөлтийн болон газрын харилцааны нийтлэг шаардлагын үүднээс Төв аймгийн хот суурингийн газар зохион байгуулалтын хийхдээ хот ба тосгодын доторхи функциональ бүсүүдийг ялгаж, бүс бүрийн менежментийг тодорхойллоо. /Зураг 5-32/

Хот, суурингийн хөгжлийн өнөөгийн байдал, цаашдын төвлөрөл суурьшлыг харгалзан хотын дотоод функционал бүсүүдийг дараахи байдалтай төлөвлөв.

Үүнд:

Гэр хорооллын бүс:

Энэ бүс нь эхнээсээ эмх замбараа муутай, төлөвлөгөөгүй байгуулагдсан, газарт учруулах сөрөг үр дагавар ихтэй уламжлалт-гэр сууцын хэлбэрээ хадгалсан, ердийн галлагаатай, цахилгаанаас өөр дэд бүтэцгүй хотын хүн амын дийлэнхи нь суурьшсан бүс юм. Хорооллын доторхи нийтийн эзэмшил газар нь тохижилтгүй, техник болон хүн малын нөлөөгөөр талхлагдаж хөрсний бүтэц алдагдаж тоосжсон, бохир зайлуулах системгүйгээс ахуйн шингэн хаягдал хөрсөнд шингэдэг. Энэ нь хүн амын бөөгнөрөл ихтэй томоохон хотууд болох Зуунмод хотод хөрс ба агаарын бохирдлын гол эх үүсвэр болж байна.

Гэр хорооллын хөрсний элсжилтээс үүссэн тоосжилт агаарын чанарт сөргөөр нөлөөлөхөөс гадна элсний нүүлтийг нэмэгдүүлж байна.

Гэр хорооллын газрыг оновчтой нормчлон төлөвлөж олгоогүйгээс зарим айл өрхийн хашаа цахилгаан шугам сүлжээний хамгаалалтын бүс болон худгийн эрүүл ахуйн бүсэд оржээ. Мөн гудамжны орц гарцыг төлөвлөөгүйгээс гудамжны урт хэт үргэлжилж, хүн ба машин техникт илүү явалт үүсгэж үр ашиггүй зардлыг бий болгожээ.

2003 оноос гэр бүлийн зориулалтаар газар өмчлүүлж эхэлсэн нь томоохон хотуудын төлөвлөлтийг сайжруулахад зохион байгуулалтын болоод хөрөнгө хүчний нэмэлт зардлыг үүсгэх нөхцлийг бүрдүүлж байна.

Гэр хорооллын бүсийн газрын менежментийг сайжруулан хүн амын эрүүл аюулгүй орчинд амьдрах, тогтвортой газар ашиглалтыг бүрдүүлэхэд дараахи хэдэн асуудлыг шийдэх шаардлагатай юм.

1-рт: Цахилгаан шугам сүлжээний хамгаалалтын бүс, худгийн болон голын усны эрүүл ахуйн бүсэд суурьшсан айл өрхүүдийг нүүлгэн шилжүүлэх

2-рт: Гэр хорооллын гудамжны зохион байгуулалтыг сайжруулан орц гарцтай болгох, хэт үргэлжилсэн гудамнуудыг таслан нэвтрэх замыг чөлөөлөх

3-рт: Нийтийн эзэмшил газар, айлуудын хашааны газрыг зүлэг болон бусад ногоон байгууламжтай болгох замаар гэр хорооллын газрыг нөхөн сэргээх, хамгаалах, тохижуулах

4-рт Газрын төлбөрийг өрх бүрт бүрэн хэмжээгээр ногдуулан, харин газраа хамгаалсан нөхөн сэргээсэн айл өрхүүдэд төлбөр татварын хөнгөлөлт үзүүлэх

5-рт хот суурингуудын салхины дээд талд байрлах болон дэд бүтэц хөгжсөн захиргаа албан газрын бүстэй ойролцоо байрших гэр хорооллуудыг амины орон сууцны зориулалтаар ашиглах

Төлөвлөлтийн хугацаанд хот суурингийн хүн амын нөхөн болон механик өсөлт хотуудад янз бүр байх боловч Зуунмод хотод нилээд эрчимтэй байна. Нийтийн тохилог орон сууцны хангамж хүн амын өсөлтийг гүйцэхгүй нь ойлгомжтой учир гэр хорооллыг хот тэлэх бүсэд байршуулахаар төлөвлөгөөнд тусгалаа.

Одоогийн байгаа гэр хорооллын газрын нягтралыг сайжруулан гудамжнуудыг тэгшитгэн олгох, хороололын дундах илүү орон зайг гэр бүлийн зориулалтаар эзэмшүүлэх бодлогыг баримтлан шинээр нэмж олгохоор төлөвлөсөн болно.

Нийтийн үйлчилгээний бүс:

Энэ бүсэд банк, зочид буудал, холбоо, худалдааны төвүүд, эмийн сан, дэлгүүр /барааны болон хүнсний / зэрэг үйлчилгээний газрууд хамрагддаг бөгөөд бүгдийг нэг дороос гэсэн зарчмыг баримтлан нийтийн зориулалттай орон сууцны болон амины орон сууцны бүстэй хамтатган төлөвлөв.

Ихэнх сумдын төвүүдэд энэ бүсийн зохион байгуулалт алдагдаж, үйлчилгээ иргэдээс холдож байгаа тал ажиглагдлаа. Учир нь сумдын төвүүдэд одоо байгаа үйлчилгээний төвүүд нь гэр хорооллын бүсээс нилээд алслагдсан байна.

Зуунмод хотын хувьд нийтийн үйлчилгээ нь харьцангуйгаар нэг дор төвлөрөн байршжээ.

Нийтийн үйлчилгээний бүсийн газрын менежментийг сайжруулан хүн амд үйлчилгээний хүрэлцээг нэмэгдүүлэх, эрүүл аюулгүй орчинд амьдрах, тогтвортой газар ашиглалтыг бүрдүүлэхэд дараахи асуудлыг шийдэх шаардлагатай байна.

1-рт: “Бүгдийг нэг дороос” гэсэн зарчмыг баримтлан үйлчилгээг хүн амд ойртуулан төлөвлөх шаардлагын үүднээс зарим хот суурингуудад нийтийн үйлчилгээний бүсийг нэмж төлөвлөв.

2-рт: Олонхи хот суурингуудад нийтийн үйлчилгээний бүсийн барилга байгууламжууд цэгчилсэн байршилтай бие биенээсээ салангид байгаа нь хотын өнгө үзэмж архитектурт зохисгүй нөлөөлж байгаад дүгнэлт хийж, шинээр олгох боломжгүй болсон жижиг орон зайнуудыг газар эзэмшигч ашиглагчдын эзэмшилд шилжүүлэх

3-рт: Газрыг шинээр олгохдоо архитектур орон зайн шийдлийг харгалзаж, хот байгуулалт, барилгажилтын норм, дүрмийг баримтлах

4-рт: Эзэмшил газрынхаа орчин тойрныг ногоон байгууламжтай болгосон аж ахуйн нэгж байгууллага иргэдийн газрын төлбөрийг хөнгөлөх чөлөөлөх асуудлыг хуулийн хүрээнд шийдвэрлэж байх

5-рт: Газар эзэмшигч ашиглагч нь өөрийн мэдлийн үйлчилгээний барилга байгууламжийн өнгө үзэмж, орчны газрын тохижилт үйлчилгээг хариуцах

6-рт: Бүсийн доторхи нийтийн эзэмшил газрыг нөхөн сэргээх, тохижуулахад шаардлагатай хөрөнгийг газрын төлбөрийн хэмжээтэй нь уялдуулан тогтоож, зүлэгжүүлэх, усжуулах арга хэмжээг орон нутгийн төр захиргааны байгууллага шийдвэрлэж, түүний бүрэн бүтэн байдлыг дэвсгэрийн байгууллагуудын газар эзэмшлийн гэрээнд тусган хариуцуулах

Захиргаа, албан газрын бүс:

Засаг даргын тамгын газар, сургууль, цэцэрлэг, хүн эмнэлэг, мал эмнэлэг, соёлын төв, нийгмийн даатгал, халамжийн төв, цагдаагийн хэсэг зэрэг албан газрууд энэ бүсэд байршдаг ба орон нутгийн хотуудын хамгийн тохижилт, архитектур сайтай хэсэг гэж үзэж болно.

Зуунмод хот болон Баянчандмань сумын төвөөс бусад суурингуудад нийтийн шугам сүлжээгүйгээр хөгжиж иржээ. Дээрх сумдын төвүүдэд захиргаа албан газрыг бүсийг хүн амын өсөлтийг даган тэлэх байдлаар төлөвлөсөн. Ялангуяа бүлэг суурингийн төв болох Эрдэнэсант сумд одоо байгаа нутаг дэвсгэрээсээ тэлэх болон хот суурин тэлэх нөөц газарт шинээр уг зориулалтаар газрыг олгохоор төлөвлөсөн.

Нийтийн зориулалттай орон сууцны бүс:

Захиргаа, албан газрын бүсийн орчимд хотын зэрэглэлээсээ шалтгаалан олон болон нам давхарын орон сууцнууд баригддаг бөгөөд сумын төвүүдийн 2-5 давхар орон сууцнуудыг энэ бүсэд хамруулав.

Албан байгууллага болон орон сууцны доторхи нийтийн эзэмшил газрын тохижилт туйлын хангалтгүй, зам талбайн засвар үйлчилгээ ихээхэн хоцрогдсон элсэнд дарагджээ. Орон сууц болон газар хувьчлагдсантай холбоотойгоор нам давхарын орон сууцны орчны газрыг хашаажуулж, түүнээс залгуулан гэр хороолол болгосон нь хотын газар нутгийн үүргийн бүсчлэлийг алдагдуулж байна.

Хүн амын нөхөн ба механик өсөлт, түүнтэй холбогдон гарах бүх төрлийн үйлчилгээ, Монгол Улсын Засгийн газрын 40000 айлын орон сууц хөтөлбөрийн зорилт зэргийг харгалзан Зуунмод хотод эхний ээлжинд 400 айлын орон сууц, бусад сумдын төвүүдэд 4 айлын орон сууцанд шаардагдах газрын хэмжээг төлөвлөсөн. /Хүснэгт 33/

Хүснэгт 33. Сумын төвүүдийн барилгажилтанд шаардагдах газрын хэмжээ /га-гаар/

ДД	Сумын нэр	Барилгажилтанд шаардагдах газар		
		1-р шат	2-р шат	3-р шат
1	Зуунмод	3.8	1.15	1.0
2	Бүлэг суурингийн төв	10.7	13.25	12.51
3	Сумын төвүүдэд	52.94	54	53.23

Захиргаа, албан газрын ба нийтийн орон сууцны бүсийн газрын менежментийг сайжруулан хүн амыг эрүүл аюулгүй орчинд амьдрах, тогтвортой газар ашиглалтыг бүрдүүлэх шаардлагын үүднээс дараахи асуудлыг шийдэх нь зүйтэй.

1-рт: Бүсийн доторхи барилга байгууламжуудийг архитектур орон зайн шийдэл оновчгүй голдуу бие биенээсээ салангид цэгчилсэн байршилтай байгаа нь хотын өнгө үзэмжид зохисгүй нөлөөлөөд зогсохгүй хотын дэд бүтцийг үр ашигтай ашиглахад ч сөргөөр нөлөөлж байна. Иймд шинээр олгох боломжгүй болсон жижиг орон зайнуудыг газар эзэмшигч ашиглагчдын эзэмшилд шилжүүлж тэдний хүч хөрөнгөөр тохижуулах

2-рт: Газрыг шинээр олгохдоо архитектур орон зайн шийдлийг харгалзаж, хот байгуулалт, барилгажилтын норм, дүрмийг баримтлах

3-рт: Эзэмшил газрынхаа 10- аас доошгүй хувийг ногоон байгууламжтай болгосон байгууллага, аж ахуйн нэгжийн газрын төлбөрийг хөнгөлөх чөлөөлөх асуудлыг хуулийн хүрээнд шийдвэрлэж байх

4-рт: Давхар орон сууцны оршин суугчид, орон сууц өмчлөгчдийн холбоо нийтийн эзэмшил газрын ашиглалтанд хяналт тавих, уг газрыг тохижуулахад оролцох эрх зүйн орчинг бүрдүүлэх

5-рт: Газар эзэмшигч ашиглагч нь өөрийн мэдлийн барилга байгууламжийн өнгө үзэмж, орчны газрын тохижилт үйлчилгээг хариуцах

6-рт: Бүсийн доторхи нийтийн эзэмшил газрыг нөхөн сэргээх, ногоон байгууламжийг бий болгохтой холбогдсон дэд бүтцийг бий болгох зардлыг /зүлэгжүүлэх, усжуулах, зам засвар/ орон нутгийн төр захиргааны байгууллага шийдвэрлэж, түүний бүрэн бүтэн байдлыг дэвсгэрийн байгууллага, оршин суугчдад хариуцуулах

7-рт: Энэ бүсэд хүн ба техникийн хөдөлгөөн ихтэй тул бүс доторхи замуудыг оновчтой төлөвлөх

Дэд бүтцийн бүс: Энэ бүсэд эрчим хүчний дэд станц, дизель станц, өндөр хүчдэлийн шугам, холбооны шугам, тэдгээрийн хамгаалалтын бүсийг оруулсан бөгөөд, дэд станц, дизель станц, өндөр хүчдэлийн шугамын хамгаалалтын бүсийг “Эрчим хүчний шугам сүлжээг хамгаалах дүрэм”-ийн дагуу сумын төвүүдийн дэд станцын эргэн тойрон 10 метрийн өргөнтэйгээр тогтоосон.

Дээрхи хамгаалалтын бүсэд барилга байгууламж, орон сууц, хашаа байшин барихыг хориглодог бөгөөд одоогоор хамгаалалтын бүсэд орсон гэр хороолол болон албан газрын асуудлыг даруй шийдвэрлэж баталгаатай газар, тогтвортой амьдрах нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай.

Замын хамгаалалтын бүс: Энэ бүсэд төмөр зам, авто зам болон түүний хамгаалалтын бүсийг оруулсан. Авто замын хамгаалалтын бүсийг “Авто замын тухай хууль”-ийн дагуу сумын төвийн замаас хоёр тийш 4 метр хүртэл өргөнтэйгээр тогтоосон. Зуунмод хот болон Баянцагаан сумын төвөөс бусад суурингууд нь замын сүлжээ бараг байхгүй бөгөөд оршин суугчид дураараа замбараагүй явсанаас ихэнх сумдын төвийн газар нь эвдрэлд оржээ. Бүх сумдуудад шинээр замын сүлжээ төлөвлөсөн бөгөөд сумын төвийн замыг “Хот тосгоны төлөвлөлт, барилгажилтийн норм дүрэм”-ийн дагуу 6 метрийн өргөнтэйгээр болон замын хамгаалалтын бүсийг 4 метрийн өргөнтэйгээр төлөвлөсөн. Батсүмбэр суманд төмөр замын хамгаалалтын бүсийг 120 метрийн өргөнтэйгээр тогтоосон. Цаашид төлөвлөсөн зам болон түүний хамгаалалтын бүсийн дагуу газар ашиглалтыг бүсийн зориулалтын дагуу ашиглуулах шаардлагатай.

Голын усны хамгаалалтын бүс:

Голын сав газар нь орчныхоо газруудаас ландшафтын тогтоцоороо эрс ялгаатай бөгөөд хүн болон амьтдын амьдрах орчныг байнга тэтгэж, байгалийн нөхөн сэргэх чадвар сайтай байдгаараа онцлогтой. Голын сав газрын хөрсөн бүрхэвч нь тал хөндийн хөрсийг бодвол эмзэг, хөрсний усны түвшин харьцангуй дээр, хөрсний гүнд их хэмжээний чулуулаг биетүүд хуримтлагдснаас гадаргын ус хялбар нэвшин хөрсний гүний усанд хүрдэг. Экологийн энэ байдлыг харгалзан голын хөндийн газар ашиглалтыг нарийн горимлах шаардлагатай юм. Тус аймгийн хэмжээнд хүн ам суурьшсан Зуунмод хотын нутаг дэвсгэрээр Ар асгатын гол урсан өнгөрөх бөгөөд голын хөндийд “Усны тухай хууль”, “Газрын нэгдмэл сангийн тайлан хөтлөх журам”-ын баримтлан голын эргээс хоёр тийш 50 метрийн өргөнтэйгээр голын усны хамгаалалтын бүсийг тогтоов.

Газрын менежментийг сайжруулах, байгаль орчныг хамгаалах шаардлагын үүднээс энэ бүсэд гэр хорооллын болон аж ахуйн зориулалтаар газар ашиглахыг хориглох ба зөвхөн дулааны улиралд уламжлалт аргаар малын бэлчээрт ашиглахыг зөвшөөрнө.

Газар ашиглалтын одоогийн байдлаас харвал голын усны хамгаалалтын бүсэд нилээд тооны айл өрх, албан газруудыг суурьшсан байгааг зориулалтын бүсэд даруй нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ авах.

Амины орон сууцны бүс: Энэ бүсэд инженерийн шугам сүлжээнд холбогдоогүй нэг давхар орон сууцнуудыг оруулан төлөвлөсөн бөгөөд цаашид хот төлөвлөлтөнд тавигддаг шаардлагын дагуу амины орон сууны бүсийг нэмэгдэх байдлаар төлөвлөсөн. Зуунмод хотболон сумдын төвүүдийн хувьд аймгийн төвийг тойрсон гэр хорооллын газруудаас төвийн инженерийн шугам сүлжээнд холбогдох боломжтой болон дэд бүтцийг байршуулахад зардал бага шаардагдах гэр хорооллын газруудыг энэ бүсийн зохиулалтаар ашиглахаар төлөвлөсөн. Одоо байгаа амины орон сууцны газрууд нь тохижилт туйлын хангалтгүй, зам талбайн засвар үйлчилгээ ихээхэн хоцрогдсон элсэнд дарагдсан байдалтай байна.

Энэ бүсийн газрын менежментийг сайжруулан хүн амыг эрүүл аюулгүй орчинд амьдрах, тогтвортой газар ашиглалтыг бүрдүүлэх шаардлагын үүднээс дараахи асуудлыг шийдэх нь зүйтэй.

1-рт: Уг зориулалтаар газрыг олгохдоо архитектур орон зайн шийдлийг харгалзаж, хот байгуулалт, барилгажилтын норм, дүрмийг баримтлах

3-рт: Эзэмшил газрынхаа 10- аас доошгүй хувийг ногоон байгууламжтай болгосон иргэний газрын төлбөрийг хөнгөлөх чөлөөлөх асуудлыг хуулийн хүрээнд шийдвэрлэж байх

5-рт: Газар эзэмшигч өмчлөгч нь өөрийн мэдлийн барилга байгууламжийн өнгө үзэмж, орчны газрын тохижилт үйлчилгээг хариуцах

6-рт: Бүсийн доторхи нийтийн эзэмшил газрыг нөхөн сэргээх, ногоон байгууламжийг бий болгохтой холбогдсон дэд бүтцийг бий болгох зардлыг /зүлэгжүүлэх, усжуулах, зам засвар/ орон нутгийн төр захиргааны байгууллага шийдвэрлэж, түүний бүрэн бүтэн байдлыг дэвсгэрийн байгууллага, оршин суугчдад хариуцуулах

Үйлдвэржилтийн бүс: Энэ бүс нь аль болох суурьшсан хэсгээс зайдуу салхины доод талд, голын ус, болон техникийн аюулгүй бүсэд байршуулах зарчмыг баримталсан бөгөөд хот тосгодын өнөөгийн ба хэтийн хөгжлийн төлвөөс шалтгаан бүсчлэн тогтоох шаардлагагүй юм. Одоогийн байдлаар хөдөөгийн тосгодын үйлдвэрийн газрын тоонд шатахуун түгээх станц, хөнгөн хүнсний

үйлдвэрүүд багтаж байгаа бөгөөд хүнд үйлдвэртэй сумд харьцангуй цөөн байна. Сумдын нутаг дэвсгэрт тархсан хөнгөн ба хүнсний үйлдвэрүүд хот суурингийн төв хэсгээр тархаж байрласан нь нилээд эмх замбараагүй байдалтай байна. Цаашид үйлдвэрийн газруудыг төлөвлөсөн бүсийн хүрээнд байгуулах шаардлагатай.

Түүх соёлын дурсгалыг хамгаалах бүс: Энэ бүс нь түүх соёлын дурсгалыг хадгалан хамгаалах зорилготой бөгөөд энд тухайн сумдад байгаа сүм хийд, музейн газар орно.

Спорт амралтын бүс: Энэ бүсэд наадмын талбай, биеийн тамирын талбайг оруулан төлөвлөсөн бөгөөд энэ бүсийн газар нь орчны тохижилт муугаас наадмын талбайгаас бусад нь ашиглагдахгүй болсон байна. Цаашид энэ бүсийн газрыг тохижуулан ногоон байгууламжтай болгох талаар сумын удирдлага арга хэмжээ авах шаардлагатай.

Тусгай хэрэгцээний газар: Хот суурингийн эдэлбэрт байгаа цаг уурын ажиглалтын талбай энэ ангилалд хамрагдаж байна.

Худгийн эрүүл ахуйн бүс: “Хүн амын унд ахуйн усны эх үүсвэрийн хамгаалалтын болон эрүүл ахуйн бүсийн дэглэм”-ийн дагуу гүний худгийн эргэн тойрон 50 метрийн өргөнтэйгээр эрүүл ахуйн бүс татаж одоогийн суурьшлаас чөлөөлөхөөр тусгалаа.

Худгийн эрүүл ахуйн бүсэд дараахь үйл ажиллагааг явуулахыг хориглоно.
Үүнд:

- Газрын өнгөн хөрсийг элэгдэл эвдрэлд оруулах
- Ахуйн болон үйлдвэрлэлийн зориулалттай барилга байгууламж барих
- Шатахуун түгээх цэг, автозасварын газар байгуулах
- Хог хаягдал хаях, бохир усны цооног ухах, малын хашаа саравч барих, усалгаатай тариалан эрхлэх

Хот суурин өргөжин тэлэх нөөц газар: Төв аймгийн ихэнх сумдуудын хувьд өргөжин тэлэх нөөц газар нь хязгаарлагдмал, хүн ам суурьшсан хэсэг нь сумын эдэлбэр дотор багахан талбайг хамарсан байдалтай ба газар ашиглалтын хувьд сийрэг таруу байршилтай байна. Цаашид Зуунмод, Эрдэнэсант, Баянцогт, Заамар, сумдуудаас бусад сумдын төвүүдэд одоо байгаа суурьшлын хил дотроо газар ашиглалтын коэффициентийг дээшлүүлэх замаар гэр хороолол, амины орон сууцны бүсийг нэмж төлөвлөсөн. Харин Төв аймгийн Зуунмод хотод өргөжин тэлэх нөөц газрын хэмжээ маш хязгаарлагдмал учир цаашид хотоос баруун урагш өөр газар тэлэх боломжтой. Бүлэг суурингийн төв Баянцогт, Заамар, Эрдэнэсант, Баянчандмань сумдуудад өргөжин тэлэх газрыг хүн амын өсөлттэй нь уялдуулан суурьшилд тохиромжтой газар нутгийн хүрэлцээг харгалзан, сумын төвийн эдэлбэр дотор нь төлөвлөсөн. Баянчандмань сумын хувьд сумын төвийн төв замаас баруун урагш сумын төвийн эдэлбэрийн хил хүртэл тэлэх боломжтой байна.

5.2.2. Хот өргөжин тэлэх бүс

Монгол Улсын газрын нэгдмэл сангаас хот суурингуудийн эдэлбэрт олгогдсон газрын хэмжээ нь өнөөгийн суурьшлаас хавьгүй илүү учир газрын

хүрэлцээ ихэнхи хот сууринд хүн амын өсөлт болон эрэлт хэрэгцээг бүрэн хангахаар байна.

Ер нь хотжсон газруудын нягтрал сийрэг, барилгын давхаржилт бага учир хотыг гадагш тэлэх биш одоо байгаа суурьшлыг нягтруулах байдлаар газрыг зохион байгуулах шаардлагатай.

Харин бүлэг суурингийн төв болох Эрдэнэсант сумын төвд 2020 он хүртэлх хүн амын өсөлттэй нь уялдуулан сумын төвөөс зүүн болон зүүн урагшаа 137.5 га өргөжин тэлэх газрыг төлөвлөж өгсөн. Харин Зуунмод хотын хувьд уулаар хашигдсан тул өргөжин тэлэх нөөц газар маш хязгаарлагдмал юм. Иймд гадаргын нөхцлийг харгалзан тус хотын эдэлбэрийг зөвхөн голын баруун талын хөндийгөөр баруун урагш бага зэрэг тэлнэ. **Харин дэд бүтцийн асуудал шийдснээр хотоос баруун урагш 100 га газраар хотыг тэлэх боломжтойгоор тусгалаа.**

5.3. Зам, шугам сүлжээний газрын менежмент

Газар зохион байгуулалтын дагуу зам, шугам сүлжээний газарт цахилгаан, дулаан, ус хангамж, ариутгах татуурга, зам тээвэр, холбоо, мэдээллийн зориулалтаар хот, тосгон, бусад суурины гадна олгогдсон газруудыг хамруулдаг бөгөөд тэдгээрийн үйлдвэрлэлийн технологийн онцлогийг харгалзан олгосон дэвсгэр болон зурвас газраас гадна хүрээлэн буй орчны таагүй нөлөөллөөс хамгаалахад зориулсан хамгаалалтын зурвасыг ч энэ ангилалд хамруулах шаардлага гардаг. Эдгээр хамгаалалтын зурвас нь тус тусын ангилал, зориулалтын газарт өөр байдаг ба түүн дээр зориулалтын бус үйл ажиллагаа явуулахыг бүрмөсөн хориглодог онцлогтой. /Зураг 33/

Замын газрыг төлөвлөхдөө нийслэлийг аймгийн төвүүдтэй, аймгийн төвүүдийг өөр хооронд нь холбодог замд 100 метрээр, засаг захиргааны нэг нэгжийн хүрээнд орших хот тосгон, суурин газрыг холбосон орон нутгийн чанартай замын дагуу 60 метр өргөнтэй газрыг замын байгууламжуудыг байршуулах, засварлах, арчилгаа тордолгоо хийхэд зориулан замын хамгаалалтын бүсийг тогтоодог.

Газрын нэгдмэл сангийн тайлангаас харвал тус аймагт авто замын газар 31900.0 га, шугам сүлжээний газар 4380.0 га, ус дамжуулах болон үерийн хамгаалалтын далан 80.0 га нийт 37916.0 га зам шугам сүлжээний газар байна.

Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд одоо байгаа болон цаашид улс, орон нутгийн байгууллагын бодлого, чиглэл, хөтөлбөр, төслийн хүрээнд төлөвлөгдөж буй авто болон төмөр зам, түүнд шаардагдах газрын хэмжээг тооцож гаргав.

Хүснэгт 35. Замын газрын хэмжээ

Д/д	Замын төрөл ба чиглэл	Одоо байгаа зам		Төлөвлөж буй зам	
		Замын урт /км/	Эзлэх газрын хэмжээ /га/	Замын урт /км/	Шаардлагатай газрын хэмжээ /га/
1	Улсын чанартай авто зам	558.43	8265.0		
2	Орон нутгийн чанартай	3964.72	21249.0		

	авто зам				
3	Хээрийн зам	31677.14	2372.0		
4	Баянцагаан-Багахангайн авто зам			66.96	670.6
5	Зуунмод-Мандалговийн авто зам			142.52	1544.6
6	Улаанбаатар-Батсүмбэрийн авто зам			43.22	443.5
7	Баянхангай-Булганы авто зам			130.87	2392.7
8	Зуунмод-Баянгийн авто зам			34.1	340.5
9	Төмөр зам	249.50	1636		
	Улаанбаатар-Зуунмод-Баянгийн төмөр зам			59.3	711.9
	Нийт	36447.79	33522.0	476.97	6103.8

Төв аймаг нь газар нутгийн хувьд нийслэл хотыг тойрон байрласан нь зам харилцаа хөгжихөд таатай нөлөөлсөн бөгөөд тус аймгийн нутгаар баруун зүүн болон хойд өмнөд бүсүүдийг холбосон томоохон замын сүлжээ бий болсноороо давуу талтай юм. Баруун тийш Улаанбаатар-Арвайхээр болон Улаанбаатар-Хархорины зам дайран өнгөрдөг бол зүүн тийш Улаанбаатар-Багануур, цаашлаад Хэнтий орох зам, хойд чиглэлд Улаанбаатар-Дархан-Эрдэнэтийн зам, урагшаа "Мянганы зам"-ын босоо тэнхлэн болох Улаанбаатар-Замын-Үүдийн замууд тус тус дайран өнгөрдөг. Цаашид төлөвлөлтөөр Зуунмодоос Дундговь аймаг Мандалговь орох зам, Улаанбаатараас Батсүмбэр, Баянхангайгаас Булган, Баянцагаанаас Багахангай, Зуунмодоос Баян орох замуудыг нэмж төлөвлөн хэрэгцээт газрын хэмжээг тооцож гаргалаа.

Улсын чанартай замын хамгаалалтын зурваст нийт 12651.3 га газар төлөвлөгдсөн бөгөөд энэ бүсэд замыг эвдэж гэмтээхгүй байх, замын хөдөлгөөнийг чөлөөтэй байлгах, тухайн зурвас газарт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгж байгууллага иргэд нь замын дагуух сул элсийг бэхжүүлэх, хөрсийг хамгаалах, мод бут өвслөг ургамлыг хадгалан хамгаалах, эвдрэлийн үйл явцыг зогсоох арга хэмжээ авах, зурвас дотор хог хаягдал хаях, овоолох, бохир ус зайлуулах төхөөрөмж байрлуулах, худалдаа үйлчилгээ эрхлэхийг хориглох зэрэг ашиглалтын горимыг баримтална.

Тус аймагт манай улсын төмөр замын гол сүлжээ дайран өнгөрдөг бөгөөд нийт 249.5 км урт зам, 1636.0 га газрыг эзэлдэг.

Тус аймгийн нутагт байгаа нийт цахилгаан дамжуулах шугамын урт болон холбооны шугамын урт дараах байдалтай байна. /Хүснэгт 36/

Хүснэгт 36. Цахилгаан, холбооны дамжуулах шугамын газрын хэмжээ

Д/д	Эрчим хүчний ба холбооны шугамын ангилал	Урт /км/	Эзлэх газрын хэмжээ /га/
1	110 кВ-ын шугам	85.37	340.95
2	20 кВ-ын шугам	264.30	528.59
3	35 кВ-ын шугам	1181.47	3545.81
4	220 кВ-ын шугам	523.80	7130.23
6	Харилцаа холбооны шугам	1530.16	1835.8
7	Нийт дүн	3585.10	13381.38

Эрчим хүчний шугам сүлжээний зурвасын өргөн нь цахилгаан дамжуулах шугамын хүчдлийн хэмжээнээс хамаарах бөгөөд 20 кВ хүртэлх хүчдэлтэй шугамын дагуу 20 метр, 35 кВ-ын шугамын дагуу 30 метр, 110 кВ-ын шугамын дагуу 40 метр, 220 кВ-ын шугамын дагуу 110 метр өргөнтэй хамгаалалтын зурвас тогтоох ба энэ хэмжээг хот суурины дотор 14-28 метр хүртэл багасган төлөвлөдөг бөгөөд энэ дагуу тооцож үзэхэд цахилгаан дамжуулах шугамуудын хамгаалалтын зурвас газарт зориулан нийт 12902.15 га талбайг хамгаалалтын зурвасаар тооцож, ашиглалтын дэглэмийг баримтлан ашиглана.

Харилцаа холбооны шугам сүлжээний хамгаалалтын зурвасын хувьд баганат шугам бол 10 метр, кабелийн шугам бол 5 метр, хүлээн авах станцын орчимд 300 метр голчтой байна. Энэ шугам сүлжээний хамгаалалтын зурвас 1835.8 га талбай байхаар тус төлөвлөгөөнд тусгагдлаа. /Зураг 3/

5.4.Ой ба усан сангийн газрын менежмент

5.4.1. Ойн сангийн газрын менежмент

Газрын тухай хуулийн дагуу ойн сан бүхий газарт ой мод, загтай газар, модыг нь огтолсон талбай, ойн цоорхой, зурвас болон ойг өсгөн үржүүлэхэд зориулсан газар, мөн ой тэлэн ургах боломжийг хангахуйц ойн захын тодорхой хэсгийг хамуулдаг газрын нэгдмэл сангийн тайлангаар тус аймагт нийт 192277.5 га ойн сангийн газар байгаагийн 149991.7 га нь ой бүхий газарт, 42285.8 га ой тэлж ургах газар хамрагдана.

Төв аймгийн ойн сангийн нилээд хэсэг нь Хан Хэнтийн дархан цаазат газар болон Горхи Тэрэлжийн БЦГ-т хамрагдах бөгөөд үлдсэн хувь нь Батхаан, Нагалхаан, Хустай зэрэг тусгай хамгаалалттай газар нутаг болон бусад нутаг тархсан. Ойн ашиглалт-хамгаалалтын бүсийн ангиллыг хүснэгт 37, зураг 34-д харуулав.

Хүснэгт 37. Ойн ашиглалт-хамгаалалтын ангилал

Д/д	Ашиглалт-хамгаалалтын бүсийн ангилал	Бүрэлдэхүүнд багтах газар	Талбай	
			га	хувь
1	Онцгой бүсийн ой	Хан Хэнтийн ДГ-ын онгон бүсийн ой	624.23	0.11
		Горхи Тэрэлжийн БЦГ-ын онцгой бүсийн ой	17014.04	3.13
2	Хамгаалалтын бүсийн ой	Хан Хэнтийн ДГ-ын хамгаалалтын бүсийн ой	37671.23	6.93
		Хан Хэнтийн ДГ-ын хязгаарлалтын бүсийн ой	35959.68	6.61
		Горхи Тэрэлжийн БЦГ-ын аялал жуулчлалын бүсийн ой	44029.16	8.10
		Горхи Тэрэлжийн БЦГ-ын хязгаарлалтын бүсийн ой	38231.11	7.03
		Нагалхаан БНГ-ын ой	536.43	0.10
		Хустайн БЦГ-ын ой	1809.47	0.33
		Батхаан БНГ-ын ой	514.18	0.09
3	Ашиглалтын бүсийн ой		209177.25	38.47
4	Ногоон бүс		158229.22	29.10
		Нийт	543796.00	100.0

Нийт ойн сангийн газрын 3.24 хувь нь онцгой бүсийн ой, 29.19 хувь хамгаалалтын бүсийн ой, 38.47 хувь нь ашиглалтын бүсийн ой, 29.1 хувь нь ногоон бүс эзэлж байна.

Хөрсийг усны эвдрэлээс хамгаалах, газрын доорхи болон гадаргуугийн усны тэнцлийг хадгалах зорилгоор гол горхины эх, нуурын эргэн тойронд 5 км-ээс дотогш, голын эргээс хоёр тийш урсгалын дагуу, булаг шандын тархины эргэн тойрны 3 км доторхи газарт хориотой бүсийн ойн хилийг татдаг бөгөөд тус аймгийн хувьд тус бүс нь хамгаалалтын бүсэд багтаж байгаа юм.

Ойн нөхөн төлжилтийг хангах ойн захаас 100 метр хүртэлх зай болон ойн цоорхойд даацаас хэтэрсэн мал бэлчээх, сэлгээгүй хадлан бэлтгэх зэргээр ой мод байгалийн жамаар үрээ хаяж, нөхөн төлжих боломжийг алдагдуулахгүй байх, ашиглалтын явцад зохистой хэмжээний төлбөр ногдуулах арга хэмжээ авбал зохино. Ойн хөнөөлт шавьж хүр эрвээхэйн өндөг ихээр тархсан газруудад устгал хийх, ойгоос их хэмжээгээр мод огтлохгүй байх зэрэг нийтлэг арга хэмжээ авахаас гадна ойн ашиглалт хамгаалалтын бүсүүдэд ашиглалтын горимыг доорхи байдлаар тогтооно.

Онцгой бүсийн ойд газар болоод байгальд сөрөг нөлөөгүй арга, хэлбэрээр судалгаа, шинжилгээний ажил явуулах, ургамал, амьтны өсч үржих нөхцөлийг хангах, хөрсийг нөхөн сэргээх, байгалийн гамшгаас учирсан хор уршгийг арилгах арга хэмжээ авахаас өөр үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

Хамгаалалтын бүсийн ойд тусгай хамгаалалттай газрын ангилал болон усны эхийг хамгаалах хориотой зурвасын ойн ашиглалтын горимоор зөвшөөрөгдсөн үйл ажиллагааг явуулна.

Ашиглалтын бүсийн ойд ойн зохион байгуулалтын судалгаа зураг төслөөр зөвшөөрөгдсөн хэмжээнд хэрэглээний мод бэлдэх боломжтой бөгөөд ойн бусад бүсүүдэд модыг хэрэглээний зориулалтаар мод бэлтгэхийг хориглоно. Үүнд орон нутгийн захиргааны зохицуулалт онцгой ач холбогдолтой юм.

Ногоон бүсэд ойн тарьц суулгац үржүүлгийн газар, ойн цоорхой, мод бэлтгэсэн талбай, ойн захаас 100 метр хүртэл өргөнтэй өвслөг ургамалт зурвас тус орно.

5.4.2. Усан сангийн газрын менежмент

Хуулийн дагуу усан сан бүхий газарт гадаргуугийн усны эзэлж байгаа газар, мөнх цас, мөсөн гол, түүнчлэн усны нөөц чанарыг хамгаалахад зайлшгүй шаардлагатай усны эрэг орчмын /усны хөвөө/ зурвас газар багтдаг.

Харин олон улсын жишгээр бол нуур, гол горхины эргийн дагуу 50 метр өргөнтэй, усархаг намгархаг газрын эргэн тойрны 100 метр өргөн зурвас газрыг усны эрэг орчмын бүс гэж зарлан түүн дээр усны нөөц, чанарт нөлөөлж болох аливаа үйл ажиллагаанд чанга хяналт тавьдаг. Мөн энэ зурваст газар хагалах, барилга байгууламж барих, орчны нөхцөл байдлыг өөрчлөх, нуур голын усанд ан амьтан чөлөөтэй хүрэх замыг алдагдуулах зэргээс аль болохоор зайлсхийдэг. /Зураг 34/

Төв аймгийн нийт голуудын урт 3120.0 км, усан сан бүхий газрын нийт талбай 14285.0 га байна. Усан сан бүхий газрын ашиглалт хамгаалалтыг зохицуулах үндсэн 2 бүсийг төлөвлөв. Үүнд:

5.4.2.1. Усны эрэг орчмын бүс

Төв аймгийн нутаг дэвсгэрийн усзүйн сүлжээ нутгийн зүүн хойт хэсэгт нилээд сайн хөгжжээ. Сүүлийн үеийн байгаль-цаг уурын өөрчлөлт, хүний үйл ажиллагааны нөлөөнөөс томоохон голуудын цутгалуудын байнгын урсгал татарч, хур тунадас ихтэй жил, эсвэл хавар шар усны үеэр устай болдог болжээ.

Голуудын усны эрэг орчмын бүсийг 50 метрээр татсан бөгөөд энэ нь нийт талбай 15600.0 га газрыг эзэлнэ. Энэ бүсэд усны нөөц, чанарт нөлөөлж болох аливаа үйл ажиллагаа болон энэ зурвас газарт газар хагалах, барилга байгууламж барих, орчны нөхцөл байдлыг өөрчлөх зэрэг үйл ажиллагаа явуулахгүй байх шаардлагатай.

5.4.4.2. Усны эрүүл ахуйн бүс:

Усан сан бүхий газрын менежментэд баримтлах гол бүсийн нэг нь усны эрүүл ахуйн бүсийг тогтоох явдал бөгөөд гол горхи, булаг шанд, худаг, усан сан нь усан хангамжийн эх үүсвэрийн үүрэг гүйцэтгэж байгаа бол тэдгээрт 100 метрээс доошгүй өргөнтэй эрүүл ахуйн бүс тогтоодог.

Тус аймгийн гадаргын усан хангамжийн эх үүсвэрт Туул гол, Хэрлэн гол, Тэрэлжийн гол, Хараа гол, Хагийн гол, Сөгнөгөрийн гол зэрэг нь голлох үүрэгтэй бөгөөд эдгээрийн усны эрүүл ахуйн бүсийг эргээс 100 метрийн зайд татлаа.

Усны эрүүл ахуйн бүсийн нийт талбай 21232.9 га бөгөөд ундны усан хангамжийн эх үүсвэр болдог гэдэг утгаар нь энэ бүсийг эрэг орчмын бүстэй нэг дэглэмээр ашиглаж хамгаалах нь зүйтэй.

5.4.4.3. Эрэг орчмын газрын ашиглалт, авах арга хэмжээ

Барилга байгууламж, жуулчны бааз, хоноглох газар нуур, голын эргээс 100 метрээс гадна байрлавал зохих бөгөөд зоо мал эмнэлгийн ариутгал-боловсруулалтын цэг, хөдөө аж ахуйн түүхий эд боловсруулах, үйлдвэрлэх газрыг усны хамгаалалтын бүсийн гадна, урсгалын доод хэсэгт байрлуулж хаягдал усыг тусгайлан цэвэрлэж зайлуулна.

Гол горхины эх, нуур, тойрмын эргэн тойронд 2км дотор ургамлыг үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахыг хуулиар хориглодог. Гол горхины эх, нуурын эргэн тойрны 5 км доторхи, голын эргээс хоёр тийш урсгалын дагуу булаг шандын тархины эргэн тойрон 3 км доторхи хөрсийг усны эвдрэлээс хамгаалах, газрын доорхи болон гадаргуугийн усны тэнцлийг хадгалах зорилгоор ойг хамгаална.

Энэ стандартын дагуу Туул гол, Тэрэлжийн гол, Сөгнөгөрийн гол зэрэг гол, булаг шандын эргэн тойрон байгаа ой бүхий газруудад хориотой зурвасыг тогтоосон болно.

5.5. Газрын хэвлий нөөцийн менежмент

Газрын хэвлийг ашиглах нь эдийн засгийн хөгжилд зайлшгүй шаардлагатай боловч байгаль орчин, газарт ихээхэн сөрөг нөлөө үзүүлдэг үйл ажиллагаа юм. /Зураг 35/

Төв аймгийн нутаг дэвсгэр нь бүхэлдээ 1:200 000 масштабын геологийн судалгаанд хамрагдаж, 1:50 000 масштабын нарийвчлалтай эрлийн ажлууд 50-60 хувьд хийгдэж, геологийн зураглал зохиогдсон байна.

Уул уурхайн үйлдвэрлэл эрчимтэй хөгжиж буй бүс нутаг нь Заамарын Өгөөмөр, Сүмбэрийн Нарст уул, Борнуурын Сүжигт, Харганат, Нарт, Мөнгөнморьтын Цагаан тал, Алтан судал, Дагналтай, Хавцал Жамбалд алт, Эрдэнэ, Зуунмодны элс, хайрга, Баяндэлгэрийн шавар, Баянгийн шохойн чулуу, Баянжаргалан, Баян, Баянцагааны жонш, Баянжаргалан, Архуст, Баянцагаан, Баянгийн Төгрөг нуурын нүүрсний уурхай зэрэг том жижиг уурхайнууд үйл ажиллагаа явуулж байна.

Тус аймгийн нутагт явуулсан геологийн судалгаагаар алт, зэс, чулуун нүүрс, шатдаг занар, хайлуур жонш, барилгын материалын бүсүүд илэрсэн бөгөөд эдгээр ашигт малтмалын илрэлийн бүсүүд дараах хэмжээтэй байдаг.

Хүснэгт 38 . Ашигт малтмалын мужлал

Д/д	Ашигт малтмалын нэр	Талбай	
		га	хувь
1	Алт	1092724.2	14.76
2	Барилгын материал	716465.9	9.68
3	Зэс	260580.06	3.52
4	Чулуун нүүрс, шатдаг занар	454397.7	6.14
5	Хайлуур жонш	343815.7	4.64
Нийт		1775259.40	24.0

Одоо ашиглаж байгаа томоохон ордуудын хувьд газрын нөхөн сэргээлтийг хийдэггүйгээс ихээхэн хэмжээний газар эвдрэлд оржээ. Тайлангаас харахад уул уурхайн тогтоогдсон нөөц бүхий үйлдвэрлэлийн ашиглалт, малталт хийх явцад эвдэрсэн газрын хэмжээ 2942.0 га бөгөөд үүнээс 187 га-д хөрс хуулалт хийсэн байна.

Одоо ашиглаж байгаа болон нөөц нь тогтоогдсон ордууд, илрэлүүдийг газрын байршлаар нь газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөнд тусгасан бөгөөд аймаг болон бүс нутгийн хөгжлийн үе шаттай нь уялдуулан ашиглахдаа ордын нөөцийг харгалзахаас гадна байгаль орчныг хамгаалах, газрыг нөхөн сэргээх асуудлыг газар эзэмших, ашиглах гэрээнд нарийн тусган хяналт тавих нь зүйтэй.

Хүснэгт 39. Нэн түрүүнд ашиглаж болох ашигт малтмалын ордууд

Д/д	Ордын нэр	Байршил	Нөөц	Хэтийн чиглэл	Үйлчлэх хүрээ
Чулуун нүүрс					
1.	Мааньт		20,5 сая тн	Эрчим хүчний үйлдвэрлэл	Бүлэг суурингийн хэмжээнд
2.	Цайдам	Баян		Эрчим хүчний үйлдвэрлэл	Бүлэг суурингийн хэмжээнд
3.	Өнжүүл	Баян-Өнжүүл		Хайгуул хийж нөөц тогтоох	Бүлэг суурингийн хэмжээнд
4.	Багануур		515,8 сая тн	Эрчим хүчний үйлдвэрлэл	Улсын хэмжээнд
5.	Баянжар галан	Баянжар галан	374,4 сая тн	Эрчим хүчний үйлдвэрлэл	Улсын хэмжээнд
6.	Хөмөлтэй	Баянжар галан		Эрчим хүчний үйлдвэрлэл	Улсын хэмжээнд
7.	Төгрөг нуур	Баян	3 млрд,тн	Эрчим хүчний үйлдвэрлэл	Улсын хэмжээнд
8.	Цайдам нуур	Бүрэн	4,4 млрд,тн	Эрчим хүчний үйлдвэрлэл	Улсын хэмжээнд
9.	Нүүрс хотгор	Баян		Эрчим хүчний үйлдвэрлэл	Улсын хэмжээнд
Шатдаг занар					

10.	Баян-Эрхэт	Баяндэл гэр	5198,8 сая тн	Эрчим хүчний үйлдвэрлэл	Бүлэг суурингийн хэмжээнд
11.	Баян жаргалан	Баян жаргалан	8120,6 сая тн	Эрчим хүчний үйлдвэрлэл	Бүлэг суурингийн хэмжээнд
Цагаан тугалга					
12.	Их сайхан	Мөнгөн морьт	30,0 тн	Олборлох үйлдвэр хөгжүүлэх	Бүлэг суурингийн хэмжээнд
13.	Мухар	Мөнгөн морьт	212,0 тн	Олборлох үйлдвэр хөгжүүлэх	Бүлэг суурингийн хэмжээнд
14.	Баяндаваа	Эрдэнэ	276,4 тн	Олборлох үйлдвэр хөгжүүлэх	Бүлэг суурингийн хэмжээнд
15.	Амфитеатро вая	Эрдэнэ	358,5 тн	Олборлох үйлдвэр хөгжүүлэх	Бүлэг суурингийн хэмжээнд
16.	Баатар	Эрдэнэ	461,7 тн	Олборлох үйлдвэр хөгжүүлэх	Улсын хэмжээнд
17.	Баруун авдрант	Эрдэнэ	297,0 тн	Олборлох үйлдвэр	Улсын хэмжээнд
18.	Авдрант	Эрдэнэ	208,0 тн	Олборлох үйлдвэр хөгжүүлэх	Улсын хэмжээнд
Гянт болд					
19.	Жанчивлан	Эрдэнэ	1009,0 тн	Олборлох үйлдвэр хөгжүүлэх	Улсын хэмжээнд
20.	Урт гозгор	Эрдэнэ	257,1 тн	Олборлох үйлдвэр хөгжүүлэх	Улсын хэмжээнд
21.	Авдрант	Эрдэнэ	310,2 тн	Олборлох үйлдвэр хөгжүүлэх	Улсын хэмжээнд
22.	Цагаан даваа	Баянчандмань	3581,0 тн	Олборлох үйлдвэр хөгжүүлэх	Бүлэг суурингийн хэмжээнд
23.	Өнгөн хайрхан	Баян-Өнжүүл	12,7 мян тн	Олборлох үйлдвэр хөгжүүлэх	Бүлэг суурингийн хэмжээнд
24.	Их хайрхан	Баян-Өнжүүл	1,5 мян тн	Олборлох үйлдвэр хөгжүүлэх	Бүлэг суурингийн хэмжээнд
25.	Хар чулуут	Баян-Өнжүүл	610,1 тн	Олборлох үйлдвэр хөгжүүлэх	Бүлэг суурингийн хэмжээнд
Алт					
26.	Тосонгийн полигон	Заамар	35,5 тн	Уул уурхайн үйлдвэрлэл хөгжүүлэх	Улсын хэмжээнд
27.	Тосонгийн гол	Заамар	313,4 кг	Уул уурхайн үйлдвэрлэл хөгжүүлэх	Улсын хэмжээнд
28.	Цагаан булаг	Заамар	998,0 кг	Уул уурхайн үйлдвэрлэл хөгжүүлэх	Улсын хэмжээнд
29.	Улаан эрэг	Заамар	188,9 кг	Уул уурхайн үйлдвэрлэл хөгжүүлэх	Улсын хэмжээнд
30.	Баян гол	Заамар	553,4 кг	Уул уурхайн үйлдвэрлэл хөгжүүлэх	Улсын хэмжээнд
31.	Баянголын полигон	Заамар	19,0 тн	Уул уурхайн үйлдвэрлэл	Улсын хэмжээнд

				хөгжүүлэх	
32.	Туул голын полигон	Заамар	63,8 тн	Уул уурхайн үйлдвэрлэл хөгжүүлэх	Улсын хэмжээнд
33.	Хайлааст	Заамар	6,3 тн	Уул уурхайн үйлдвэрлэл хөгжүүлэх	Улсын хэмжээнд
34.	Бумбат	Заамар	16,0 тн	Уул уурхайн үйлдвэрлэл хөгжүүлэх	Улсын хэмжээнд
35.	Ар наймган	Заамар	10,0 тн	Уул уурхайн үйлдвэрлэл хөгжүүлэх	Улсын хэмжээнд
36.	Хар ямаат	Жаргалант	51,0 кг	Олборлох үйлдвэр хөгжүүлэх	Улсын хэмжээнд
37.	Бороо	Бор нуур	43,0 тн	Уул уурхайн үйлдвэрлэл хөгжүүлэх	Улсын хэмжээнд
38.	Нарантолгой		8,6 тн	Олборлох үйлдвэр хөгжүүлэх	Улсын хэмжээнд
40.	Эрээн		361,0 кг	Олборлох үйлдвэр хөгжүүлэх	Улсын хэмжээнд
41.	Сүжигт	Жаргалант	975,0 кг	Олборлох үйлдвэр хөгжүүлэх	Улсын хэмжээнд
42.	Харгана	Борнуур	159,0 кг	Олборлох үйлдвэр хөгжүүлэх	Улсын хэмжээнд
43.	Тэрэлж	Мөнгөнморьт	447,0 кг	Олборлох үйлдвэр хөгжүүлэх	Улсын хэмжээнд
Хайлуур жонш					
44.	Жанчивлан	Эрдэнэ	Нөөц тооцох	Олборлох үйлдвэр хөгжүүлэх	Бүлэг суурингийн хэмжээнд
45.	Чулуут цагаан дэл	Баян	2,0 мян тн	Олборлох үйлдвэр хөгжүүлэх	Бүлэг суурингийн хэмжээнд
Давс					
46.	Баян бараат	Баян-Өнжүүл	51,0 мян,тн	Олборлох үйлдвэр хөгжүүлэх	Бүлэг суурингийн хэмжээнд
47.	Давст нуур	Дэлгэрхаан	18,9 мян,тн	Олборлох үйлдвэр хөгжүүлэх	Бүлэг суурингийн хэмжээнд
48.	Их түхэм нуур	Бүрэн	6 мян,тн	Олборлох үйлдвэр хөгжүүлэх	Бүлэг суурингийн хэмжээнд

Уул уурхайн олборлолт нь зөвхөн түүний орд газрыг сүйтгээд зогсохгүй, орчны газар, ой, усыг хүнд техникийн явалт, химийн бодисоор ихээхэн талхлан бохирдуулж нутгийн малчид болон алт олборлогчдын хооронд ихээхэн зөрчил маргаан үүсгэж, мал аж ахуй өөрсдийн унаган нутаг дэвсгэрээс шахагдахад хүрээд байна.


Иймд цаашдын газрын харилцаа болон газар зохион байгуулалтын хүрээнд Ашигт малтмалын тухай болон Газрын тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулан уул уурхайн лиценз олгохдоо орон нутгийн оролцоог нэмэгдүүлэх, нутгийн иргэдийн

саналыг авах, ашиглалтын дараахи нөхөн сэргээлтийг шаардлагын хэмжээнд хийх асуудлыг тусгах нь зүйтэй.

Ер нь Төв аймгийн газар ашиглалтын ачаалал, нутагшил суурьшлын нягтширлыг харгалзан цаашид уул уурхайн газрыг нэмж олгохгүй байх зарчмыг баримтлах шаардлагатай байна.

Мөн одоогоор олгогдсон ашиглалтын лицензийг хянан үзэж оршин суугчдын эрх ашиг болон байгаль орчинд сөргөөр нөлөөлж болох зарим зөвшөөрлийг цуцлуулах хүртэл арга хэмжээ авах бололцоотой юм.

Зураг №36



5.6. Тусгай хамгаалалттай газар болон аялал жуулчлал хөгжүүлэх газрын менежментийн бүсүүд

5.6.1.Тусгай хамгаалалттай газрын менежментийн бүс

Монгол Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн тухай хууль, тусгай хамгаалалттай газар нутгийн орчны бүсийн хууль, тусгай хамгаалалттай газар нутгийн үндэсний хөтөлбөрийн хүрээнд газар нутгийн тодорхой хэсгийг тусгай хамгаалалтанд авах нь газраар дамжуулан байгаль экологийн тэнцвэрийг хадгалахад чухал үүрэгтэй юм. /Зураг 13/

5.6.1.1. Улсын тусгай хамгаалалттай газар нутгийн газрын менежмент

Төв аймагт Хан Хэнтийн дархан газар, Горхи Тэрэлж Хустайн байгалийн цогцолборт газар, Батхаан, Нагалхааны байгалийн нөөц газрууд тус тус оршдог бөгөөд нийт нутгийн 13.5 хувь буюу 1002903.0 га газрыг эзэлнэ.

Тусгай хамгаалалттай газар нутгийн хэмжээ болон дотоод бүсчлэлийн байдлыг дараах хүснэгтэд тусгалааа. /Хүснэгт 40/

Хүснэгт 40. Улсын тусгай хамгаалалттай газрын хэмжээ ба бүсчлэл

Д/д	Тусгай хамгаалалттай газрын нэр	Талбай /га/	Дотоод бүсчлэл				
			Онгон бүс	Онцгой бүс	Аялал жуулчлалын бүс	Хамгаалалтын бүс	Хязгаарлалтын бүс
1	Богд хаан уулын дархан газар	1160.62					1160.62
2	Хан Хэнтийн дархан газар	653390.03	44490.09			170756.77	438143.17
3	Горхи-Тэрэлжийн БЦГ	296892.93		24269.97	124499.95		148123.01
4	Хустайн БЦГ	43214.94		3889.34	20311.02		19014.57
5	Батхаан БНГ	5131.49					
6	Нагалхаан БНГ	3112.98					
		1002903.00					

Төв аймгийн нутагт Хан Хэнтийн дархан газрын Онгон бүсийн А, Б хэсэг, хамгаалалтын бүс бүтнээрээ, хязгаарлалтын бүсүүд тус тус багтаж байгаа бол Богд хан уулын дархан газрын хязгаарлалтын бүсийн багахан хэсэг орно. Харин бусад тусгай хамгаалалттай газар буюу Горхи-Тэрэлжийн БЦГ, Хустайн БЦГ, Нагалхааны БНГ газрууд бүтнээрээ багтаж байгаа бол Батхааны БНГ-ын тал хувь нь тус аймгийн нутагт багтана.

Дархан газрын онгон бүсэд байгалийн унаган төрх, хэв шинжийг нь хадгалах зорилгоор байгалийн төлөв байдлыг нь хөндөхгүйгээр зөвхөн ажиглах хэлбэрээр судалгаа, шинжилгээний ажил явуулж болох бөгөөд үүнээс бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно. Харин хамгаалалтын бүсэд онгон бүсийн дэглэмээс гадна ургамал, амьтны өсч үржих нөхцлийг хангах, байгалийн гамшгаас хохирсон хор

уршгийг арилгахтай холбогдсон биотехникийн арга хэмжээг байгаль орчинд сөрөг нөлөөгүй арга хэлбэрээр явуулахыг зөвшөөрнө.

Тус газрын аялал жуулчлалын бүсэд газар, байгаль, экологи, газраас хөдлөшгүй түүх соёлын өв, газар дэлхийн гарал үүсэл, бүрэлдэн тогтолтын мэдээлэл зэрэгт хохирол учруулалгүйгээр хуулиар зөвшөөрсөн зарим үйл ажиллагааг болзолт ашиглалтын хэлбэрээр явуулах бөгөөд хадгалах-ашиглах-хамгаалах ажиллагааг хослуулан явуулах нь зүйтэй юм.

Байгалийн цогцолборт газрын онцгой бүсийн газрын менежментийн онцлог нь уг газрыг нөөшлөх замаар байгалийн унаган ландшафтын төрх, хэв шинж, информативт чанарыг хадгалан үлдээхийн зэрэгцээ тэнд нутагшсан ургамал, амьтны аймаг болон биологийн бусад төрөл зүйлийн амьдрал жам ёсоороо үргэлжлэх орон зай, орчны чиг үүрэг, нөхцлийг хангах явдал болно. Энэ бүсэд байгалийн зүй тогтлыг танин мэдэхийн үүднээс байгалийн нөөц баялгийг хөндөхгүйгээр шинжлэх ухааны ажиглалт хийх, байгалийн гэнэтийн үзэгдлээс учирсан хохирол, ургамал, амьтны аймгийн амьдралын хэвийн нөхцөлд учирсан саад, бэрхшээлийг арилгахдаа зөвхөн байгальд ивээлтэй технологи, арга хэрэгсэлээр авч явуулах шаардлагатай.

Байгалийн иж бүрдэл, биологи, түүхэн олдвор, геологийн онцлогийг харгалзан байгалийн нөөц болон байгалийн дурсгалт газруудыг төрөлжүүлэн ангилна. Энэ ангиудад горимын бүсүүдийг тогтоох шаардлагагүй бөгөөд байгалийн хэв шинж, тодорхой баялгийн төрх байдал, ургамал, амьтны аймгийн байршил, өсөлт, үржилтэд сөрөг нөлөөгүйгээр уламжлалт аж ахуй эрхлэх замаар ашиглалтын дэглэм тогтооно.

Байгалийн нөөц газарт түүний байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй барилга байгууламж барих, үйлдвэрлэлийн зориулалтаар газар ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, ан амьтан агнах, барих, мод, зэгс, шагшуурга бэлтгэх зэргээр байгалийн унаган төрхийг өөрчлөх аливаа үйл ажиллагааг хориглоно.

Байгалийн дурсгалт газарт горимын бүсүүдийг баримтлахгүй боловч байгалийн болон түүх соёлын дурсгалын зүйлсээр нь төрөлжүүлж хаалт, хашлага барих, сэрэмжлүүлсэн дохио, тэмдэг тавих, түүний хамгаалалтыг нутгийн оршин суугчдад хариуцуулах зэргээр хамгаалалтын арга хэмжээ авахаас гадна дурсгалт газар дахь байгалийн болон түүх, соёлын дурсгалт зүйлээс 0,1-3,0 км-ийн орчимд сүр бараа, үзэмжийг нь дарах барилга байгууламж барих, газар хагалах, ухах, тэсэлгээ хийх, ашигт малтмал хайх, олборлох, байгалийн болон түүх, соёлын дурсгалт зүйлийг хөндөх, эвдэх, буулгах, тэдгээрт хохирол учруулахуйц бусад үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

5.6.1.2. Орон нутгийн тусгай хамгаалалттай газар нутгийн газрын менежмент

Тусгай хамгаалттай газар нутгийн тухай хуулийн хүрээнд аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын шийдвэрээр орон нутгийн тусгай хамгаалалтанд дараах газруудыг авчээ. Үүнд:

- Говь, тал хээр хосолсон ховор тогтоц бүхий байгалийн үзэсгэлэнт газрыг хамгаалах зорилгоор Аргалант сумын нутагт Молцог элс 1155.0 га
- Аргаль угалзыг хамгаалахаар Баян-Өндөр Эрдэнэ гэдэг 7088.0 га газрыг Алтанбулаг сумын

- Цагаан зээр, хар сүүлт зэрэг анг хамгаалах болон эмчилгээний шавартай газрыг хамгаалах зорилгоор Баянцагаан суманд 24444.0 га Бумбагар, Тэрвий, Өлзийт нуур гэдэг газруудыг
- Хүдэр, тарвага зэрэг аийтдыг хамгаалах зорилгоор Батсүмбэр сумын нутагт 16467.0 га Өлгий, Өлөгтий, Нарийн гачуурт зэрэг газрууд болон 24775.0 га Бургалтай, Өртөө мухар, Худаг, Уйлант зэрэг газруудыг тус тус орон нутгийн тусгай хамгаалалтанд авчээ.
- Баянжаргалан суманд Тогос хайрханы энгэрийн хад 5 га
- Баян-Өнжүүл сумын нутагт Хундаганы рашаан 100 га
- Өндөрширээт сумын нутагт Уулын хан уул 4080 га
- Угтаалцайдам сумын нутагт Халиугчин уул 4127 га
- Жаргалант сумын нутагт Байцын дээд эх 1066 га
- Дэлгэрхаан, Эрдэнэсант сумдын нутагт Угалз хөшөөт 45454 га газрыг
- Сэргэлэн суманд Алтан хундага 10 га
- Сүмбэр сумын нутагт Хавчуу гэдэг газар 11633 га
- Архуст сумын нутагт Нарст уул 1880 га, Бөөрөлжүүтийн рашаан 370 га
- Борнуур сумын нутагт Ёл хад, Дуган хадны ам, Ар гуулинд нийт 16580 га
- Батсүмбэр сумын нутагт Бумбатай, Номт, Харуул толгой, Сайхны даваа гэдэг газруудад нийт 1080 га
- Баян-Өнжүүл суманд Харын нуур гэдэг газарт 864 га, Улхын булан 7280 га, Урд хойд Өнжүүл, Баянгийн уул ийт 22980 га, Их манхан элс 2665 га, Ар бүрдийн элс 46671 га
- Баянцагаан сумын нутагт Баруун урт 1909 га
- Баяндэлгэр сумын нутагт Харанхуй овоот 1672 га гэх мэт 24 сумын нутгийн 1161353.0 га газрыг эзэлдэг.

Төлөвлөлтөөр цаашид дараах газруудыг орон нутгийн буюу аймгийн тусгай хамгаалалтанд авахаар төлөвлөсөн бөгөөд үүнд

Түүх дурсгалын газрууд нь:

- Батсүмбэр сумын Хараагийн Ноён ууланд орших Хүннүгийн үеийн булшнууд
- Сэргэлэн сумын Баянцогт гэдэг газар орших Тонюкукийн бичигт хөшөө
- Дэлгэрхаан сумын нутагт орших Цогт тайжийн бичигтэй дуут хад, Мишиг гүний хүрээний дуганууд
- Эрдэнэ сумын Баруунбаян гэдэг газар орших Гүнжийн сүм
- Сэргэлэн сумын Зуунмодны аманд орших Манзуширийн хийдийн туурь, сийлсэн хөргүүдтэй хад
- Алтанбулаг сумын нутагт орших Өнгөтийн цогцолборт дурсгал
- Мөнгөнмоьт сумын нутагт орших Тэрэлжийн дөрвөлжин ба Бүрхийн дөрвөлжин, Сарьдагийн хийдийн туурь, Тогос уулын өвөр хажуугаар орших олон үеийн дурсгал
- Алтанбулаг сумын нутагт орших Морин толгойн олон үеийн булш
- Баянжаргалан сумын нутагт орших Гуа дов гэдэг эртний хотын туурь
- Борнуур сумын нутагт орших Хүннүгийн үеийн Бороогийн суурин
- Баянцагаан сумын Хүнхэр хонгор гэдэг газар орших 2 ширхэг хүн чулуу
- Сүмбэр сумын нутагт орших хүн чулууны цогцолбор

- Баян сумын Өгөөмөр гэдэг газар орших хүн чулуу, Багахангай, Хангайнбулаг гэдэг газар орших хүн чулуу

Аймгийн тусгай хамгаалалттай газруудад байгаль орчинд сөрөг нөлөө үзүүлэхээргүй шинжлэх ухааны ажиглалт, судалгаа явуулах, аялал зугаалга хийх, байгалийн болон түүх дурсгалыг хамгаалах арга хэмжээ авах зэрэг үйл ажиллагааг зөвшөөрөх бөгөөд зөвшөөрөлгүй аялал зугаалга хийх, газрын төлөв байдалд ноцтой нөлөөлөх технологиор ашигт малтмал олборлох, экологийн орчин болох агаар, ус, хөрсийг бохирдуулах, түүх соёлын дурсгалт зүйлийг эвдэх, гэмтээх зэрэг үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

Харин газрыг сумын тусгай хамгаалалтанд авах асуудал нь тухайн сумын засаг дарга болон иргэдийн хурлын мэдэлд байх бөгөөд хилийн цэс болон хамгаалалтын дэглэмийг иргэдийн хурлаар шийдвэрлэхэд сумдын газрын даамлын ажил үүрэгт хамрагдана.

Одоогийн байдлаар хэд хэдэн сумд газрыг сумын тусгай хамгаалалтанд авсан байдаг. Тухайлбал: Сүмбэр сум Хуц ухант, Загдал гол, Баянжаргалан сум Ерөөлт хангай, Эхэн худаг, зэрэг газруудыг бэлчээр отрын болон эмчилгээ сувилгаа, ундны ус бүхий газар гэж орон нутгийн хамгаалалтанд авсан байна.

5.6.2. Амралт, рашааны газрын бүс

Тус аймгийн нутагт улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг Өвөр Жанчивлан, Ар Жанчивлан зэрэг рашаанууд байдаг бөгөөд Бөөрөлжүүт, Тээл, Тахилт, Бүрхийн рашаан, Сүүжийн рашаан, Элгэн булаг, Далны рашаан, Мандал, Нүхэн, Цант, Оорцог, Бөгтөр нарсны, Бага төхөм, Саарал морьтын тойром, Дэвсэн булаг, Хүнхэрийн рашаан зэрэг рашаануудад нутгийн иргэд байнга ирж эмчилгээ сувилгаа хийж байна. Эдгээр рашаануудын орчимд нэгдсэн барилга сууц байдаггүйгээс иргэд өөрсдийн гэр майхан барьж байрладаг учраас жил бүр рашаа орчмын газар ихээхэн нөлөөлөлд орж, улмаар рашааны ундаргад нөлөөлдөг тул томоохон рашаануудын орчимд нэгдсэн барилга байгууламжууд барьж, хамгаалах эзэнтэй болгож төвлөрүүлэх нь чухал юм. Төв аймгийн нутагт орших рашаанууд нь Монгол орны рашааны мужлалын хувьд нүүрсхүчлийн хүйтэн рашааны мужид орших бөгөөд эмчилгээний шавар нь шаварлаг-лагийн төрөлд багтдаг.

Хүснэгт 41. Рашааны мужлал

Д/д	Мужийн нэр	Талбай	
		га	хувь
1	Азотын рашааны муж	1240577.16	16.75
2	Нүүрсхүчлийн хүйтэн рашааны муж	3897089.92	52.63
3	Бүрэн судлагдаагүй нутаг дэвсгэр	2266569.92	30.61
Бүгд		7404237.00	100.00

Зураг №37



Монгол улсын рашааны каталогид орсон рашаануудын шинж чанарыг доорхи хүснэгтэд харуулав. /Хүснэгт 42/

Хүснэгт 42. Төв аймгийн рашаануудын шинж чанар

д/д	Рашааны нэр	Орших газар	Солбицол	T ⁰ C	Анги, төрөл
1	Ар жанчивлангийн рашаан	Эрдэнэ	X47 ⁰ 41'00'', Y107 ⁰ 29'40''	2	C ^{ca}
2	Жанчивлангийн рашаан	Архуст	X47 ⁰ 36'00'', Y107 ⁰ 37'00''	5	C ^{ca}
3	Рашаангийн рашаан	Баяндэлгэр сум	X47 ⁰ 43'30'', Y108 ⁰ 07'30''	0	CCI ^{Mg}
4	Нүүрэнтгийн рашаан	Баяндэлгэр сум	X47 ⁰ 42'30'', Y108 ⁰ 17'10''	4	C ^{ca Mg}
5	Баруун Байдлагийн рашаан	Баяндэлгэр сум	X47 ⁰ 53'30'', Y108 ⁰ 17'00''	4	C ^{ca}
6	Дунд байдлын доод рашаан	Баяндэлгэр сум	X47 ⁰ 57'00'', Y108 ⁰ 22'20''	0.9	
7	Дунд байдлын дээд рашаан	Баяндэлгэр сум	X48 ⁰ 04'00'', Y108 ⁰ 11'15''	8	
8	Бүрхийн рашаан нуур	Мөнгөн морьт сум	X48 ⁰ 05'00'', Y108 ⁰ 33'00''	1	
9	Бүрхийн рашаан	Мөнгөн морьт сум	X48 ⁰ 05'00'', Y107 ⁰ 33'00''	7	C ^{ca}
10	Хонгоны рашаан	Мөнгөн морьт сум	X48 ⁰ 27'40'', Y108 ⁰ 45'20''	2	
11	Галдастайн рашаан	Эрдэнэ сум	X48 ⁰ 09'20'', Y108 ⁰ 05'00''	1.4	
12	Гутайн рашаан	Эрдэнэ сум	X48 ⁰ 10'00'', Y107 ⁰ 56'30''	3	
13	Минжийн рашаан	Мөнгөн морьт сум	X49 ⁰ 09'00'', Y108 ⁰ 05'00''	0.8	C ^{caMg}
14	Тээлийн рашаан	Угтаал цайдам	X48 ⁰ 24'40'', Y105 ⁰ 36'40''	2	C ^{Na}
15	Хайлстайн рашаан	Заамар сум	X48 ⁰ 08'00'', Y104 ⁰ 29'00''	10	
16	Дэвсэн булгийн рашаан	Эрдэнэсант сум	X47 ⁰ 10'00'', Y104 ⁰ 30'12''	3	C ^{Na}
17	Дэлгэрийн хунхарын	Эрдэнэ сант сум	X47 ⁰ 02'05'', Y104 ⁰ 30'05''	7	Cl ^{ca}

18	Саарал морьтын рашаан	Дэлгэрхаан сум	X46°41'00", Y104°26'05"	19	Cl ^{Ca}
19	Элгэнэ рашаан	Баян сум	X46°50'30", Y107°52'40"	5	Cl ^{Ca}
20	Естийн халуун рашаан	Ерөө голын сав	X48°35'55", Y107°50'45"	34	C ^{Na}
22	Бөөрөлжүүт рашаан нуур	Баян сум	X47°22'00", Y108°04'10"	3.5	C ^{CaNa}
23	Хундгана рашаан нуур	Баян-Өнжүүл сум	X46°48'00", Y106°19'30"	5	Cl ^{Na}
24	Бага төхөм, давст нуур	Дэлгэрхаан сум	X46°45'20", Y104°31'00"	8	Cl ^{Na}
25	Их төхөмийн нуур	Бүрэн сум	X46°54'30", Y104°49'00"	15	Cl ^{Na}
26	Долооны давст нуур	Дэлгэрхаан сум	X46°51'20", Y104°35'30"	8	

C^{Ca} –гидрокарбонат кальцийн ус
 C^{Na} –гидрокарбонат натрийн ус
 Cl^{Na} –хлорын ангийн натрийн ус
 Cl^{Na} –хлорын ангийн магнийн ус

Рашааны чанар, найрлага ялангуяа ууссан хийнүүд, хувирамтгай нэгдлүүдийн найрлага амархан өөрчлөгддөг учраас үндсэн шинж чанарыг өөрчлөхгүй, бохирдуулахгүйн тулд тохижилтыг сайжруулж, ариун цэврийн болон хамгаалалтын бүс тогтоох шаардлагатай. Энэхүү бүсийн хэмжээ хязгаар, хэлбэрийг усны эх булаг болон хөрсөн дэх уст давхраа оршиж буй хэсгийн ариун цэврийн нөхцөл байдал, геологийн тогтоц, гидрогеологийн шинж, хөрсний бүтэц, газар доорхи усны урсгалын чиглэл, салхины зонхилох чиглэл, бохирдлын эх үүсвэр зэргийг харгалзан байгаль орчны мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг харгалзан мэргэжлийн байгууллага тогтоох бөгөөд ариун цэврийн хамгаалалтын бүсийг дараах хэмжээг баримтлан тогтооно.

Үүнд:

- Хатуу дэглэмтэй ариун цэврийн бүс 20-50 метр
- Эрүүл ахуйн бүс 100-150 метр
- Хамгаалалтын бүс 150-500 метр байхаар тооцно.

Рашааны эрүүл ахуйн болон хамгаалалтын бүсэд дараах дэглэмийг баримтлана.

Үүнд:

- Байгалийн эмчилгээний хүчин зүйлийг ашиглахтай шууд холбоогүйгээр худаг гаргах, засварлах, рашаан түгээх, хадгалах систем, эмчилгээний шавар олборлох - байр, бусад барилга байгууламж барих
- Хог хаягдлын болон бохир ус зайлуулах байгууламж байгуулах
- Химийн хорт бодис бусад бохирдуулах зүйлсийг ил задгай хадгалах, хаях
- Байгальд сөрөг нөлөөлөл үзүүлэх үйлдвэрлэл үйлчилгээ явуулах
- Газрын хөрсийг гэмтээх, эвдрэлд оруулах

- Рашааны эргэн тойрон дахь газраас хадлан өвс бэлтгэх, мал бэлчээх
- Мөнгө болон бусад хүнд металл, хог болох зүйлийг рашаан усанд хаях
- Аливаа бохирдол үүсэх шинж чанар бүхий эм, урвалж болон химийн бодисыг хадгалах, хэрэглэх
- Төрөл бүрийн бордоо хэрэглэх ногооны талбайг байршуулах, халдварт өвчин тарааж болзошгүй зүйлс байршуулах
- Машин техник угаах газар, бохир усны нүх, бие засах газар барих гэх мэт үйл ажиллагаа явуулахыг хориглоно.

Дээрх бүстэй холбоотойгоор үйл ажиллагаа явуулж байгаа болон ашиглахаар төлөвлөж байгаа рашаан, сувиллын газруудад байгаль орчны ерөнхий болон нарийвчилсан үнэлгээг хийлгэх шаардлагатай.

Цаашид рашаануудыг хамгаалах зорилгоор тодорхой эзэмшилтэй болгож, нэгдсэн журмаар хүн хүлээн авдаг, хамгаалалтын бүсийн дэглэмтэй тогтоох нь зүйтэй юм.

Төлөвлөлтөөр аймгийн нутаг дэвсгэрт байгаа рашаануудыг түшиглэн амралтын газруудыг байршуулахаар төлөвлөсөн бөгөөд энд нийт 15 га газар төлөвлөгдсөн.

5.6.3. Аялал жуулчлалын бааз, тэдгээрийн бүс

Төв аймаг нь Монгол орны төв хэсэгт байрладаг, нийслэл хоттой ойр байдаг бөгөөд газарзүйн байрлал болон байгалийн тогтоцын хувьд байгалийн аялал жуулчлал хөгжих боломжтой ба аялал жуулчлал нилээд хөгжсөн аймгийн нэг юм. Тус аймгийн тусгай хамгаалалттай газар Хан Хэнтий, Богдхан уулын дархан газрууд болон Хустай, Горхи-Тэрэлжийн байгалийн цогцолборт газар, Нагалхаан, Батхааны байгалийн нөөц газруудыг түшиглэн аялал жуулчлал хөгжүүлэхээс гадна түүх дурсгалын олон сонин дурсгалтай тул тэдгээрийг дагуулан аялал жуулчлал хөгжүүлэх боломжтой юм. Тус аймг нь аялал жуулчлалын гол нутгийн нэг бөгөөд энд гадаад дотоодын олон жуулчид ирдэг. Томоохон төвүүдийн нэг нь Горхи-Тэрэлж орчмын Эрдэнэ сум юм. Одоогоор тус аймгийн нутагт нийт 100 гаруй жуулчны бааз үйл ажиллагааг явуулдаг бөгөөд эдгээрийн олонхи нь Борнуур, Баянчандмань, Жаргалант, Эрдэнэ сумдын нутагт тусгай хамгаалалттай газар, Туулын хөндий болон төв замын ойролцоо байрладаг. Жуулчны баазуудын нэр, байршил, хүчин чадлын талаархи мэдээллийг [хавсралтаар харуулав. /Зураг 36/](#)

Улсын Газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө болон бусад бодлогын чанартай мэдээлэлтэй уялдуулан төлөвлөлтөөр тус аймгийн нутгийн хойд болон зүүн хойд хэсэгт аялал жуулчлалыг түлхүү хөгжүүлэхээр төлөвлөсөн. Аялал жуулчлалын бүсийн хүрээнд жуулчны баазуудыг байгуулах бөгөөд дотоодын жуулчдын хувьд төлөвлөлтөд оруулсан маршрутын дагуу жуулчлах боломжтой юм. Тус аймаг нь байгалийн хэд хэдэн бүсүүдийг дамжсан байгалийн үзэсгэлэнт тогтоц газар ихтэйгээс гадна монгол улсын нийслэлтэй холбоотой түүхэн дурсгалууд ч элбэгтэй нутаг юм.

Төв аймаг нь Улаанбаатар хотыг баруун, зүүн, говийн аймгууд болон төвийн бүсийн аймгуудтай холбосон “Мянганы зам”-ын төвд байрладаг, эрчим хүчний нэгдсэн системд ихэнх сумын төвүүд холбогдсон, говь, хангай, тал хээр хосолсон, ургамал, ан амьтан элбэгтэй, чийг дулааны хангамж тэнцвэртэй байдаг, нийслэлтэй холбоотой түүх, дурсгал ихтэй зэрэг давуу талууддаа түшиглэн туул,

Хэрлэн зэрэг голуудад загас агнуурын чиглэлээр, хан Хэнтий, Горхи Тэрэлж, Хустай зэрэг тусгай хамгаалалттай газруудыг түшиглэн байгалийн аялал жуулчлал, Цогтын бичигт дуут хад болон эртний хүн чулуу, булш, сүм хийдийн туурь зэргийг түшиглэн түүхэн аялал зохион байгуулах боломжтой юм.

Цаашид төлөвлөлтөөр Сэргэлэн сумын Шавартын ам, Архуст сумын Нарстай уулын баруун, зүүн суга, Угтаалын Халиугчны гол, Сонин хангай уул, Уушиг уул, Жаргалант сумын Артолгой, Бугын ам, Буурал уул, Борнуур сумын Шаварт гол, Баянцогт сумын Алтан шивэрт, Зүүн, Баруун салаа, Хангинахын ам, Баянгол, Сөгнөгөр зэрэг газруудад шинээр жуулчны бааз төлөвлөж байгаа бөгөөд эдгээрт 120 гаруй га шаардлагатай.

Зураг №38



ЗУРГАА. ГАЗРЫН ЭКОЛОГИ-ЭДИЙН ЗАСГИЙН ҮНЭЛГЭЭ

6.1. Газрын экологийн чадавхи, түүний үнэлгээ

Байгшаль нутаг дэвсгэотйн цогцолбор нөхцлийн мужлалын хүрээнд газрын нөхцөл, нөөц, төлөв байдал, чанарыг гадаргын хотгор гүдгэр, уур амьсгал, ус зүй, хөрс ба ургамлан бүрхэвч, амьтны аймаг зэрэг байгалийн хам бүрдэл хүчин зүйлсээс хамруулан тодорхой орон зайн хүрээнд нэгтгэн ангилж, газрын менежментийн бодлогыг тодорхойлох нь илүү үр дүнтэй байдаг.

Иймээс тус аймгийн газрын экологийн чадавхийг газрыг геоэкологийн ижил төстэй нөхцлөөр нь нэгтгэсэн ландшафт-типологийн зарчимд тулгуурлан ангилж, ашиглалтыг чиглэлийг горимыг экологийн унаган чадавхийн ижил төстэй байдал, ашиглалт даах чадварт тохируулан зөвлөв.

Төв аймгийн газар нутаг нь 8 ангид хуваагдах ба ангиуд ландшафтын нөхцлөөрөө 33 дэд ангид хуваагдаж байна. Эдгээр газрууд нь байгалийн бүсийн хувьд уулын тайгаас хужир марзат нам хотос бүхий тал хөндийг хамрах ба ашиглалтын хувьд нийгмийн бүх төрлийн хэрэгцээнд тохиромжтой үржил шимт хөрстэй газраас, экологийн онцлогт тохируулан экстенсив аргаар ашиглах өргөн уудам хуурай хээр, бага хэмжээний хад асга, элсэн манханыг багтаажээ.

/Хүснэгт 43, зураг 39/

Хүснэгт 43. Төв аймгийн газрын ангилгаа

Зураг дээрх индекс	Газрын ангилал	Эзлэх талбай /га/	Ашиглалтын үндсэн чиглэл
11	Өндөр уул-уул дотоодын хавцал маягийн хөндийн нуга ба хээр	189786,1	Экологийн байдлыг алдагдуулалгүй хадгалан хамгаалах, зэрлэг ан амьтан, сарлагийн бэлчээрт ашиглана.
21	Ойт хээрийн дундаж ба нам уулс-уулсдотоодын нугачаат хөндий	448773,8	Биологийн төрөл зүйлийг хамгаалан аялал жуулчлал, амралт сувилал хөгжүүлэх, байгалийн дагалдах баялаг болох жимс, самар, эмийн ургамал зэрэгт мэргэжлийн хяналтын дор эрчимтэй бус ашиглалтыг хангуулах

22		Уулын хар хүрэн ба сулавтар хөгжилтэй хар хүрэн хөрстэй өвслөг ургамалтай чулуурхаг гадаргатай дундаж ба нам уулын орой дээд налуу хажуу	332767,1	Бүх төрлийн мал ан амьтны бэлчээрт ашиглагдана. Биологийн төрөл зүйлийг хамгаалан аялал жуулчлал, амралт сувилал хөгжүүлэхдээ мэргэжлийн хяналтын дор эрчимтэй бус ашиглалтыг хангуулах
23		Нугын гүндээ цэвдэгтэй хар шороон ба нугын хар хүрэн хөрстэй голлон сөөг оролцсон өвслөг ургамалтай дундаж уулсын хоорондохи нуга, хөндий	256707,6	Бүх төрлийн мал ан амьтны бэлчээр, боломжтой газраас хадлан бэлтгэнэ. Өрхийн тариаланд түүвэрлэн ашиглах
31		Уулын хар хүрэн ба хүрэн хөрстэй өвслөг ургамалтай дундаж ба нам уулсын хажуу налуу, хормой	784674,4	Бүх төрлийн мал ан амьтны бэлчээр ашиглана. Уулын налуу хажуугийн доод хэсгээс тариаланд түүвэрлэн ашиглах боломжтой.
32	Нугархаг хээрийн дундаж ба нам уулс-уулс хоорондын тэгшивтэр хөндий	Уулын сул хөгжилтэй ха хүрэн хөрстэй сийрэг ургамалтай чулуурхаг гадаргатай дундаж ба нам уулын орой дээд энгэр хажуу	132897,3	Бүх төрлийн мал ан амьтны бэлчээр ашиглана. Уулын налуу хажуугийн доод хэсгээс тариаланд түүвэрлэн ашиглах боломжтой.
33		Шавранцар хар хүрэн хөрстэй өвслөг ургамалтай уулс хоорондын тэгшивтэр хөндий	325853,6	Газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломжтой, бүх төрлийн малын бэлчээрт ашиглана. Хөрс хамгаалалтын арга хэмжээ авч хөрсний үржил шимийг тэтгэх, усны горимыг тохируулах
41	Хуурай хээрийн дундаж ба нам уулс-уулс хоорондын тэгшивтэр ба долгиорхог хөндий, ухаа гүвээт тал	Гүйцэт бус хөгжилтэй хүрэн ба цайвар хүрэн хөрстэй сөөг бүхий өвслөг ургамалтай ухаа гүвээт тал хөндий	839595,6	Бүх төрлийн зориулалтаар ашиглах боломжтой бөгөөд газар тариаланд ашиглахдаа хөрс хамгаалалтын арга хэмжээ авах шаардлагатай.

42		Уулын хүрэн ба сул хөгжилтэй хүрэн хөрстэй сийрэг ургамалтай чулуурхаг гадаргатай дундаж ба нам уулын орой, хажуу налуу	374380,0	Бүх төрлийн мал ан амьтны бэлчээр ашиглана
43		Шавранцар хүрэн, заримдаа хар хүрэн хөрстэй өвслөг ургамалтай уулс хоорондын ухаа гүвээт долгиорхог өргөн хөндий	1139295,2	Газар тариалангийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх боломжтой, бүх төрлийн малын бэлчээрт ашиглана. Хөрс хамгаалалтын арга хэмжээ авч хөрсний үржил шимийг тэтгэх, усны горимыг тохируулах
44		Элсэнцэр хүрэн заримдаа цайвар хүрэн хөрстэй өвслөг ургамалтай тэгшивтэр ба сулавтар долгиорхог өргөн хөндий	841930,1	Бүх төрлийн мал, ан амьтны бэлчээрт ашиглана
45		Элсэнцэр хүрэн, заримдаа цайвар хүрэн хөрстэй сөөг бүхий тэгшивтэр ба сулавтар долгиорхог өргөн хөндий	373258,4	Бүх төрлийн мал, ан амьтны бэлчээрт ашиглана, Сөөгт ургамлыг хамгаалах, эмийн ургамлыг мэргэжлийн байгууллагын хяналтын дор бэлтгэх
46		Сул бэхжсэн хөрстэй сийрэг өвслөг ургамалтай элсэн тарамцаг	72397,7	Нарийн горим тогтоож, эрчимтэй бус хэлбэрээр ашиглах. Газар нутгийн биологийн төрөл зүйлийг хамгаалах
51	Цөлөрхөг хээрийн нам уулс, цав толгодот гүвээрхэг ба тэгшивтэр хөндий	Чулуурхаг гадаргатай, цайвар хүрэн хөрстэй, сөөг бүхий сийрэг өвслөг ургамалтай нам уулсын орой, хажуу налуу	79749,9	Бүх төрлийн малын бэлчээрт ашиглах
52		Хайргархаг бор хөрстэй нам уулс, цав толгодын орой, хажуу налуу	78301,7	Бүх төрлийн малын бэлчээрт ашиглах

53		Хайргархаг гадаргатай цайвар хүрэн хөрстэй өвслөг ургамалтай гүвээрхэг ба тэгшивтэр тал хөндий	91657,7	Бүх төрлийн малын бэлчээрт ашиглах
54		Хайргархаг бор хөрстэй, сөөг бүхий өвслөг ургамалтай гүвээрхэг ба тэгшивтэр тал хөндий	123404,6	Бүх төрлийн малын бэлчээрт ашиглах
71	Бүс дундын голын хөндий болон гадагш урсгалгүй, нам хотсууд	Голын хөндий, нуурын захын аллювийн нуга-намгийн хөрстэй гидрофит ургамал бүхий нойтон нуга	65651,2	Малын бэлчээрт ашиглах, мелорацийн арга хэмжээ авсны үндсэн дэр газар тариаланд хэсэгчлэн ашиглах
72		Аллювийн нугын хээржсэн ба үелсэн сулавтар хөгжилтэй хөрст өвслөг ургамалтай татмын нуга	195459,9	Ихэнхдээ малын бэлчээрт ашиглагдах ба боломжтой газраас хэсэгчлэн газар тариалан, түүний дотроос усалгаатай тариаланд ашиглах боломжтой.
73		Аллювийн нугын хээржсэн ба үелсэн сулавтар хөгжилтэй хөрст сөөг, ширэнгэ бүхий татмын чийглэг нуга	68148,8	Ихэнхдээ малын бэлчээрт ашиглагдах ба боломжтой газраас хэсэгчлэн газар тариалан, түүний дотроос усалгаатай тариаланд ашиглах боломжтой.
74		Голын хөндий, нам хотсын хужирлаг мараалаг хээржсэн хөрстэй галофит ургамал бүхий нуга	395481,2	Малын бэлчээр, хадлан бэлтгэл
75		Хээржсэн нугын хужир, мараат хөрстэй галофит өвслөг ба сөөгт ургамалтай нам хотос	168312,9	Голлон малын бэлчээрт ашиглах ба усных үүсвэрийг харгалзан зарим хэсгийг газар тариаланд ашиглаа.
76		Уулын бэл хормойн гуу жалгын бүрдэл	13389,1	Хязгарлагдмал ашиглалттай
80		Нүцгэн газар	12363,5	Ашиглалтгүй газар

Өндөр уул-уул дотоодын хавцал маягийн хөндийн нуга ба хээр гэсэн ангид 1800-2000 метрээс дээш үнэмлэхүй өндөртэй уулсыг өндөр уул гэж үздэг бөгөөд ийм уулсыг тэдгээрийн хоорондохи гүн атриажилт бүхий 800-1000 метрийн харьцах өндөртэй, хөрсний тогтворжилт муутай, хажуугийн элэгдэлд байнга өртдөг, мөсдөлтийн үеэс үлдсэн сул асарга чулуу бүхий бүтцүүдийг хамрууллаа. Энэ ангийн газрууд Хэнтий нурууны төв хэсгийг хамрах ба Мөнгөнморьт, Эрдэнэ, Батсүмбэр сумдын ойт хээрийн бүс болон уулын тайгын бүслүүрт тархаж нийт 189786.1 га газар буюу аймгийн нутаг дэвсгэрийн 2.5 хувийг эзэлнэ.

Гадаргын тогтоцын байдал, хөрсний үржил шим, ургамлан нөмрөгийн шимт чанараасаа хамаарч, өндөр уулын таг, царам, орой, хажуу налуу болон уулс хоорондын нарийн ам хөндийнүүд нь экологийн нөхцөл, ашиглалтанд тохиромжтой байдлаар нь 4 дэд ангид хуваав. Энэ ангийн газрыг экологийн нөхцлийг нь алдагдуулалгүй хадгалан хамгаалж, зэрлэг ан амьтан, сарлагийн бэлчээрт ашиглахаас гадна аялал жуулчлал, уулын спорт хөгжүүлэхэд ашиглах нь тохиромжтой.

Мөн өндөр уулын бүс нь экологийн өвөрмөгц тогтоцыг хадгалсан, ховор нандин биологийн төрөл зүйлийг агуулсан учир шинжлэх ухааны судалгааны өндөр ач холбогдолтой бөгөөд түүний байгалийн унаган тогтоцыг хадгалан үлдээхийн тулд тусгай хамгаалалтанд авч ашиглалтыг горимлосон нь чухал ач холбогдолтой болжээ.

1500-1800 метрийн өндөртэй дундаж, 1200-1500 метрийн өндөртэй уулс, тэдгээрийн хоорондохи дунд зэргийн атираажилт бүхий уулт тогтоцыг **ойт хээрийн дундаж ба нам уулс-уулсдотоодын нугачаат хөндий** хэмээн ангилсан ба аймгийн нийт нутгийн 14.02 хувийг эзэлнэ.

Гадаргын тогтоц нь хөрсний үржил шим, ургамлан нөмрөгийн шимт чанараасаа хамаарах бөгөөд дундаж ба нам уулын орой, ар өвөр хажуу налуу ба хормой, уулс хоорондохи нуга, хөндийн экологийн нөхцөл, ашиглалтанд тохирох байдлаараа 3 дэд ангид хуваагдана. Энэхүү уулт бүтэц нь Хэнтийн нурууны үргэлжлэл болон салбар уулсын аядуу зөөлөн чийглэг сэрүүн уур амьсгалтай, өтгөн, ургац сайтай, зүйлийн бүрэлдэхүүнээр баялаг нугархаг шинжийн ургамалжилттай, хар шороон бо хар бараан хөрстэй дундаж уулсын орой, баруун ба ар хажуу налуу, хормой, уул хоорондын нарийн ам хөндийг багтаасан нэгэн цогц бүлэг газрууд юм. Уулс хоорондын нарийн хөндийд цэвдэгшлийн овойлтын дов, хүйтний хагаралтай, гадаргын болоод гүний усны хангамж сайтай, томоохон голын эхүүд энэ газруудаас үүдэлтэй.

Уулсын оргил нь тэгш хавтгай, эсвэл бөмбөгөрдүү хэлбэртэй, налуу хажуу нь алгуур, хөрс нь харьцангуй сайн тогтворжсон, үе давхаргын ялгарал сайтай, үржил шимээр сайн боловч тархалтын хувьд алаг цоог, бага талбай эзлэх учраас хөдөө аж ахуйн үйлдвэрлэлийн зориулалтаар ашиглахад үр ашиг багатай, өрхийн аж ахуй, жижиг үйлдвэрлэлийн хэрэгцээнд зориулан түүвэрлэн ашиглах боломж хэдийг ч цэвдэгшлийн нөлөөг бууруулах зорилгоор шим бордоогоор бордож хөрсний дулааны горимыг зохицуулах шаардлагатай.

Энэ ангийн газрыг экологийн нөхцлийг нь алдагдуулалгүй биологийн төрөл зүйлийг хамгаалан аялал жуулчлал, амралт сувилал хөгжүүлэх, байгалийн дагалдах баялаг болох жимс, самар, эмийн ургамлыг мэргэжлийн хяналтын дор эрчимтэй бус ашиглах, аялал жуулчлал, уулын спорт хөгжүүлэх, зэрлэг ан амьтан, бүх төрлийн малын бэлчээрт ашиглахад тохиромжтой. Нуга хөндийгөөр нь хадлан бэлтгэх, өрхийн тариаланд түүвэрлэн ашиглах боомжтой юм.

Өндөр уулын бүсийн адил экологийн өвөрмөгц тогтоцыг хадгалсан, ховор нандин биологийн төрөл зүйлийг агуулсан байдаг тул байгалийн унаган тогтоцыг хадгалан үлдээх зорилгоор тусгай хамгаалалтанд авах шаардлагатай.

Аймгийн нутаг дэвсгэрийн хойт хэсгийн ойт хээрийн бүсийн залгаанд орших завсарын бүсийн уулс, тэдгээрийн хоорондохи өргөвтөр тэгшитэр хөндий бүхий нугачаат тогтоцыг **нугархаг хээрийн дундаж ба нам уулс-уулс хоорондын тэгшивтэр хөндий** хэмээн ангилсан ба аймгийн нийт нутгийн 16.79 хувийг эзэлнэ.

Гадаргын тогтоц нь хөрсний үржил шим, ургамлан нөмрөгийн шимт чанараасаа хамаарч дундаж ба нам уулын орой, ар өвөр хажуу налуу, уулс хоорондохи тэгшивтэр хөндий гэсэн 2 дэд ангид хуваагдана.

Эндэхийн уулс нь бөмбөгөр оройтой, налуу хажуутай, хад чулуу багатай, харьцангуй сайн тогтворжсон хөрсөн бүрхэвчтэйгээс гадна уулс хоорондын хөндий нь өргөн тавиу ашиглалтанд тохиромжтойгоос гадна хөрс нь үржил шим сайтай, гол төлөв шавранцар механикийн бүрэлдэхүүнтэй учраас ашиглалт даах чадвар нь харьцангуй сайн. Харин элсэнцэр хөрс алаг цоог тааралдана.

Энэ ангийн газар агроүйлдвэрлэлийн нилээд сайн чанартай газарт тооцогддог бөгөөд бүх төрлийн мал ан амьтны бэлчээр ашиглахаас гадна уулын хормой, хөндийг тариаланд ашиглах боломжтой. Гэхдээ хөрс хамгаалалтын болон хөрсний үржил шимийг дээшлүүлэх арга хэмжээ авах шаардлагатай.

Хуурай хээрийн дундаж ба нам уулс-уулс хоорондын тэгшивтэр ба долгиорхог хөндий анги нь тус аймгийн нутаг дэвсгэрийн төв ба өмнөд хэсгээр тархаж нутаг дэвсгэрийн 37.84 хувийг эзэлнэ. Эндэхийн дундаж ба нам уулс нь хавтгай ба бөмбөгөрдүү оройтой, хажуу налуу нь ихээхэн мөлгөр, атриажилт багатай, харьцангуй сайн тогтворжсон хөнгөн механикийн бүрэлдэхүүнтэй хүрэн хөрстэй, уур амьсгал харьцангуй дулаан боловч хуурай байдаг. Үүнтэй холбоотойгоор ухаа гүвээ, толгодын орой, хажуу налуугаар гүйцэд бус хөгжилтэй хүрэн хөрстэй, нам ба дундаж уулсын хажуу налуу, хормойгоор уулын хүрэн ба уулын сулавтар хөгжилтэй хүрэн хөрс, тал хөндийгөөр нь шавранцар ба элсэнцэр хүрэн хөрс, сул бэхжсэн элсэн хөрс бүхий багахан хэсэг газар энэ ангид хамрагдана. Хүрэн хөрс нь гол төлөв бэлчээрт ашиглагддаг ба агроүйлдвэрлэлийн дунд зэргийн чанартай хөрс юм.

Усны эх үүсвэрийг түшиглэн усалгаатай тариаланг хөгжүүлэх боломжтой. Хүрэн хөрсийг ашиглахад ус чийгийн горимоос гадна хөнгөн механикийн бүрэлдэхүүнтэй учраас салхины эвдрэлээс хамгаалах арга хэмжээг эрчимтэй авах шаардлагатай.

Газрын гадаргын тогтоц, хөрсний ялгаагаараа нийт 6 дэд ангид хуваагдаж байна.

Хээрийн болон говийн бүсийг заагаар тархсан **цөлөрхөг хээрийн нам уулс, цав толгодот гүвээрхэг ба тэгшивтэр хөндийн ангид хамрагдах газрууд** нь хээрийн бүсийн хамгийн өмнөд залгаанд Баянцагаан болон Баян-Өнжүүл сумын өмнөд хил орчмын нарийн зурвас хэсэгт байрлах уулс, цав толгодоор хэрчигдсэн харьцангуй өргөн хөндийнүүдийг багтаана. Цав толгодын хоорондохи гүвээ бүхий талархаг гадарга нь өнгөндөө нилээд хайргархаг, үржил шим муутай цөлөрхөг хээрийн бор хөрстэй. Ургамлын зүйлийн бүрэлдэхүүнд монгол өвс голлосон хазаар өвс, боролзой, шаваг, баглуур, бударгана зэрэг ургамал оролцоно.

Бэлчээрийн ургац тийм ч өндөр биш боловч ургамлын шимт чанар сайтай учир малд олон талын ач холбогдолтой. Гадаргын усан хангамж муутай, харин хөрсний усны нөөц нилээд сайн учир гол төлөв худаг гаргах замаар усжуулах боломжтой. Энэ нутгийн урд захад цөлөрхөг хээр түрэн орж ирснээр хөрсөн бүрхэвчинд цайвар хүрэн хөрс голлон тархжээ.

Энэ анги нь нийт нутаг дэвсгэрийн 5.05 хувийг эзлэх бөгөөд гадаргын ба хөрс ургамлын шинж төрхөөрөө 4 дэд ангид хуваагдаж байна.

Сул бэхжсэн хөрстэй сөөг, сөөгөнцөр ба тачир сийрэг өвслөг ургамалтай сул бэхжсэн хөрстэй довцог, бөөрөг элс нь экологийн хувьд эмзэг тул хязгаарлагдмал ашиглалттай байх бөгөөд зарим ашигт ургамлыг мэргэжлийн байгууллагын хяналтын дор ашиглах, зарим хэсэгт ашиглалтаас чөлөөлж, элсний нүүлтээс сэргийлэх, хөрсжүүлэх арга хэмжээ авах нь зүйтэй. Ер нь элсэн хөрс нь тогтоц муутай учраас ашиглалтын явцад салхины нөлөөгөөр байнга зөөгдөж, байгаль экологи болон улс ардын аж ахуйд хөнөөл учруулдаг.

Байгаль нутаг дэвсгэрийн аль ч бүсэд тохиолдох газруудыг **бүс дундын голын хөндий болон гадагш урсгалгүй нам хотсуудын** ангид хамруулсан бөгөөд энэ нь аймгийн нуйтаг дэвсгэрийн 12.24 хувийг эзэлж байна.

Энэ газрын онцлог нь усны байнгын болон түр зуурын нөлөөгөөр хөрсөн бүрхэвч бага орон зайд эрс ялгаатай, ургамлан нөмрөгт чийгсүү ба давссуу ургамал зонхилдог явдал юм.

